**ГЛУПЕ'Ц**, -нца, м. (пренебр.). тэнэг хүн, мун- хаг, мангуу, ухаангүй.

**ГЛУПА'ТЬ**, -плю, -пишь; несов. (разг.). тэнэг- лэх, мунхаглах, тэнэг юм хийх, дэмий юм хийх.

**ГЛУ'ПО**, нареч. 1. тэнэгээр, тэнэг янзаар; *глупо* улыбаться тэнэг янзаар инээмсэглэх; 2. тэнэг яв- дал, бүр дэмий; *глупо* так *волноваться* из-за пу- стьяка яль шальгүй юманд ингэж сэтгэлээ зовоох бүр дэмий.

**ГЛУПОВА'ТЫЙ**, -ая, -ое; -ват, -а, -о. тэнэгдүү, тэнэгэвтэр, тэнэг шиг.

**ГЛУ'ПОСТЬ**, -и, ж. тэнэг юм, тэнэг явдал; го- ворить *глупости* тэнэг юм хэлэх; *делать* *глупость* тэнэг юм хийх.

**ГЛУ'ПЫЙ**, -ая, -ое; *глуп, глупа, глупо.* тэнэг, мунхаг, мангуу; *глупый* человек тэнэг хүн; *глупый* поступок тэнэг явдал; ☆ *глуп*, как пробка шал, тэ- нэг, уушгин тэнэг; *глуп*, как осёл үхэр шиг тэнэг, тэнэг мал; это *глупо* энэ тусгүй дээ, тэр тусгүй дээ. энэ дэмий хэрэг.

**ГЛУХА'РЬ**, -я, м. сойр (шувуу), хөх ногтруу.

**ГЛУ'ХО**, нареч. битүү, бүдэг.

**ГЛУХО'Й** -ая, -ое. *глух, глуха, глухо; глуше.* 1. дүлий, чих хатуу; *глухой* старик дүлий өвгөн 2. дүлий хүн; азбука для *глухих* дүлий хүмүүсийн үсэг; 3. дүлий хайхрамжгүй; *глухой* ко всем просьбам ха- маг гуйлгыг хайхрахгүй; 4. бүдэг, хүнгэнэх; *глухой* шум бүдэг чимээ; 5. бөглүү, буйд, зэлүүд; *глухое* место буйд газар; *глухая* улица бөглүү гудамж; 6. битүү, үүд хаалгагүй, үүд цонхгүй; *глухая* стена би- түү хана, үүд цонхгүй хэрэм; 7. далдуур, цаагуураа, битүүлгээр; *глухое* недовольство битүүлгээр дургүй- цэх; ☆ *глухое* время года жилийн хамгийн уйтгар- тай цаг, жилийн хөлгүй цаг; *глухой* согласный дуу- гүй гийгүүлэгч.

**ГЛУХОНЕМО'Й**, -ая, -ое. дүлий, хэлгүй; *глухо- немой* ребёнок дүлий хэлгүй хүүхэд.

**ГЛУХОТА'**, -ы, ж. дүлий, чих хатуу.

**ГЛУШИ'ТЕЛЬ**, -я, м. 1. чимээ намхруулагч, чимээ дарагч; 2. хавчигч; *глушитель* критики шүүмжлэл хавчигч.

**ГЛУШИ'ТЬ**, -шу, -шишь; несов., кого-что. 1. дү- лийрүүлэх, балмагдуулах, бахардуулах; *глушить* ры- бу загас балмагдуулж барих; 2. дарах, дарагдах; сорняки *глушат* сад шарилж цэцэрлэгийг дарж бай- на; 3. хавчих; хяхах; *глушить* критику шүүмжлэлийг хяхах.

**ГЛУШЬ**, -и, ж. бөглүү, буйд, зэлүүд, ширэнгэ; *лесная* *глушь* бөглүү ой, ойн ширэнгэ.

**ГЛЫ'БА**, -ы, ж. бөөнцөг, бөөн, бул, том; *камен- ная* *глыба* бул чулуу; *глыба* льда бөөн мөс.

**ГЛЮКО'ЗА**, -ы, ж. глюкоз, үзмийн чихэр, үзэмлэг.

**ГЛЯДЕ'ТЬ**, -яжу, -ядишь; *глядя; несов.* 1. харах, үзэх, шагайх; *глядеть* в окно цонхоор харах; 2. ха- рах, асрах, бөөцийлөх; *глядеть* за ребёнком хүүхэд харах, хүүхэд асрах; 3. харах, хандах; *окна* *гля- дят* на юг цонх нь урагшаа харсан. ☆ *глядеть* в оба сэрэмжтэй байх; *глядеть* косо хялайх; того и *гляди* харж байхгүй бол; *глядеть* сквозь пальцы хараагүй юм шиг байх, үл мэдэгчихэн болох.

**ГЛЯДЕ'ТЬСЯ**, *гляжусь, глядишься; несов., во что.* үзэх, харах, харагдах, тусгах; *глядеться* в зер- кало биеэ толинд харах.

**ГЛЯДЬ**, *частица.* (разг.). харан гэтэл, тэгэхнээ, нэг мэдэхнээ; *глядь*, он идёт харан гэтэл тэр явж байна.

**ГЛЯ'НЕЦ**, -нца, м. гялгар, гилгэр; *навести* *гля- нец* гялгар болгох, гялайлгах.

**ГЛЯ'НУТЬ**, -ну, -нешь (разг.). *однокр.* ширвэн харах, нүдний өнцгөөр харах, хялам хийж харах, харс- хийх.

**ГЛЯНЦЕВИ'ТЫЙ**, -ая, -ое, -ит. гилгэр, гялгар.

**ГЛЯ'НЦЕВЫЙ**, -ая, -ое. гялгар, гилгэр; *глянце- вая* бумага гялгар цаас.

**ГМ1 мөнд.** (разг.). хм, ээ дээ! (эргэлзсэн санаа).

**ГНАТЬ I**, гоню, гонишь; гнал, гнала, гнало; гонящий; гонимый; гоня; несов., кого-что. I. хөөх, үлдэх; гнать из дому гэрээс хөөх; 2. туух; гнать стадо мал туух; 3. шамдах, ярах, давхих, гүйлгэх; гнать лошадей во весь опор моринь хар хурдаар давхих.

**ГНАТЬ II**, гоню, гонишь; гнал, гнала, гнало; гонящий; гоня; несов., что. нэрэх; гнать спирт спирт нэрэх, архи нэрэх.

**ГНАТЬСЯ**, гонюсь, гонюсь; гнался, гналась; гонящийся; гонясь несов., за кем-чем. I. хөөх; нэхэх, мөрдөх; гнаться по пятам мөрдөн хөөх, 2. хөөцөлдөх; монополистууд агшийн төлөө хөөцөлдөнө; гнаться за славой алдар нэр хөөцөлдөх.

**ГНЕВ**, -а, м. хилэн, уур, унтуу; приступ гнева хилэн хүрэх, уур хүрэх, уур шатах.

**ГНЕВАТЬСЯ**, -аюсь, -аешься; несов., на кого-что (устар.). хилэгнэх, уурлах, цухалдах.

**ГНЕВНЫЙ**, -ая, -ов; -вен, -вна, -вно. хилэнт, ууртай; гневный взгляд ууртай харц.

**ГНЕДО'Й**, -ая, -ов. хээр, халтар; гнедая лошадь хээр мөр.

**ГНЕЗДИТЬСЯ**, I и 2 л. не употр., -ится; несов. I. үүрлэх; ласточки гнездятся под крышей хараацгай дээвэр дор үүрлэж байна; 2. орогнох, үүрлэх; тарханы гнездятся в щелях жоом завсар заалхайгаар нь үүрлэж байна; 3. орших, хоногших; в голове гнездились назойливые мысли толгойд өнөөх а санаа хоногшоод байлаа.

**ГНЕЗДО'**, -а, мн. гнезда, гнезд, ср. I. үүр; вить гнездо үүр засах, үүрлэх; волчьи гнезда чонын үүр; 2. үүр, бут; гнездо грушедей сархианы үүр, мөөгийн бут; 3. үүр, уурхай; гнездо заравы халдварын уурхай; 4. суурь, хаацай; пулемётные гнезда пулемётгийн хаацай.

**ГНЕЗДОВА'НИЕ**, -я, ср. үүрлэх, үүрлэн орших.

**ГНЕЗДОВО'Й**, -ая, -ов. үүрлэх, үүрэн, үүрлүүлсэн; гнездовой посев үүрэн тариага.

**ГНЕСТИ'**, гнесту, гнестшь; -тущий, прош. не употр.; несов., кого-что. дарах, зовоох; меня гнетёт тоска майаг уйтгар дарж байна.

**ГНЕТ**, -а, м. I. дарял, дарлагдал, дарлах; колоннальный гнет колонийн дарял; избавить от гнета дарлааас ангижруулах; 2. шахах, дарах; творог под гнетом тараг шахах, аарц шүүх.

**ГНЕТУЩИЙ** -ая, -ее. зовлонтой, зовнилтой, сэтгэлд эвгүй; гнетущие мысли зовнилтой бодол.

**ГНИ'ДА**, -ы, ж. хуурс, хуус

**ГНИЕ'НИЕ**, -я, ср. ялзах, үжих, өмхрөх.

**ГНИЛО'Й**, -ая, -ов; гнил, гнила, гнило. I. өмх, ялзархай, үжсэн; гнилое дерево өмх мод; 2. нойтлог, чийгээг; гнилая погода нойтлог цаг уур.

**ГНИЛОСТНЫЙ**, -ая, -ов. I. үжээх, бээлгэх, өмхийрүүлэх, өмхрөөх; гнилостные бактерии үжээх ийн; 2. өмхий, үжмэл; гнилостный запах болота балчгийн өмхий үнэр.

**ГНИЛУ'ШКА**, -и, ж. (разг.). өмх мод, өмх юм.

**ГНИЛЬ**, -и, ж. өмх, өмхий, ялзархай; гниль древесный модны өмх.

**ГНИЛЬЕ**, -я, ср. ялзарсан юм, ялзарсан хог, өмхий хог.

**ГНИТЬ**, гнию, гнишь; гнил, -ила, -ило; несов. ялзах, өмхийрөх, өмхрөх; сею гниёт өвс ялзарч байна.

**ГНОЕ'НИЕ**, -я, ср. (книжн.). идээлэх, бээрлэх. **ГНОИТЬ**, гною, гноишь; несов. өмхийрүүлэх, ялзаруулах, үжээх; гноить мясо мах өмхийрүүлэх.

**ГНОИТЬСЯ**, I и 2 л. не употр., -ится; несов. I. өмхийрөх, ялзах, идээлэх, бээрлэх; рана ещё гноится шарх бээрлэж л байна; 2. нуухдаж; глаза гноятся нүд нуухдаж байна.

**ГНОЙ**, -я, в гнобе и в гнобу, м. I. идээр, бээр из нарыва вышло много гноя идээрлэсэн газраас их бээр гарлаа; 2. нуух; гной в глазах нүдний нуух (луух).

**ГНОЙНИ'К**, -а, м. I. буглаа, бээрлэсэн газар; вскрыть гнойник буглааг хагалах; 2. архаг бузрын голомт.

**ГНОЙНЫЙ**, -ая, -ов. идээртэй, бээрлэсэн, бугласан; гнойная рана бээрлэсэн шарх.

**ГНОМ**, -а, м. анахай, үлгэрийн оодой хүн.

**ГНОСЕОЛО'ГИЯ**, -и, ж. гносеологи, мэдлэгийн онол.

**ГНУСА'ВИТЬ**, -влю, -вишь; несов. гунших.

**ГНУСА'ВОСТЬ**, -и, ж., **ГНУСА'ВЫЙ**, -ая, -ов, -ав. гуншаа.

**ГНУ'СНОСТЬ**, -и, ж. шившиг, бузар явдал, булай хэрэг; совершить гнусность шившгээ тарих, бузар явдал гаргах.

**ГНУ'СНЫЙ**, -ая, -ов; -сен, -сна, -сно. жигшүүртэй, шившигийн муу; гнусный поступок жигшүүртэй явдал.

**ГНУ'ТЫЙ**, -ая, -ов. матмал, махийсан; гнутая мебель матмал ширээ сандал.

**ГНУТЬ**, гну, гнешь; несов. I. матах, бөхийх, бөхийлгөх; гнуть проволоку төмөрлөг утсыг матах; гнуть спину нуруу бөхийх, бөхөлзөх; 2. тахилгах, нахилзуулах, бөхөлзүүлэх; бури гнёт деревья шуурга модыг бөхөлзүүлж байна.

**ГНУТЬСЯ**, гнусь, гнешься; несов. матагдах, маталзах, матайх, хотойх, хотолзох, гулзайх; гнуться под тяжестью хүнд юманд дарагдан хотойх; дерево гнётся от ветра мод салхинд гулзайж байна.

**ГНУША'ТЬСЯ**, -аюсь, -аешься; несов., кого-чего и с неопр. жигших, дур гутах, тоохгүй, тоож үзэхгүй; гнушаться лжи худлаас жигших, худал үгэнд дур гутах.

**ГОБЕЛЕ'Н**, -а, м. гобелен хивс, уран хээтэй хивс, хивсэн арава.

**ГОБО'Й** -я, м. жимбүүр.

**ГОВЕ'ТЬ**, -ею, -еешь; несов. бацаг барих, мацаг барьж мөргөл хийх

**ГО'ВОР**, -а, м. I. аман аялгуу; местный говор нутгийн аман аялгуу; 2. дуудлага, аялгуу, с нерусским говором орос биш аялгуутай; 3. ярих, хөөрөх, ярих үг; тихий говор аяархан ярих.

**ГОВОРИ'ЛЬНЯ**, -и, ж. (ирон.). чалчих газар, сул үгний танхим; буржуазная парламентская говори-льня хөрөнгөтний их хурлын чалчих газар.

**ГОВОРИТЬ** -рю, -ришь; -рёмный (-ён -ена); несов. I. хэлэх, ярих, хэл мэдэх, хэлд орох; говорить по-русски оросоор ярих; ребёнок уже говорит хүүхэд хэлд орж байна; 2. хэлэх, ярих, гэх; говорить правду үнэнийг хэлэх; говорить быстро түргэн ярих; иначе говоря өөрөөр хэлбэл; он говорит, удегт тэр явна гэж байна; 3. яригдах, хэлэлцэх, хөөрөлдөх; говорить с приятелем найзтайгаа ярилцах; 4. харуулах, үзүүлэх, гэрчлэх; этот факт говорит о многом энэ баримт олон юмыг харуулна; ☆ нечего говорить, что и говорить яриагүй, ойлгомжтой; это говорит не в вашу пользу энэ бол танд тусгүй юм болж байна; как говорят олны хэлэлцдэг ёсоор.

**ГОВОРЯТЬСЯ** *1 и 2 л. не употр., -итя;* *несов.* хэлэгдэх, яригдах, хэлэлцэх; **об** этом много говорилось энэ тухай их яригдсан; **комментарии**, как говорится энэ, излишний тайлбар хэрэггүй гэдэг шүү дээ.

**ГОВОРЛИВОСТЬ**, *-и, жс.* яримтгай, ярианд дуртай, хэлэмтгий.

**ГОВОРЛИВЫЙ** *-ая, -ое; -ив.* 1. яримтгай, ярианд дуртай; 2. дуу чимээтэй, хорчигносон; **говорливый** ручеек хоржигносон булаг.

**ГОВОРУН**, *-а, м. (разг.).* ярымгай хүн, хэлэмгий хүн, яриа хүн.

**ГОВОРУНЬЯ** *-и, жс.* ярымгай эхнэр, хэлэмгий эхнэр, яриа эмэгтэй.

**ГОВЯДИНА**, *-ы, жс.* үхрийн мах.

**ГОВЯЖИЙ**, *-оя, -ве.* үхрийн, үхрийн махан; **говяжий** жир үхрийн өөх.

**ГОГОЛЬ**, *-я, м.* нугас, шунгаач алаг; ☆ **ходить** гоголем ганган амьтан, айхтар гоё юм явах.

**ГОГОЛЬ-МОГОЛЬ**, *м.* өндгөн бантан.

**ГОГОТАНЬЕ**, *-я ср.* 1 ганганах, гангар, гунгар хийх; 2. тачигнатал инээх.

**ГОД**, *-а, мн.* *годы и годá, м.* 1. жил; **в будущем** году ирэх жил, хойт жил; **в прошлом** году ноднин жил; **год** тому назад нэг жилийн өмнө; **круглый** год бүтэн жил; **год от году** жил тутам, жил ирэх тутам; 2. он; **1917-ый** год 1917-р он; **80-ые** годы прошлого столетия өнгөрсөн зууны наяд он; **люди** сороковых годов дөчөөд оны хүмүүс; **год** издания хэвлэсэн он; 3. нас; **который** год ему? нас нь хэд вэ? хэдэн настай вэ? **молодые** годы залуу нас; он уже в годах тэр настай болж байгаа, нас нь ахиж байгаа; ☆ **без** году неделя тун саяхан.

**ГОДИНА**, *-ы, жс.* *(высок.).* цаг, үе, жилүүд; **в** тяжелую годину бэрх цагт; **година** испытаний хэцүү үе; **историческая** година түүхт жилүүд.

**ГОДИТЬСЯ**, *гожусь, годишься;* *несов.* зохих, зохилдох, таарах, хэрэг болох; **сапоги** не годятся гутал таарахгүй байна; **это** никуда не годится энэ юм юунд ч хэрэг болохгүй; **так** поступать не годится тэгж болохгүй.

**ГОДИЧНЫЙ**, *-ая, -ое.* жилийн, нэг жилийн; **годинный** доход жилийн орлого; **годинный** срок нэг жилийн хугацаа.

**ГОДНОСТЬ**, *-и, жс.* хэрэглэж болох эсэх, тохиромж, таарамж.

**ГОДНЫЙ**, *-ая, -ое; -ден, -дна, -дно.* 1. тохирох, таарах, хэрэглэж болох, болох; **годный** к военной службе нэргийн албанд тохирох; **годный** для питья ууж болох; **годный** в пищу хоолонд хэрэглэж болох; 2. хүчин төгөлдөр, хүчинтэй, хугацаатай; **билет** годен в течение двух дней билет *(пиу)* хоёр хоногийн хугацаатай.

**ГODOBАЛЫЙ**, *-ая, -ое.* нэг настай, ойндоо хүрсэн; **годовалый** ребенок ойндоо хүрсэн хүүхэд; ☆ **годовалый** ягнёнок төлөг; **годовалый** жеребёнок даага; **годовалый** телёнок бяруу; **годовалый** верблюжонок тором.

**ГODOBОЙ**, *-ая, -ое.* 1. жилийн, жил тутмын; **годовой** план жилийн төлөвлөгөө; **годовой** отчёт жилийн тайлан; **годовой** ремонт и осмотр вагонов вагоны жил тутмын засвар үзлэг.

**ГODOBЩИНА**, *-ы, жс.* ой, ойн өдөр; **годовщина** Великой Октябрьской социалистической революции Агуу их Октябрийн социалист хувьсгалын ой; **праздновать** годовщину ойн баярыг тэмдэглэх; **годовщина** свадьбы хуримын ой, гэрлэсний ой.

**ГОЛ**, *-а, м.* гол, байны хаалга; **забить** гол байны хаалганд оруулах, гол цохих *(бөмбөгөөр).*

**ГОЛЕНИШЕ**, *-а, ср.* түрвй; **головки** нандсились, а голенища совсем целые зулаг нь урагдаад түрвй нь бүтэн үлдлээ.

**ГОЛЕНЬ**, *-и, жс.* шилбэ, шаант.

**ГОЛЕЦ**, *-льцá.* м. сардиг, ян уул.

**ГОЛЛАНДЕЦ**, *-дца, м.* холланд хүн, нидерланд хүн.

**ГОЛЛАНДКА**, *1, -и, жс.* холланд эмэгтэй, нидерланд эмэгтэй.

**ГОЛЛАНДКА** II, *-и, жс.* 1. холланд үнээ; 2. холланд пийшин.

**ГОЛЛАНДСКИЙ**, *-ая, -ое.* холланд, нидерланд; **голландский** язык холланд хэл.

**ГОЛОВА**, *-ы, вин.* *голова, мн.* *головы, голова, голова́м, жс.* 1. толгой; **понури́ть** голову толгойгоо унжуулах, уруу парайлах; **надеть** на голову толгойд өмсөх; 2. толгой *(ихэнхдээ орчуулахгүй)* сто **голов** крупного рогатого скота зуун үхэр; 3. толгой, тархи, ухаан; **светлая** голова сэргэлэн толгой; **человек** с головой ухаантай хүн; 4. тэргүүн, дарга; **городской** голова хотын дарга; **он** всему делу голова тэр бүх хэргийн тэргүүн; ☆ **вбить** в голову толгойд нь шингээх; **терять** голову сандрах, самгардах; **как** снег на голову гэв гэнэт; **голова** кружится толгой эргэж байна; **ломать** голову бйлгөж ядах; **уйти** с головой в работу шургуу нэр ажиллах; **валить** с большой головы на здоровую өөрийн гэмийг бусдад тохох; **в** первую голову хамгийн түүрүүнд; **не** выходит из головы мартах аргагүй, санаанаас гарахгүй.

**ГОЛОВАСТИК** *-а, м.* 1. шанаган хорхой; 2. том толгойт.

**ГОЛОВЕШКА** *-и, жс.* цуцал.

**ГОЛОВКА**, *-и, жс.* 1. бяцхан толгой; 2. ширхэг; **головка** чеснока нэг ширхэг саримсаг; 3. тав; **головка** гвоздя хадаасны тав.

**ГОЛОВНОЙ** *-ая, -ое.* 1. толгойн; **головная** боль толгойн өвчин; 2. түрүү; **головной** отряд түрүү отряд; ☆ **головной** убор малгай.

**ГОЛОВНЯ**, *-и, род. мн.* *-ней, жс.* 1. цуцал; 2. харуу, харуутах, хар түрүү, харанцаг *(тарианы өвчик).*

**Головокруже́ние**, *-я, ср.* толгой эргэх, ташуурах; **головокружение** от успехов амжилтаас толгой эргэх, амжилтаа ташуурах.

**Головокружи́тельный**, *-ая, -ое.* толгой эргэм, толгой эргэмээр, ташуурмаар.

**ГОЛОВОЛОМКА**, *-и, жс.* зулай атируулах юм, түвэгтэй бодлого, ухааны сорилт.

**ГОЛОВОМОЙКА**, *-и, жс.* *(разг.)* сургаж загнах, загнах.

**ГОЛОВОРЕЗ**, *-а, м.* *(разг. неодобр.).* 1. танхай этгээд, төрхгүй амьтан; 2. яргачин.

**ГОЛОВОТЯП**, *-а, м.* *(разг. пренебр.).* ажиллагчаан болдог хүн, хийгчээн болооч.

**ГОЛОВОТЯСТВО**, *-а, ср.* *(разг. пренебр.).* ажиллагчаан болох, хийгчээн болох.

**ГОЛОВУШКА**, *-и, жс.*; **буйная** головушка хэцүү эр, горьгүй хүн; **бедная** моя головушка! хөөрхий болсон би!

**ГОЛОД**, *-а, м.* 1. өлсөх, өлбөрөх; **умирать** с голоду өлсөж үхэх; 2. өлсгөлөн; **голод** в колоннальных стражах колонийн орнууд дахь өлсгөлөн; **нейроложай** грезил голодом муу ургац, өлсгөлөнд хүргэх аюултай байв.

**ГОЛОДАТЬ**, *-аю, -аешь;* *несов.* өлсөх, өлбөрөх; **цельный** день голодать өдөр турш өлсөх.

**ГОЛОДАЮЩИЙ**, *-ая, -ее.* өлсөж байгаа, өлсгөдөн хүн, өлсгөдөнд нэрвэгдэгсэд.

**ГОЛОДНЫЙ**, -ая, -ое; голоден, -дна, голодно. 1. өлөн, өлссөн, өлсөх; быть голодным өлсөж байх; голодный желудок өлөн ходоод; 2. өлсгөлөн, турах, өлбөрөх, гуринхилах; голодная смерть өлбөрч үхэх, түрж үхэх; голодный волк өлөн чоно, гуринхилсан чоно; 3. өл залгах, өлөн, ховор хомс; голодная степь өлөн хээр; голодный обед өл залгах хоол.

**ГОЛОДОУВКА**, -и, ж. өлсгөлөн; объявить голодовку өлсгөлөн зарлах.

**ГОЛОЛЕДИЦА**, -ы, ж. төмөр зуд, зуд турхан, жалтиргаа.

**ГОЛОС**, -а, мн. голоса, -ов м. 1. дуу; кричать во весь голос чанга дуугаар хашгирах; возвышать голос дуугаа чангатгах; в один голос нэг дуугаар; 3. хоолой; высокий голос нарийн хоолой; низкий голос бүдүүн хоолой; 3. эрх; решающий голос таслах эрх; совещательный голос зөвлөх эрх; лишить права голоса сонгох эрхийг хасах; 4. санал; большинство голосов олонхийн саналаар; голос читателя уншигчийн санал; поднять голос саналаа шууд гаргах; с чужого голоса говорить бусдын саналыг давтах (бусдын амаар будаа идэх); голос избирателей сонгогчдын санал.

**ГОЛОСИСТЫЙ**, ая, -ое; -ист. сүрхий дуутай чанга дуутай.

**ГОЛОСИТЬ**, -ошу, -осишь; несов. уйлах, орилох, гиншин гашуудах.

**ГОЛОСЛОВНО**, нареч. баримтгүй, үндэсгүй, оргүй; утверждать голословно баримтгүй нотлох, үндэсгүй хэлэх.

**ГОЛОСЛОВНОСТЬ**, -и, ж. баримтгүй, үндэсгүй, оргүй үг.

**ГОЛОСЛОВНЫЙ**, -ая, -ое; -вен, -вна. баримтгүй, үндэсгүй, оргүй; голословное обвинение баримтгүй зэмлэх.

**ГОЛОСОВАНИЕ**, -я, ср. санал авах, санал өгөх, санал хураах, гар өргөх; всеобщее голосование нийтийн санал авах; тайное голосование нууцаар санал хураах; открытое голосование илээр санал хураах, гар өргөж таслах; поставить на голосование гар өргүүлэх, санал хураах.

**ГОЛОСОВАТЬ**, -сую, -суешь; несов. что и за кого-что, 1. санал өгөх, санал хураах; голосовать поднятием руки гар өргөж санал өгөх, гар өргүүлж санал хураах; 2. гар өргөх, гар өргөж таслах; голосовать предложение саналыг гар өргөж таслах.

**ГОЛОСОВОЙ**, -ая -ое. дууны, хоолойн; голосовые связи дууны хөвч.

**ГОЛУБЕТЬ**, 1 и 2 л. не употр., -еет; несов. цэнхэрлэн харагдах, хөхрөх; море голубеет тэнгис цэнхэрлэн харагдана.

**ГОЛУБИЗНА**, -ы, ж. хөх өнгө, цэнхэр; голубизна глаз цэнхэр нүд.

**ГОЛУБИКА**, -и, ж. нэрс.

**ГОЛУБИНЫЙ**, -ая, -ое. 1. тагтаан, тагтааны; голубиная почта тагтаан шуудан; 2. номхон, тагтаа шиг; голубиная кротость тагтаа шиг номхон.

**ГОЛУБИТЬ**, -блю, -бишь; несов., кого-что. энхрийлэх, эрхлүүлэх.

**ГОЛУБКА**, -и, ж. 1. эм тагтаа; 2. хүүхэн хонгор, хайртай хонгор.

**ГОЛУБОВАТЫЙ**, -ая, -ое. хөхөвтөр, хөхөмдөг, цэнхэр, цэгээн.

**ГОЛУБОГЛАЗЫЙ** -ая, -ое; -аз. цэнхэр нүдтэй.

**ГОЛУБОЙ** -ая, -ое. цэнхэр, хөх; голубая лента цэнхэр тууз; ☆ голубая кровь язгууртан.

**ГОЛУБОК**, -бка, м. 1. тагтаа, хүүрэгэнэ; 2. хайртай хонгор.

**ГОЛУБЦЫ**, -бв, ед. голубец, -бца, м. байцаанд ороосон шанз.

**ГОЛУБЧИК**, -а, м. (разг.). хонгор минь, чи минь.

**ГОЛУБЬ**, -я, мн. -и, -ей, м. тагтаа, хүүрэгэнэ; почтовый голубь шуудангийн тагтаа; дикий голубь хүүрэгэнэ, зэрлэг тагтаа; домашний голубь тэжээмэл тагтаа; голубь мира энх тайвны тагтаа.

**ГОЛУБЯТНИК**, -а, м. тагтаа тэжээгч.

**ГОЛУБЯТНЯ**, -и, ж. тагтааны байр.

**ГОЛУЙ**, -ая, -ое; гол, гола, голо, голы. 1. нүцгэн; голые ноги нүцгэн хөл; голое дерево нүцгэн мод; совершенно голый человек чармаа нүцгэн хүн; 2. хоосон. нүцгэн, цулгай; голая степь нүцгэн тал, хоосон тал; голая стена цулгай хана; 3. ганц л, ганцхан л, дан; голая соль дан давс; голая истина ганцхан л үнэн; голые цифры дан ганц тоо; ☆ брать голыми руками улаан гараар барих; гол как сокол гон бие гозон толгой, юу ч үгүй хоосон.

**ГОЛЫТБА**, -ы, ж. (устар.). ядуучууд, гуйлагчид.

**ГОЛЫШ**, -а, м. (разг.). нүцгэн хүн.

**ГОЛЫЕ**, -я, ср. (спец.). 1. шийр цувдай; 2. сармай (арьс).

**ГОМЕОПАТ**, -а, м. гомеопат эмч, ижил зүйлээр эмнэгч.

**ГОМЕОПАТИЧЕСКИЙ**, -ая. -ое. гомеопатийн, ижил зүйлээр эмнэх; гомеопатическая доза гомеопатийн тун.

**ГОМЕОПАТИЯ**, -и, ж. гомеопати, ижил зүйлээр эмнэх арга (эрүүл хүнд ихээр уулгавал нэг зүйл өвчин үүсгэдэг эмийг бага багаар уулгаж мөн төрлийн өвчнийг анагаах арга).

**ГОМЕРИЧЕСКИЙ**, -ая, -ое; 1-хомерийн; 2. элэг хөштөл, тачигнатал; гомерический смех элэг хөштөл инээх, тачигнатал инээх.

**ГОМОН**, -а, -м. шуугиан, дуу чимээ, шулганах, шулганаан; птичий гомон шувуу шулганах.

**ГОНГ**, -а, м. харанга; ударить в гонг харанга цохих.

**ГОНДОЛА**, -ы, ж. 1. гондол завь; 2. дүүжин сагс, өлгөө хайрцаг (агаарын бөмбөрцөгт дүүжилдэг сууц).

**ГОНЕНИЕ**, -я, ср. (книжн.). хавчих, хяхах; гонение на свободу печати хэвлэлийн чөлөөг хавчих; подвергнуться гонениям хавчигдах, хяхагдах.

**ГОНЕЦ**, -нца, м. элч, буухиа.

**ГОНИТЕЛЬ**, -я, м. (высок.). хавчигч, хяхагч.

**ГОНКА**, -и, ж. 1. хөөх, хөөцөлдөх, адгах; гонка вооружений зэвсгээр хөөцөлдөх; 2. уралдаан; ☆ задать гонку сүүлий нь мушгих.

**ГОНКИ**, мн. 1. уралдаан; гонки на короткую дистанцию богино хөлийн уралдаан, ойрын уралдаан; гонки на длинную дистанцию урт хөлийн уралдаан, холын уралдаан.

**ГОНОР**, -а, м. их зан, ихэмсэг, нэрэлхүү, тумархуу; человек с гонором их зантай хүн.

**ГОНОРАР**, -а, м. шан, шагнал, харамж; авторский гонорар зохиогчийн шагнал.

**ГОНОРРЕЯ**, -и, ж. хүйтэн өвчин, заг.

**ГОНОЧНЫЙ**, -ая, -ое. уралдааны; гоночный автомобиль уралдааны машин, уралдааны чийчээ.

**ГОНЧАР**, -а, м. ваарч.

**ГОНЧАРНЫЙ**, -ая, -ое. ваар үйлдэх, ваарын; гончарное искусство ваар үйлдэх урлаг; гончарные изделия ваарын үйлдэхүүн.

**ГОНЧАЯ**, -ей, ж. ГОНЧИЙ тайга нохой.

**ГОНЯТЬ**, -яю, -яешь; *несов.*, *кого-что*. 1. хөөх, хөөж байх, үлдэх; 2. гүйлгэх, байн байн явуулах.

**ГОНЯТЬСЯ**, -яюсь, -яешься; *несов.*, *за кем-чем*. хөөцөлдөх, хөөх.

**ГОПАК**, -а, *м.* гопак бүжиг, дэвхрэх бүжиг.

**ГОРА**, -ы, *вин.* гóру, *мн.* гóры, *гор.* -áм, *ж.* 1. уул; *жить в горах* ууланд суух, ууланд нутаглах; *взбираться на гору* уул өөд авирах; *по горам* и *по полям* уул талаар; *под горой* уулын хормойд; 2. овоо, овоолготой; **гора** *книг* овоолготой ном; **гора** *камень* овоо чулуу; ☆ *словно гора свалилась с плеч* санаа амарлаа, дотор онгойлоо; *стоять горой* бүх чадлаар өмөглөх, өмөг түшиг болох; *не за горами* удахгүй, ойрхон, төсөр болох; *идти в гору* шууд дэвших, өөдлөх; *сулить золотые горы* их олзтой гэж горьдуулах; *надеяться как на каменную гору* дамжиггүй итгэх; *пир горой* далай их хурим, идээн уул, архин далай.

**ГОРА'ЗД**, -а, -о (*прост.*) сүрхий, чадамгай; *он горазд спать* унтахдаа сүрхий.

**ГОРА'ЗДО**, *нареч.* нэн, улам, бүр, илүү, жишээгүй, хавьгүй; *гораздо ближе* жишээгүй ойр, хавьгүй ойр; *гораздо важнее* илүү чухал; *в Крыму гораздо теплее*, *чем в Москве* Крымд Москвагаас илүү дулаахан; *гораздо лучше* хавьгүй дээр.

**ГОРБ**, -á, *о горбé, на горбú, м.* бөх; ☆ *на своём горбу* испытать өөрийн биеэр амсах; *своим горбом* жить өөрийн хөдөлмөрөөр амьдрах.

**ГОРБА'ТЫЙ**, -ая, -ое; -ат. 1. бөгтөр, нуруугүй; *горбатый мост* бөгтөр гүүр; 2. монхор; **горбатый** *нос* монхор хамар.

**ГОРБИ'НКА** -и, *ж.* монхор; *нос с горбинкой* монхор хамар.

**ГОРБИТЬ**, -блю, -бишь; *несов.*, *что*. бөгцийлгөх, бөгцийх.

**ГОРБИТЬСЯ**, -блюсь, -бишься; *несов.* бөгтийх' бөгцийх; *он горбится при ходьбе* тэр бөгтийж явдаг.

**ГОРБУ'Н**, -а, *м.* бөгтөр хүн, нуруугүй, нуруу муутай хүн.

**ГОРБУ'НЯ**, -и, *ж.* бөгтөр эхнэр.

**ГОРБУ'ШКА**, -и, *ж.* талхны булан, булан талх.

**ГОРБЫ'ЛЬ**, -я, *м.* зах банз.

**ГОРДЕЛИ'ВЫЙ**, -ая, -ое; -ив. омогтой, бардам, ихэмсэг, дээрэлхэг; *горделивая осанка* бардам янзтай, ихэмсэг байдалтай.

**ГОРДЕ'ЦА**, *м.* (*неодобр*) ихэмсэг бардам, их зантай хүн.

**ГОРДИ'ТЬСЯ**, -ржусь, -рдисься; *несов.*, *кем-чем*. 1. бахархах; *гордиться* своими успехами амжилтандаа бахархах; 2. бардах, бардамнах, сайрхах; *что ты гордишься?* держись попроще чи яагаад бардамнав? зүгээр энгийн бай.

**ГОР'ДОСТЬ**, -и, *ж.* 1. бахархал, бахдал, урдаа барих юм; *национальная гордость* үндэсний бахархал; 2. бардам, омог; *обвинять кого-нибудь в гордости* хэн нэгнийг бардам гэж зэмлэх.

**ГОР'ДЫЙ**, -ая, -ое; *горд, горда, гордо*. бардан сайрхаг, омогтой; *гордый человек* бардан хүн.

**ГОР'Е**, -я, *ср.* гаслан, зовлон, гай; *случилось большое горе* их гаслан тохиолдов; ☆ *ему и горя мало* огт ажиггүй; *горе-учёный* гавихгүй эрдэмтэн.

**ГОРЕВА'ТЬ**, -рюю, -рюешь; *несов.*, *о ком-чем*. гаслах, гашуудах, зовних, шаналах.

**ГОРЕ'ЛКА**, -и, *ж.* дэн, дэнгийн толгой, дэнгийн гол, галдуур.

**ГОРЕ'ЛЫЙ**, -ая, -ое. хиншүү ханхалсан, шатанги, шатанхай, түлэнхий; *пахнет горелым* хиншүү ханхална; *горелая доска* түлэнхий банз.

**ГОРЕМЫ'КА**, -и, *м. и ж.* (*разг.*) зовлонт хүн, зол заяагүй амьтан, тульж зовсон.

**ГОРЕМЫ'ЧНЫЙ** -ая, -ое; -чен, -чна (*разг.*) зовлонт, зовж тульсан.

**ГОРЕ'НИЕ**, -я, *ср.* шатах, ноцох, асах.

**ГО'РЕСТНЫЙ**, -ая, -ое. гашуудалтай, гаслантай. **ГО'РЕСТЬ**, -и, *ж.* эмгэнэл, гаслан, зовлон; *пережить много горестей* их зовлон амсах.

**ГОРЕ'ТЬ**, -рю, -ришь; *несов.* 1. шатах; *дрова хорошо горят* түлээ сайн шатаж байна; 2. ноцох; *свеча не горит* лаа ноцохгүй байна; 3. гялалзах; *глаза горят от радости* баярлаад нүд нь гялалзах байна; 4. улайх; *щёки горят от мороза* хацар нь даараад улайж байна; *лицо горит* нүүр улайж байна; 5. халуурах, төөнөрөх; *гореть в жару* халуурах; ☆ *гореть желанием* их хүсэх; *земля горит под ногами* байх суух аргагүй болох; *не горит* яаралтай биш.

**ГОРЕ'Ц**, -рца, *м.* 1. уулын хүн, уулынхан; 2. мэхээр, тарна.

**ГОРЕ'ЧЬ**, -и, *ж.* 1. гашуу, хорсох; *горечь во рту* ам гашуу оргих; 2. уйтгар, гаслан; *горечь* *разлуки* хагацлын гаслан; *горечь* *воспоминания* гашуудалтай дурсамж.

**ГОРИЗО'НТ**, -а, *м.* 1. тэнгэрийн хаяа, тэнгэрийн хормой, хаяалбар, горизонт; *скрыться за горизонтом* тэнгэрийн хаяанд далдрах; *солнце на горизонте* нар тэнгэрийн хаяанд очив; **видимый горизонт** харагдах хаяалбар; 2. уудам газар, харааны газар, нүдний үзүүр; *с горы* открылся широкий горизонт уулан дээрээс уудам газар харагдав; 3. харц, хараа, мэдлэг; *человек с широким горизонтом* уудам харцтай хүн, их мэдлэгтэй хүн; 4. далайц; **большие горизонты** өргөн далайц.

**ГОРИЗОНТА'ЛЬ**, -и, *ж.* хэвтээ шугам, хэвтээ хямцаа, хөндлөн хаяалбар; *по горизонтали* хөндлөн.

**ГОРИЗОНТА'ЛЬНОСТЬ**, -и, *ж.* хөндлөн чиг, хэвтээ чиг.

**ГОРИЗОНТА'ЛЬНЫЙ**, -ая, -ое. хэвтээ, хөндлөн, хаяалбар; *горизонтальная линия* хэвтээ шугам;

*горизонтальная поверхность* хөндлөн гадарга.

**ГОРИ'ЛЛА**, -ы, *ж.* горил мич (*хүн төстэй сармагчин*).

**ГОРИСПОЛКО'М**, -а, *м.* (*городской исполнительный комитет*) хотын гүйцэтгэх хороо.

**ГОРИ'СТЫЙ**, -ая, -ое; -ист. уулархаг, уултай; *гористая местность* уулархаг нутаг.

**ГОР'КА**, -и, *ж.* толгой, болдог, дов.

**ГОР'КНУТЬ**, 1 и 2 л. *не употр.*, -нет; *несов.* гашуун болох, эхүүн болох, хурших; *масло горкнет в тепле* тос дулаан газарт эхүүн болно.

**ГОРКО'М**, -а, *м.* (*городской комитет*) хотын хороо; *горком* *партии* хотын намын хороо.

**ГОРЛА'Н**, -а, *м.* (*прост. неодобр.*) их дуутай хүн, бархираа эр.

**ГОРЛА'НИТЬ**, -ню, -нишь; *несов.*, (*прост.*) орилох, бархирах; *горланить на всю улицу* гудамж дүүртэл бархирах.

**ГОРЛА'СТЫЙ**, -ая, -ое; -аст (*прост.*) чанга дуутай, их дуутай, бархираа; *горластый парень* чанга дуутай хүү.

**ГОР'ЛИЦА**, -ы, *ж.* хүүрэгэнэ, хүтгээ, түүтэй.

**ГОР'ЛО**, -а, *ср.* 1. хоолой; *дыхательное горло* мөгөөрсөн хоолой; 2. хоолой; *горло Белого моря* Цагаан тэнгисийн хоолой; ☆ *кричать во все горло* өндөр дуугаар хашгирах, тэнхээ мэдэн бархирах; *быть заятым по горло* амьсгаа авах ч завгүй байх; *хватать за горло* багалзуурдах; *я сыт по горло*

бү айхтар надлаа; старт подерёк горла их саад бо-  
дох; слова востряли в горле уг амад тээглэв.

**ГОРЛОВОЙ**, -ая, -ое. хорлойн; горловая чахотка  
коодойн сурьээ; ☆ горловое венце хөөмийлөх.

**ГОРЛЫШКО**, -а, ср. хорлой, амсар, хүзүү, цор-  
го; горлышко бутылки лонхны хоолой; горлышко  
сепаратора сүүний машинын цорго.

**ГОРМО'Н**, -а, м. даавар.

**ГОРН I**, -а, м. хясаа, хяс.

**ГОРН II**, -а, м. бүрээ; играть на горне бүрээ та-  
вах.

**ГОРНИ'ЛО**, -а, ср., чего (высок.). гал дөл, аар;  
в горниле войны дайны гал дөл дотор; в горниле  
испытаний шалгалтын аар дунд.

**ГОРНИ'СТ**, -а, м. бүрээч.

**ГОРНИЦА**, -а, ж. зочдох тасалгаа.

**ГОРНИЧНАЯ**, -ой, ж. зарц өхнөр, үйлчлэгч эмэг-  
тэй.

**ГОРНОЗАВО'ДСКОЙ**, -ая, -ое. уурхайн, уул уур-  
хайн; горнозаводская промышленность уурхайн  
үйлдвэр.

**ГОРНОЛЫ'ЖНИЙ**, -ая, -ое. уулын цанцн.

**ГОРНОПРОМЫ'ШЛЕННЫЙ**, -ая, -ое. уурхайн  
үйлдвэрийн.

**ГОРНОРАБО'ЧИЙ**, -его, м. уурхайн ажилчин.

**ГОРНОСТАЙ**, -я, м. үсн.

**ГОРНЫЙ**, -ая, -ое. 1. уулын; горный воздух  
уулын агаар; горное ущелье уулын хавцал; горные  
породы уулын чулуулаг; 2. уулархаг; горная страна  
уулархаг орон; 3. уурхайн, уул уурхайн; горный  
институт уул уурхайн дээд сургууль, уурхайн инсти-  
тут; горное дело уурхайн ажил; ☆ горный хрусталь  
усан болор.

**ГОРНЯ'К**, -а, м. уурхайн, уурхайн ажилчин.

**ГОРНАЦКИЙ**, -ая, -ое. уурхайчны.

**ГОРОД**, -а, мн. -а, -ов, м. хот, балгас; главный  
город төв хот; включать в черту города хотын  
хэмжвэрнд багтаах; за город цөөхдэт хотын гадна  
гарах; за городом хотын гадна.

**ГОРОДИ'ТЬ**, -ажу, -одишь, -невоа, что (обл.).  
1. хаших, короолох, хашаа барих; городить поле  
талбайг хаших, талбайд хашаа барих; 2. донгосох;  
городить ченуху дамий донгосох.

**ГОРОДИ'ШКО**, -а, м. (разг.). хотын оронцог, хо-  
тонцог, түр.

**ГОРОДИ'ЩЕ**, -я, ср. туурь, эвдэрхий балгас,  
балгас.

**ГОРОДНИ'ЧИЙ**, -его, м. хотын дарга.

**ГОРОДОВОЙ**, -ого, м. түрүүч цагдаа.

**ГОРОДО'К**, -днд, м. бага хот, бяцхан хот, хотхон.

**ГОРОДСКОЙ**, -ая, -ое. хотын; городское насе-  
ление хотын хүн ард; городской житель хотын хүн;  
городской совет хотын зөвлөл.

**ГОРОЖА'НИЙ**, -а, мн. -әне, -ан, м. хотын хүн.

**ГОРОЖА'НКА**, -и, ж. хотын эмэгтэй.

**ГОРООБРАЗОВА'НИЕ**, -я, ср. уул тогтох.

**ГОРО'Х**, -а, м. буурцаг, вандуй; ☆ как об стену  
горох хананд будаа цацах шиг, юу ч хөлөөд нэмэр-  
гүй.

**ГОРО'ХОВЫЙ**, -ая, -ое. буурцгийн, вандуйн; го-  
роховый суд буурцгийн шөл; ☆ шут гороховый алин  
салгадай.

**ГОРО'ШЕК**, -шеа, м. буурцаг, вандуй, хорхиног;  
душистый горошек үнэрт хорхиног; зелёный горо-  
шек ногоон буурцаг.

**ГОРО'ШИНА**, -а, ж. бяцхан буурцаг.

**ГОРО'ШИНКА**, -и, ж. бяцхан буурцаг.

**ГО'РСКИЙ**, -ая, -ое. уулын, уулынхан, уулынханн;  
горские племена уулын аймгууд.

**ГОРСОВЕ'Т**, -а, м. (го родской совет) хотын  
зөвлөл.

**ГОР'СТОЧКА**, -и, ж. 1. атга, атгын чинээ; 2. хэд-  
хэн, цөөхөн.

**ГОР'СТЬ**, -и, мн. -и, -ей, ж. 1. атга; горсть муки  
атга гурил; 2. бага, цөөн, хэдхэн, цөөхөн тротой;  
горсть храбрцов хэдхэн зоригтөн, цөөн аралхэг  
хүмүүс.

**ГОРТА'ННЫЙ**, -ая, -ое. төвөнгийн, төвөнгөөр;  
гортанный звук төвөнгийн авиа.

**ГОРТА'НЬ**, -и, ж. төвөн, төвөнх.

**ГОРЧИ'ТЬ**, 1 и 2 д. не употр., -чит; несов. га-  
шуун, гашуун амттай, хурисан амттай; масло гор-  
чит тос гашуун болжээ; во рту горчит амад га-  
шуу оргино.

**ГОРЧИ'ЦА**, -ы, ж. гич.

**ГОРЧИ'ЧНИК**, -а, м. гичийн гоюу, гоюу; ставить  
горчичник гоюу тавих.

**ГОРЧИ'ЧНИЦА**, -ы, ж. гичийн сав.

**ГОРЧИ'ЧНЫЙ**, -ая, -ое. гичийн.

**ГОРШЕ'ЧНАЯ ГЛИ'НА**, -ы, ж. ваарын шавар, ваа-  
рын наанги шороо.

**ГОРШЕ'ЧНИК**, -а, м. ваарч.

**ГОРШО'К**, -шкá, м, 1. ваар, бутан, ховон; цөв-  
точный горшок цэцгийн ваар; 2. хөтөвч; ночной  
горшок хөтөвч.

**ГО'РЬКАЯ**, -ой, ж. 1. гашуун; 2. архи, хар архи;  
пить горькую архи уух.

**ГО'РЬКИЙ**, -ая, -ое; -рек, -рьяа, -рью; горчай-  
ший, -ая, -ее. 1. гашуун; горький вкус гашуун амт;  
горькое лекарство гашуун эм; 2. гашуун, гашуудал,  
гаслант, уйтгарт; горькие слёзы гашуудлын нулимс;  
горький смех гаслант инээд; 3. аягүй, хэцүүдсэн,  
зөвлонт; горькая участь зөвлонт тавилан; горькая  
истина аягүй үнэн; ☆ горький пьяница арчаагүй  
архичин; горький опыт гашуун туршдага, хял үзэх,  
хашрах.

**ГО'РЬКО**, нареч. 1. гашуун; это лекарство очень  
горько энэ эм их гашуун байна; 2. гашуудалтай; горь-  
ко думать об этом энэ тухай бодоход гашуудалтай;  
3. зөвлонтой, уйтгартай; горько на душе сэтгэл  
зөвлонтой байна.

**ГОРЮ'ЧЕЕ**, -его, ср. шатахуун; жидкое горючее  
шингэн шатахуун.

**ГОРЮ'ЧИЙ**, -ая, -ее; -юч. 1. шатамхай, шатдар,  
шатах; горючий материал шатдаг юм; горючий газ  
шатах хий; 2. шатахуун; горючего не хватило ша-  
тахуун дутаг; ☆ горючие слёзы гашуун нулимс.

**ГОРЯ'НКА**, -и, ж. уулын эмэгтэй.

**ГОРЯ'ЧЕЧНЫЙ**, -ая, -ое. халуун, халуурсан; го-  
рячечный бред халууны солжорон,

**ГОРЯ'ЧИЙ**, -ая, -ее; -яч, -á. 1. халуун; горячий  
и холодные напитки халуун хүйтэн унд; горячий  
пища халуун хоол; 2. халуун, нин сэтгэлдний; горя-  
чий привет халуун баярыг хүргээ; 3. түргэн, түргэн  
ууртай, аагтай, догшин; у него горячий характер  
тэр түргэн ууртай; 4. агсам; ☆ горячая педра ид аж-  
лын үе, толгой өндийх завгүй цаг; понасть кому-  
либо под горячую руку болдоггүй үеэр нь таарал-  
дах, ууртай байхад нь орох; по горячим следам  
халуун мөрөөр нь.

**ГОРЯЧИ'ТЬ**, -чу, -чишь; несов. 1. агсамнуулах,  
шавдах, ташуурдан шавдах; горячить лошадь морно  
агсамнуулах; 2. каламцуулах.

**ГОРЯЧИТЬСЯ**, -чусь, -чишья; *несов.* хөөрөх, уурлах, түргэдэх, унтууцах; *напрасно* горячиться дэмий уурлах.

**ГОРЯЧКА**, -и, *жс.* (*разг.*). 1. халуурах, чичрэг; 2. сандрах, сандруу цаг; горячка перед отъездом явахын өмнө сандрах; экзаменационная горячка шалгалтын сандруу цаг; ☆ белая горячка архины галзуу.

**ГОРЯЧНОСТЬ**, -и, *жс.* 1, түргэдүү, түргэн; горячность характера түргэдүү зан; 2. нармайлт, шавдуу; он с большой горячностью принялся за это дело энэ ажилд тэр их шавдуу орсон юм.

**ГОРЯЧО** *нареч.* халуун, халуунаар, чин санаанаас.

**ГОСБА'НК**, -а, *м.* (*государственный банк*) улсын банк, гүрний банк.

**ГОСБЮДЖЕ'Т**, -а, *м.* (*государственный бюджет*) улсын төсөв, улсын орлого зарлага.

**ГОСИЗДА'Г**, -а, *м.* (*государственное издательство*) улсын хэвлэлийн газар.

**ГОСПИТАЛИЗИ'РОВАТЬ**, -рую, -руешь; -анный; *сов. и несов., кого-что (спец.)*. эмнэлгэд хэвтүүлэх, хэвтүүлэн эмчлэх.

**ГО'СПИТАЛЬ**, -я, *м.* цэргийн эмнэлгийн газар; полевой госпиталь цэргийн хээрийн эмнэлгийн газар.

**ГОСПЛА'Н**, -а, *м.* (*государственный плановый комитет*) улсын төлөвлөгөөний газар.

**ГОСПОДИ'Н**, -а, *мн.* -одá, -од, -одáм. *м.* эзэн, ноён, эрхэм; господа и крепостные ноён харьяат хоёр; господин председатель ноён дарга аа! ☆ сам себе господин өөрөө өөртөө эзэн, бор гэртээ богд, хар гэртээ хаан.

**ГОСПО'ДСКИЙ**, -ая, -ое. ноёны, эзний.

**ГОСПО'ДСТВО**, -а, *ср.* ноёрхол, ноёрхох, ноёлох, зонхилох; господство на море далай дээр ноёрхох; политическое господство улс төрийн ноёрхол.

**ГОСПО'ДСТВОВАТЬ**, -твую, -твуеть; *несов.* ноёрхох, ноёлох, зонхилох; господствовать в воздухе агаарт ноёрхох.

**ГОСПО'ДСТВУЮЩИЙ**, -ая, -ее. ноёрхох, ноёлох, зонхилох; господствующий класс ноёрхогч анги; господствующая высота ноёлох өндөрлөг.

**ГОСПОЖА'**, -и, *жс.* 1. хатан, хатагтай, ноёгтой; 2. авгай.

**ГОСПРЕДПРИЯ'ТИЕ**, -я, *ср.* (*государственное предприятие*) улсын худалдаа үйлдвэрийн газар.

**ГОССТРА'Х**, -а, *м.* (*государственное страхование*) улсын даатгах газар, улсын даатгалын газар.

**ГОСТЕПРИИ'МНЫЙ**, -ая, -ое; -мен, -мна. найрсаг, элэгсэг, зочломтгой; гостеприимные люди зочломтгой хүмүүс.

**ГОСТЕПРИИ'МСТВО**, -а, *ср.* зочлон хүндлэх, зочлох, зочлол.

**ГОСТИ'НАЯ**, -ой, *жс.* зочлох тасалгаа, зочлох өрөө, зочлох танхим.

**ГОСТИ'НЕЦ**, -нца, *м.* (*обл.*) бэлэг, ёсны юм.

**ГОСТИ'НИЦА**, -и, *жс.* зочид буудал; останавливаться в гостинице зочид буудалд байрлах.

**ГОСТИ'ТЬ**, гощу, гостить; *несов.* айлчлах, зочин болох, гийчлэх.

**ГОСТРУДСВЕРКА'ССА**, -ы, *жс.* (*государственная трудовая сберегательная касса*) улсын жижиг хадгаламжийн газар.

**ГОСТЬ**, -я, *мн.* -и, -ей, *м.* аячин, гийчин, зочин, айлчлах; быть в гостях зочин болж байх; незваный гость урнагүй зочин; идти в гости айлчлах; принимать гостей зочдыг хүлээн авах; ☆ в гостях хорошо, а дома лучше айлд аятай боловч гэртээ бүр аятай.

**ГО'СТЬЯ**, -и, *жс.* эмэгтэй гийчин, зочин эмэгтэй, айлчин хүүхэн.

**ГОСУДА'РСТВЕННОСТЬ**, -и, *жс.* засаг төр, төр, гүрний.

**ГОСУДА'РСТВЕННЫЙ**, -ая, -ое. улсын, төрийн, гүрний; государственный строй төрийн байгуулал; государственные органы төрийн байгууллага; государственная власть улсын засаг; государственная независимость улсын тусгаар тогтнол; государственный флаг төрийн далбаа; государственная граница улсын хил; государственное имущество улсын хөрөнгө; государственное издательство СССР Зөвлөлт Холбоот Улсын гүрний хэвлэл.

**ГОСУДА'РСТВО**, -а, *ср.* улс, гүрэн, засаг төр, төр; СССР есть социалистическое государство раббичи и крестьян Зөвлөлт Холбоот Улс бол ажилчин тариачны социалист улс мөн; граница государства улсын хил; государство и революция төр ба хувьсгал; многонациональное государство олон үндэстнээр бүрэлдсэн улс.

**ГОСУДА'РЫНЯ**, -и, *жс.* хатан, хатагтай; милостивая государыня хүндэт хатагтай.

**ГОСУДА'РЬ**, -я, *м.* 1. хаан, 2. ноён; милостивый государь хүндэт ноён.

**ГО'ТИКА**, -и, *жс.* готик (*Баруун Европын хуучин цагийн шовх уран барилгын маяг*).

**ГОТИ'ЧЕСКИЙ**, -ая, -ое. готик, гот (*шовх хэлбэртэй*).

**ГОТОВА'ЛЬНЯ**, -и, *жс.* гортиг хэрэгсэл.

**ГОТОВИ'ТЬ**, -влю, -вишь; *несов., кого-что*. 1. бэлтгэх, бэлдэх, зэхэх; готовить кадры боловсон хүчнийг бэлтгэх; 2. бэлдэх, хийх; готовить уроки хичээл бэлдэх, хичээлээ хийх; готовить обед хоол хийх; 3. бэлтгэл хийх, бэлтгэх; готовить встречу гостям зочдыг угтах бэлтгэл хийх.

**ГОТОВИ'ТЬСЯ**, -влюсь, -вишья; *несов.* бэлтгэх, бэлдэх, бэлтгэгдэх, зэхэх, хийх, төхөөрөх; готовиться к докладу илтгэл бэлдэх; книга готовится к изданию ном хэвлэлд бэлтгэгдэж байна; готовиться к экзамену шалгалтад бэлтгэх.

**ГОТОВНОСТЬ**, -и, *жс.* бэлэн, бэлхэн, зэхээстэй; выразить готовность ехать явахад бэлнээ хэлэх.

**ГОТОВ'БЫЙ**, -ая, -ое; -ов. бэлэн, бэлхэн, бэлэн эзлэн; готовое платье бэлэн плати, бэлэн тэрлэг; обед готов хоол бэлэн; мы готовы к экзаменам бид шалгалтанд бэлэн; всегда готов хэзээд бэлхэн; будь готов бэлэн бай; готов на всё яахад ч бэлэн.

**ГОФРИРОВА'ННЫЙ**, -ая, -ое. атриатай, нугачмал; гофрированное железо атриатай төмөр.

**ГОФРИРОВА'ТЬ**, -рую, -руешь; -ованный; *сов. и несов., что (спец.)*. атриа гаргах, нугачаа гаргах, нугачмал болгох, хуниас гаргах.

**ГРАБЕЖ**, -á, *м.* тонуул, дээрэм; вооруженный грабёж зэвсэгт дээрэм.

**ГРАБИ'ТЕЛЬ**, -я, *м.* дээрэмчин, тонууль.

**ГРА'БИТЬ**, -блю, -бишь; *несов., кого-что*. дээрэмдэх, тонох.

**ГРА'БЛИ**, -бель и -блей, -блям. тармуур; конные грабли морин тармуур.

**ГРАВЁР**, -а, *м.* сийлбэрч.

**ГРАВЁРНЫЙ**, -ая, -ое. сийлбэрийн, сийлэх; гравёрное искусство сийлбэрийн урлаг.

**ГРА'ВИЙ**, -я, *м.* хайрга, хайрын чулуу.

**ГРАВИРОВА'ТЬ**, -рую, -руешь; -ованный; *несов., что*. сийлэх; гравировать на меди эсэн дээр сийлэх.

**ГРАВИРОВА'ВКА**, -и, *жс.* сийлэх, сийллэг.

**ГРАВИРОВА'ЩИК**, -а, *м.* сийлбэрч.

**ГРАВАТА'ЦИЯ**, -и, *жс.* (*спец.*) дэлхийн татаат.



**ГРАВЮ'РА**, -ы, ж. сийлбэр.

**ГРАД** I, -а, м. 1. мөндөр; выпал сильный град их мөндөр орлоо; 2. гоожих, ус шиг урсах, үргэлжлэн цувах; град пуль сум мөндөр шиг буух; град писем захидал үргэлжлэн цувах; пот льётся градом хөлс гоожих, хөлс ус шиг урсах.

**ГРАД** II, -а, м. (стар.). балгас, хот.

**ГРАДА'ЦИЯ**, -и, ж. (книжн.). шатлал.

**ГРАДОНАЧА'ЛЬНИК**, -а, м. хотын дарга, хотын тэргүүлэгч.

**ГРАДУИ'РОВАТЬ**, -рую, -руешь; -анный; сов. и несов., что (спец.). шатлах, шатлан эмжээслэх.

**ГРА'ДУС**, -а, м. градус (дугуй ба өнцгийг хэмжих нэгж); угол в шестьдесят градусов жаран градусын өнцөг; вчера было 20° мороза өчигдөр хорин градус хүйтэн байлаа.

**ГРА'ДУСНИК**, -а, м. халууны хэмжүүр, халууны шил.

**ГРА'ДУСНЫЙ**, -ая, -ое. градуст, хуваарт, градусын; градусное изхерение градусын хэмжил.

**ГРАЖДАНИ'Н**, -а, мн. *гражданин, гражданин*, м. 1. иргэн, харьяат; гражданин Советского Союза Зөвлөлт Холбоот Улсын иргэн; 2. хүн, нөхөр, эрхэм; неизвестный гражданин пришел наг танихгүй хүн ирсэн; гражданин! постойте! ай нөхөөр! зогсоорой!

**ГРАЖДАНКА**, -и, ж. 1. эмэгтэй иргэн, харьяат эмэгтэй; 2. авгай.

**ГРАЖДАНСКИЙ**, -ая, -ое. иргэний, ард иргэний; гражданский долг иргэний үүрэг; гражданские права ард иргэний эрх; гражданский кодекс иргэний хууль; гражданская война иргэний дайн; гражданская служба иргэний алба; ☆ гражданское население ард иргэн, хүн ард, хүн ам.

**ГРАЖДАНСТВО**, -а, ср. 1. харьяат, иргэн; приняты советское гражданство Зөвлөлтийн харьяат болох, Зөвлөлтийн иргэн болох; 2. сайшаагдах, зөвшөөрөгдөх, нийгэд дэлгэрэх; получить права гражданства олонд сайшаагдах, нийгэд дэлгэрэх.

**ГРАММ**, -а, род. мн. -ов, м. грамм (хэмжээс); сто граммов зуун грамм.

**ГРАММА'ТИКА**, -и, ж. хэл зүй, хэлний зүй; морфология и синтаксис являются частями грамматики хэлбэр зүй, өгүүлбэр зүй бол хэл зүйн хэсэг болно.

**ГРАММАТИЧЕСКИЙ**, -ая, -ое. хэл зүйн; грамматические ошибки хэл зүйн алдаа; грамматический строй хэл зүйн байгуулал.

**ГРАММОФОН**, -а, м. эгшигт хайрцаг, граммафон.

**ГРА'МОТА**, -ы, ж. 1. бичиг, бичиг үсэг, ном; обучаться грамоте бичиг заалгах, ном заалгах, бичиг үсэг сурах; 2. жуух, үнэмлэх; почётная грамота хүндэт жуух; верительная грамота итгэмжлэх жуух.

**ГРА'МОТНО**, нареч. зүгээр, эвтэйхэн, учир мэдэх байдалтай.

**ГРА'МОТНОСТЬ**, -и, ж. 1. бичиг мэдэх, бичиг мэдэх явдал; всеобщая грамотность нийтээр бичиг мэдэх болох; распространение грамотности в стране бичиг мэдэх явдал тус оронд дэлгэрэх; 2. алдаагүй, зөв зүйтэй, мэдлэг, чадмаг; политическая грамотность төрийн бодлогын мэдлэг.

**ГРА'МОТНЫЙ**, -ая, -ое; -тен, -тна. 1. бичиг мэдэх, бичиг үсэг мэдэх; грамотный человек бичиг мэдэх хүн; 2. алдаагүй, алдаа мадаггүй, зөв; грамотное письмо алдаагүй бичиг; 3. чадмаг, мэдэх сайтай, мэдлэгтэй; грамотный инженер чадмаг инженер; 4. зөв сайн, сайн хийгдсэн; вполне грамотная работа нэлээд сайн хийгдсэн ажил.

**ГРАНА'Т**, -а, м. анар, сэмбэрүү.

**ГРАНА'ТА**, -ы, ж. гранат, бөмбөг; ручная граната гар бөмбөг.

**ГРАНДИО'ЗНЫЙ**, -ая, -ое; -зен, -зна. лут, агуу их, асар их; грандиозное здание лут барилга; грандиозные замыслы асар их санаархал.

**ГРАНЁННЫЙ**, -ая, -ое. засмал, талстай, цамцаалтай; гранёный стакан талстай шилэн аяга.

**ГРАНИ'Т**, -а, м. боржин; набережная облицована гранитом голын эрэг боржингоор хөвөөлөгджээ.

**ГРАНИ'ТНЫЙ**, -ая, -ое. боржин; гранитная глыба бөөм боржин, гүнтгэр боржин; гранитная ступень боржин гишгүүр.

**ГРАНИ'ТЬ**, -ню, -нишь; несов., что. талс гаргах, цамцаал гаргах; цамцааллах; гранить алмаз алмас цамцааллах.

**ГРАНИ'ЦА**, -ы, ж. 1. хил; государственная граница улсын хил; 2. хязгаар, хэмжээ; нашей радости не было границ бидний баярласан нь хязгааргүй байлаа; выйти из границ приличия зохих хэмжээнээс хэтрэх; ☆ за границей хилийн цаана, гадаадад.

**ГРАНД'ЧИТЬ**, 1 и 2 л. не употр., -чит; несов. с чем. 1. хил залгах, зах нийлэх; СССР на юге граничит с Ираном Зөвлөлт улс өмнө зүгтэй Ирантай хил залгадаг; 2. нийлэх, адилсах ойртох, хүрэх; его мастерство граничит с искусством түүний чадвар урлагт ойртоно.

**ГРА'НКА**, -и, ж. өрдөс; исправлять сочинение в гранках зохиолыг өрдөс дээр засах; гранка рассыпалась өрдөс задарчихав.

**ГРАНЬ**, -и, ж. 1. талс, цамцаал; у кубы шесть граней шоо дөрвөлжинд зургаан талс бий; 2. зааг, хязгаар, ирмэг, даваа; на грани смерти үхэхийн даваан дээр.

**ГРАФ**, -а, м. гүн (хэргэм).

**ГРАФА'**, -ы, ж. хүснэг.

**ГРАФ'ИК**, -а, м. 1. хуваарь; график движения поездов галт тэрэг явах хуваарь; 2. зурмаг, хүснэг; производственный график үйлдвэрлэлийн зурмаг.

**ГРА'ФИКА**, -и, ж. 1. зураас (будаггүй шугам зураг); 2. үсгийн дүрс; русская графика орос үсгийн дүрс.

**ГРАФИ'Н**, -а, м. галуун хүзүүт лонх, бутан.

**ГРАФИ'НЧИК**, -а, м. жижиг лонх.

**ГРАФИ'НЯ**, -и, ж. гүнгийн хатан, хатан.

**ГРАФИ'Т**, -а, м. бал чулуу.

**ГРАФИ'ТНЫЙ**, -ая, -ое., **ГРАФЛ'ТОВЫЙ**, -ая -ое бал чулуун.

**ГРАФИ'ТЬ**, -флю, -фишь; несов., что. хүснэгдэх, хүснэг татах.

**ГРАФИ'ЧЕСКИЙ**, -ая, -ое. зурмал, зураасан зургийн; графическое искусство зураасан зургийн урлаг.

**ГРАФЛЕ'НИЕ**, -я, ср. хүснэг татах, шугам татах.

**ГРАФЛЁННЫЙ**, -ая, -ое. хүснэг татсан, шугамтай, шугам татсан; графлёная бумага шугамтай цаас.

**ГРА'ФСКИЙ**, -ая, -ое. гүнгийн.

**ГРА'ФСТВО**, -а, ср. 1. гүнгийн хэргэм; 2. гүнгийн харьяат газар, гүндлэг.

**ГРАЦИО'ЗНО**, нареч., **ГРАЦИО'ЗНЫЙ**, -ая, -ое; -зен, -зна. гунхсан, гунхалзуур, гунхалзах; грациозная девушка гунхсан хүүхэн; грациозный танец гунхалзах бүжиг.

**ГРА'ЦИЯ**, -и, ж. гунхах, гунхалзах.

**ГРАЧ**, -а, м. хар туруу (тороо), хар хэрээ, турлааг.

**ГРЕБЁНКА**, -и, ж. 1. сам; расчесать волосы гребёнкой самаар үс самнах; 2. дэржингүүр (зам); ☆ стричь всех под одну гребёнку тэгшлэн засах, бүгдийг нэг загвартай болгох.

**ГРЕ'БЕНЬ**, *-бня, м.* 1. сам; частый гребень шигүү сам; 2. хяр, хянга; гребень горы уулын хяр; 3. залаа, цацаг; петушиный гребень тахнаны залаа, 4. цохно, сэрвэн; нуруу; гребень волны долгионы нуруу.

**ГРЕБЕ'Ц**, *-бца, м.* сэлүүрч, сэлбүүрч.

**ГРЕБЕШО'К**, *-шка, м.* 1. бяцхан сам; 2. залаа, цацаг; петушиный гребешок тахнаны залаа.

**ГРЕ'БЛЯ**, *-и, ж.* сэлүүрдэх, сэлбүүрдэх; парная гребля хосоор сэлүүрдэх.

**ГРЕБНО'Й**, *-ая, -ое.* сэлүүрийн, сэлүүрт, сэлэх; гребная лодка сэлүүрт завь.

**ГРЕЗА', -ы, ж.** сэтгэл зүүдний бодол, мөрөөдөл, хүсэл.

**ГРЕ'ЗИТЬ**, *гребжу, гребись; несов.* санагалзах, сэтгэл зүүдэндээ бодох, мөрөөдөх.

**ГРЕ'ЗИТЬСЯ**, *гребжусь, гребисься; несов.* сэтгэлд ургах, сэтгэл зүүдэнд орох.

**ГРЕК**, *-а, м.* грек, эллин хүн.

**ГРЕ'ЛКА**, *-и, ж.* хөлчлөг, халуун жин.

**ГРЕМЕ'ТЬ**, *-млю, -мишь; несов.* 1. нижигнэх, нирхийх, хангинах, дуугарах; гром гремит тэнгэр дуугарч байна; гремели выстрелы буун дуу нижигнэв; 2. алдарших, дуурсах, шууртах; слава о нём гремит алдар нэр нь дуурсаж байна.

**ГРЕМУ'ЧИЙ**, *-ая, -ее.* 1. тэсрэмтгий; гремучий газ тэсрэмтгий хий; 2. хоржигнуурт; гремучая змея хоржигнуурт могой.

**ГРЕ'НА**, *-ы, ж.* (спец.) хүр хорхой.

**ГРЕНАДЕ'Р**, *-а, м.* гренадер, өндөр биетэй цэрэг.

**ГРЕНКИ'**, *-ков, ед. -нок, -нка, м.* хайрсан хатаамал (*малх*).

**ГРЕСТИ' I**, *гребу, гребёшь; грёб, гребла; несов.* сэлүүрдэх, сэлбүүрдэх.

**ГРЕСТИ' II**, *гребу, гребёшь; грёб, гребла; несов., что чел.* тармах, хамах, овоолох.

**ГРЕТЬ**, *грею, греешь; гретый; несов.* 1. шарах, дулаацуулах; солнце греет нар шарж байна; шуба греет дээл дулаацуулж байна; 2. ээх, хөлчих, дулаацуулах; греть руки гар хөлчих, гараа ээх; греть ноги хөлөө дулаацуулах; 3. халаах; греть воду ус халаах; греть пищу хоол халаах; ☆ (*перен.*) греть руки гар дүрэх, завших.

**ГРЕ'ТЬСЯ**, *греюсь, греешься; несов.* дулаацах, ээх; греться на солнце наранд ээх; греться у огня галд дулаацах.

**ГРЕХ**, *-а, м.* нүгэл, хилэнц; ☆ с грехом пополам чуу чамай гэж, арай чүү гэж; как на грех гай болоход, гай болж; нечего греха таить гэм зэмээ нуулгүй, нүглээ нуулгүй; водится за ним один грех түүнд нэг гэм бий.

**ГРЕХО'ВНЫЙ**, *-ая, -ое; -вен, -вна (устар.).* нүгэлт, нүгэлтэй, хилэнцтэй.

**ГРЕ'ЦКИЙ**, *-ая, -ое.* грецкий орех хушга.

**ГРЕЧА'НКА**, *-и, ж.* грек эмэгтэй, грек хүүхэн.

**ГРЕ'ЧЕСКИЙ**, *-ая, -ое.* грек; греческий язык грек хэл.

**ГРЕЧИ'ХА**, *-и, ж.* сагаг, сагадай.

**ГРЕЧИ'ШНЫЙ**, *-ая, -ое.* сагагийн, сагагайн.

**ГРЕ'ЧНЕВЫЙ**, *-ая, -ое.* сагадайн; гречневая крупа сагадайн будаа, гурвалжин будаа; гречневая каша сагадайн зуган, сагадайн агшаамал.

**ГРЕШИ'ТЬ**, *-шу, -шишь; несов.* 1. хилэнц үйлдэх, нүгэл хийх; 2. зөрчих, алдаа гаргах, эндүүрэх, будлих; грешить против грамматики хэл зүйн алдаа гаргах; грешить против логики логикийн эсрэг будлих.

**ГРЕ'ШНИК**, *-а, м. (устар.).* нүгэлтэй хүн, нүгэлтэн.

**ГРЕ'ШНЫЙ**, *-ая, -ое; -шен, -шна, грешно, грешны (устар.).* нүгэлтэй, хилэнцтэй; ☆ грешным делом гэмээ хэлэхэд, нуулгүй хэлэхэд.

**ГРЕШО'К**, *-шка, м.* бяцхан нүгэл, нүгэлхэн, гэм.

**ГРИБ**, *-а, м.* мөөг; бельй гриб цагаан мөөг; гриб маслёнок шар хусандай мөөг; гриб подберезовик барэгар хусандай мөөг; гриб подосиновик салбан хусандай мөөг; гриб рыжик амтат сархиаг мөөг; собирать грибы мөөг түүх; расти как грибы мөөг шиг хурдан ургачхах.

**ГРИБКО'ВЫЙ**, *-ая, -ое.* мөөгөнцрийн.

**ГРИБНО'Й**, *-ая, -ое.* мөөгтэй, мөөгний; грибной суп мөөгний шөл; грибное место мөөгтэй газар; ☆ грибной дождь зүс бороо, зөөлөн хур.

**ГРИБО'К**, *-бка, м.* 1. бяцхан мөөг; 2. мөөгөнцөр.

**ГРИ'ВА**, *-ы, ж.* дэл, зогдор; конская грива адууны дэл; львиная грива арслангийн зогдор.

**ГРИ'ВЕННИК**, *-а, м.* арван мөнгө.

**ГРИМ**, *-а, м.* нүүр будах, нүүрийн будаг, энгэсэг.

**ГРИМА'СА**, *-ы, ж.* ярвайх, ярвалзах, урвалзах, нүүрээ татгануулах.

**ГРИМА'СНИК**, *-а, м. (разг.).* уравгануур, яравгануур.

**ГРИМА'СНИЧАТЬ**, *-аю, -аешь; несов.* уравганах, яравганах.

**ГРИМЁР**, *-а, м. (спец.).* нүүр будагч.

**ГРИМИРОВА'ТЬ**, *-рую, -руешь; -ованный; несов., кого-что.* нүүр будах.

**ГРИМИРОВА'ТЬСЯ**, *-рюсь, -руешься; возвр.* нүүрээ будах.

**ГРИМИРО'ВКА**, *-и, ж.* нүүрээ будах.

**ГРИП'П**, *-а, м.* томуу, ханиад; болеть гриппом ханиад хүрэх.

**ГРИППО'ЗНЫЙ**, *-ая, -ое.* томууны, ханиадны, ханиадаар; гриппозное воспаление лёгких ханиадаар уушиг үрвэсэх.

**ГРИФ I**, *-а, м.* 1. тас, нөмрөг тас; 2. гардилаг.

**ГРИФ II**, *-а, м.* 1. сийлдөр үсэг; 2. гарын тийз; 3. чавхдаст хөгжмийн баруул.

**ГРИ'ФЕЛЬ**, *-я, м.* чулуун үзэг.

**ГРИ'ФЕЛЬНЫЙ**, *-ая, -ое.* занар, чулуун; грифельная доска чулуун самбар, занар самбар.

**ГРОБ**, *-а, о гробе, в гробу, мн.-ы, -ов, м.* 1. авс; 2. үхлүүд, үхэх; глядеть в гроб үхлүүд болсон; свести в гроб үхэхэд хүргэх; верность до гроба үхтэл үнэнч.

**ГРОБНИ'ЦА**, *-ы, ж. (книжн.).* бунхан

**ГРОБОВО'Й**, *-ая, -ое.* авсны; ☆ до гробовой доски үхтлээ; гробовое молчание дув дугай болцгоох; гробовая тишина чив чимээгүй болцгоох.

**ГРОБОВЩИ'К**, *-а, м.* авсчин.

**ГРОЗА'**, *-ы, мн. гробы, гроз, ж.* 1. аадар, ширүүн бороо, аянгатай бороо; разразилась гроза ширүүн бороо оров; 2. айхтар юм, аянга, аюулт амьтан; он был грозой нашего района тэр бол манай нутгийн аюулт амьтан нь байлаа.

**ГРОЗДЬ**, *-и, мн. грозди, род. п. гроздей и гроздь, род. п. гроздьев, ж.* хонгорцог; гроздь винограда үзмийн хонгорцог.

**ГРОЗИ'ТЬ**, *грозжу, грозись; несов.* 1. заных, заналхийлэх, сүрдүүлэх, далайлгах; грозить пальцем шалуун дүрсгүй хүүг хуруугаар заных; грозить разрывом сална гэж далайлгах; 2. аюул тулгарах, аюул учрах, магадгүй, гэж байх, аюултай болж мэдэх; ему грозила гибель түүнд үхлийн аюул тулгарч байв; дом грэзит обвалом байшин нурж магадгүй байна, байшин нурах гэж байна; эта болезнь грозит опас-

костью для жизни энэ өвчин амнид аюуштай болж мэднэ.

**ГРОЗИТЬСЯ**, *грожусь, грозишься; несов. (разг.)* занаж зүхэх, сүрдүүлэн занаж.

**ГРО'ЗНО**, *нареч.* айхтар, догшин, сүртэй, ууртайгаар.

**ГРО'ЗНЫЙ**, *-ая, -ое; -зен, -зна, -зно.* 1. айхтар, аюуштай, аймшигтай; грозный час аюуштай цаг; грозная сила аймшигт хүч; грозный взгляд айхтар харц; 2. догшин, сүртэй, ширүүн; грозный человек ширүүн хүн; грозный правитель догшин захирагч.

**ГРОЗОВО'Й**, *-ая, -ое.* аянгатай борооны, эзарган борооны, аюуштай; грозовая туча аянгатай борооны ууц.

**ЖА'ЛКО, безл., в знач. сказ.** 1. хайрлаж өрөвдөлтэй, өрөвдөм, хөөрхийлмөөр; он жалко выглядел тэр (хүн) өрөвдмөөр харагдав; 3. хайран (байх), харамсалтай (байх), өрөвдөлтэй байх, хайрлалтай (байх), хөөрхийлөлтэй (байх); жалко денег хайран мөнгө; жалко что он не пришѣл түүний ирээгүй нь харамсалтай байна; жалко бабушку эмэг ээж хайрлалтай байна.

**ЖА'ЛО, -а, ср.** хатгуур, хэл; пчелиное жало зөгийн хатгуур.

**ЖА'ЛОБА, -ы, жс.** 1. гомдол, үглэх, зовуурь; жалобы на одиночество ганцаараа гэж үглэх, ганцаардаж байна гэж үглэх; жалобы больного өвчтөний зовуурь; 2. гомдол, зарга; бюро жалоб гомдлын товчоо; подавать жалобу гомдол мэдүүлэх, зарга мэдүүлэх.

**ЖА'ЛОБНО, нареч.** гашуудалтай, гаслантай, гунигтай, өрөвдмөөр, гомдолтой.

**ЖА'ЛОБНЫЙ, -ая, -ое; -бен, -бна.** 1. гомдлын, заргын; жалобная книга гомдлын дэвтэр; 2. гашуудалтай, гаслантай, гунигтай, өрөвдмөөр, гомдолтой, хөөрхийлмөөр; жалобный вой гунигтай улих; жалобный писк хөөрхийлмөөр гангинах.

**ЖА'ЛОБЩИК, -а, м.** гомдол гаргагч, гомдол мэдүүлэгч, гомдогч.

**ЖА'ЛОВАНЬЕ, -я, ср.** пүнлүү, цалин.

**ЖА'ЛОВАТЬ, -люю, -луешь; несов.** 1. хайрлах, хайр хүртээх, шан хүртээх, хишиг хүртээх; 2. хайхрах, үнэлэх, хүндлэх; его там не очень жалуют түүнийг тэнд төдий л хайхардаггүй юм; 3. морилж саатах, заларч ирэх; редко к нам жалует манайд хааяа морилж саатдаг.

**ЖА'ЛОВАТЬСЯ, -луюсь, -луешься; несов.** 1. гомдох, үглэх, (өвдөж байна) гэх; жаловаться на нездоровье бие муу гэх, бие муу гэж үглэх; 2. гомдол, мэдүүлэх, заалдах, зарга барих; жаловаться в суд шүүхэд заалдах.

**ЖА'ЛОСТЛИВЫЙ**, -ая, -ое; -ив (разг.). өр нимгэн, аяраңгүй, зөөлөн сэтгэлтэй; жалостливая женщина зөөлөн сэтгэлтэй эмэгтэй.

**ЖА'ЛОСТНЫЙ**, -ая, -ое; -тен, -тна (разг.). 1. өрөвч, өрөвдсөн (ялзтай), хөөрхийлсөн (маягтай); жалостное выражение лица өрөвдсөн ялзтай царай; 2. гашуудалтай, гаслантай, өрөвдөм, хөөрхийдмөөр; жалостная песня гашуудалтай дуу.

**ЖА'ЛОСТЬ**, -и, жс. 1. өрөвдөх сэтгэл, хөөрхийлөл; хайр; вызывать жалость өрөвдөх сэтгэл төрүүлэх; 2. харамсалтай (байх), харамсах, хайрлах; какая жалость! юутай харамсалтай вэ!

**ЖАЛЬ**, 1. безл., в знач. сказ., кому-чему кого-что или с неопр. 1. хайрлалтай (байх), өрөвдөлтэй (байх), хөөрхийдөлтэй (байх); жаль смотреть на него түүнийг харахад өрөвдөлтэй; 2. безл., в знач. сказ., кому-чему, кого-чего или с неопр. хар буух, хайран (байх); жаль напрасну расходовать деньги мөнгө дэмий зарцуулах хайран байна; 3. безл., в знач. сказ., кому-чему с союз. зами, что, если или без них. харамсалтай (байх); жаль, если дело не удасться хэрэг бүтэхгүй бол харамсалтай байна; 4. вводн. слово. харамсалтай нь, харамсах нь; поесть-то здесь, жаль, нечего харамсалтай нь энд идчимээр ч юм алга.

**ЖАНДА'РМ**, -а, м. харгис цагдаа.

**ЖАНДАРМЕ'РНИЯ**, -и, жс. харгис цагдаагийн анги, харгис цагдан сэргийлэх.

**ЖАНР**, -а, м. 1. төрөл зүйл; лирический жанр утга уянгын төрөл зүйл; 2. ахуй байдлын зураг; 3. маяг, янз, зан төрх; в новом жанре шинэ маягийн, шинэ янзаар.

**ЖАР**, -а, о жары, в жару, мн. не употр., м. 1. халуун; обдать жаром халуу оргих; идти в самый жар ид халуунд явах; 2. цог, улаан цог, улаан нурам; загрести жар в печи пийшингийн улаан нурам хамах; 3. халуун, бүлээн; у ребёнка жар хүүхэд бүлээнтэй байна; 4. хөөрөх, нүүр халуу оргих, царай улайх; его бросило в жар нүүр нь халуу оргив; 5. омог, хав, ид; работать с жаром хавтай ажлалах; ☆ чужими руками жар загребать хүний гараар гал шилээх, хүний гараар могой барих.

**ЖАРА'**, -и, жс. халуун, ид халуун, пүү халуун.

**ЖАРГО'Н**, -а, м. этгээд хэл; жаргон торговцев наймаачны этгээд хэл.

**ЖА'РЕНЬЕ**, -я, ср. шарах, шаралт. ●

**ЖА'РЕННЫЙ**, -ая, -ое. шарсан, хуурсан, хайрсан; жареное мясо шарсан мах.

**ЖА'РИТЬ**, -рю, -ришь; несов., кого-что. 1. шарах, хуурах, хайрах; жарить курицу тахна шарах; жарить семечки үр хуурах; 2. цоргих, шарах; солнце жарит нар цоргиж байна; 3. цоргитол халаах, улайсгах; нельзя так жарить печь пийшинг ингэтэл халааж болохгүй.

**ЖА'РИТЬСЯ**, -рюсь, -ришься; несов. 1. шарагдах, хуурагдах, хайрагдах; 2. ээх, шарагдах; жариться на солнце наранд шарагдах, наранд ээх.

**ЖАРИ'ЩА**, -и, жс. (разг.). аагим халуун, цоргисон халуун.

**ЖА'РКИЙ**, -ая, -ое; -рок, -рка, -рко; жарче' 1. халуун, аагим халуун; жаркий день халуун өдөр; 2. халуун, тачаалтай, ширүүн; жаркий спор ширүүн маргалдаан; 3. халуун, халуун орны; жаркие страны халуун орон.

**ЖА'РКО**, нареч. 1. халуун, халуунаар, халтал; солнце жарко грело нар халтал шарж байв; 2. ширүүн; жарко обсуждать ширүүн хэлэлцэх; 3. халуун байх; сегодня жарко өнөөдөр халуун байна.

**ЖАРКО'Е**, -ого, ср. шарсан мах.

**ЖАРО'ВНЯ**, -и, жс. хоовон.

**ЖАРОПОНИЖА'ЮЩИЙ**, -ая, -ев. халуун дарах; жаропонижающее средство халуун дарах эм.

**ЖАР'ЦГИ'ЦА**, -ы, жс. гэрэлт шувуу (орос үлгэрт гардаг шувуу).

**ЖАСМИ'Н**, -а, м. мэлрэг, малига.

**ЖА'ТВА**, -ы, жс. 1. тариа хадах, тариа хадалт; 2. тариа хадах цаг, тариа хадалт; до жатвы не долго ждаты удахгүй тариа хадах цаг болно; 3. хадсан тариа, ургац; обильная колхозная жатва хамтралын элбэг баян ургац; 4. арвин оло.

**ЖА'ТВЕННЫЙ**, -ая, -ое. тариа хадах; жатвенная машина тариа хадах машин.

**ЖА'ТКА**, -и, жс. (тарианы) хадуур машин.

**ЖАТЬ** I. жму, жмёшь; несов., кого-что. 1. хавчих, атгах; жать руку гарыг атгах; 2. шахах; түрэх; жать противника к реке дайсныг голд шахах; 3. барих, хавчих; сапог жмёт ногу гутал хөл барьж байна; 4. шахах, дарах; жать виноград усан үзэм шахах.

**ЖАТЬ** II, жму, жмёшь несов., что. хадах; жать пшеницу улаан буудай хадах.

**ЖА'ТЬСЯ**, жемусь, жёмьсья; несов. 1. бөгцийх, бээцийх, атирах; жаться от холода даарч бээцийх; 2. наалдах, шахагдах; жаться к матери эхдээ наалдах; 3. нарийлах, нарийндаа хатах; жмётся да деньги копил нарийндаа хатсаар мөнгө хуримтлуулна.

**ЖБАН**, -а, м. хуу.

**ЖВА'ЧКА**, -и, жс. хивдэс, хивэг, сэвс; жевать жвачку хивдэс хивэх.

**ЖВА'ЧНЫЙ**, (жвачное) -ая, -ое. хивдэг амьтан.

**ЖГУТ**, -а, м. чангалуур, эрээс, мушгимал, гөрцөл; томмол; соломенный жгут мушгимал сүрэл.

**ЖГУ'ЧЛЫЙ**, -ая, -ев; жгуч. 1. шатам халуун, цоргисон халуун; жгучий воздух цоргисон халуун агаар; 2. төөнөрсөн, хоргосон, хайрган; жгучий холод хайрган хүйтэн; 3. тэсгэлгүй, халуун, хорсолтой; жгучий стыд тэсгэлгүй ичих; ☆ жгучий вопрос өнөөдрийн чухал асуудал; жгучий брюнет тас хар үстэй хүн.

**ЖДАТЬ**, жеду, ждёшь, ждал, ждала, ждало; несов. 1. хүлээх; ждаты друзей нөхдөө хүлээх; ждаты поезда галт тэрэг хүлээх; 2. горьдох, найдах, санах; ждаты награды шагнал горьдох; 3. бодох, санах, харах; ждаты бури шуурга болно гэж санах; ждали, что он будет хорошим поэтом түүнийг сайн яруу найрагч болно гэж харж байв; ☆ того и жди юу юугүй; ждаты не дожидаться хүлээж ядах, тэсч ядан хүдээх; ждаты у моря погоды гараа эвхэн суух.

**ЖЕ** I, союз. 1. харин, гэтэл. орчуулахгүй ч завар тохиолдоно; 2. тэгээд.

**ЖЕ** II, частица. 1. л, л даа (дээ, доо, дөө), даа (дээ, доо, дөө), тэгээд; 2. л, мөн.

**ЖЕВА'ТЕЛЬНЫЙ**, -ая, -ое. зажлах, зажладаг, зажлуурын; жевательный табак зажлах тамхи; жевательные мышцы зажлуурын булчин.

**ЖЕВА'ТЬ** жуу, жуёшь; жевальный; несов., что. зажлах, хивэх, бувар бувар хийх, бувганах.

**ЖЕЗЛ** I, -а, м. очир, очирт таяг; маршалский жезл маршалын очир, өрлөгийн счир.

**ЖЕЗЛ** II, -а, м. (прост.). (төмөр замын) очир.

**ЖЕЛА'НИЕ**, -я, ср. хүсэл, дур, хүслэн, таалал; желание уехать явах хүсэл, явахыг хүсэх; исполнение желаний хүслээ хангах; гореть желанием хүслэн болох; по желанию хүслээрээ, дураараа.

**ЖЕЛАННЫЙ**, -ая, -ое. 1. хүссэн, хүсч байсан, хүсэл болсон; желанный гость хүсч байсан зочин; 2. хүсэх мэт; желанный друг хүссэн нөхөр.

**ЖЕЛАТЕЛЬНО**, *безл., в знач. сказ., с неопр. и с союзом „чтобы“ (книжн.)*. 1. хүсэх, зохих, хэрэгтэй (*байх*); деньги желательно получить до отъезда мөнгийг явахын урьд авахыг хүснэ; 2. зүгээр асан, сайн асан, аятай юм асан, таатай юм асан; желательно, чтобы вы пришли та ирвэл зүгээр асан.

**ЖЕЛАТЕЛЬНЫЙ**, -ая, -ое; -лен, -льна (*книжн.*). 1. хүссэн, хүсэлд нийлдсэн, тохиромжтой, хүсмээр, тааламд зохисон, тааламтай; желательное решение хүссэн шийдвэр, тааламд зохисон шийдвэр; 2. хүсэх; желательное наклонение хүсэх төлөв.

**ЖЕЛАТИН**, -а, м. царцмаг.

**ЖЕЛАТЬ**, -аю, -аешь; *несов.* хүсэх; ерөөх, таалах, хүсэл болох, эрмэлзэх; желаю видеть его түүнтэй учрахыг хүснэ; желаю счастья кому-либо хүний жаргалтай байхыг ерөөх.

**ЖЕЛАЮЩИЙ**, -его. м. хүсэгч, хүсээтэй хүн, дургтай хүн, эрмэлзэгч; нашёлся только один желающий хүсээтэй хүн ганцхан байв.

**ЖЕЛВАК**, -а, м. булуу, овгор, товгор, ур.

**ЖЕЛЕ**, *нескл., ср.* царцмал, цэлцэгнүүр.

**ЖЕЛЕЗА**, -ы, *мн.* железы, желез, железам, ж булчирхай; миндальная железа бүйлсэн булчирхай; поджелудочная железа ноёр.

**ЖЕЛЕЗИСТЫЙ** I, -ая, -ое (*спец.*). төмөрт, төмөргэй, төмрийн; железистая руда төмрийн хүдэр; железистая вода төмөртэй ус.

**ЖЕЛЕЗИСТЫЙ** II, -ая, -ое. булчирхайт; железистая ткань булчирхайт нэхдэс.

**ЖЕЛЕЗКА**, -и, *ж.* төмрийн өөдөс, хугархай төмөр.

**ЖЕЛЁЗКА**, -и, *ж.* найлзуурхай, булчирхай, шүүсэвч.

**ЖЕЛЕЗНОДОРОЖНИК**, -а, м. төмөр замчин.

**ЖЕЛЕЗНОДОРОЖНЫЙ**, -ая, -ое. төмөр замын; железнодорожная станция төмөр замын өртөө.

**ЖЕЛЕЗНЫЙ**, -ая, -ое. 1. төмөр, төмрийн; железный дом а) төмөр царил; б) эвдэрхий төмөр; железная дорога төмөр зам; 2. хатан, ган болд, ган төмөр, ган; железная воля хатан зориг, ган зориг; 3. бөх, төмөр шиг; железное здоровье бөх бие; железный кулак төмөр шиг нударга; ☆ железный век төмрийн үе.

**ЖЕЛЕЗНЯК**, -а, м. гүрү төмрийн хүдэр; магнитный железняк соронзон гүрү; красный железняк улаан гүрү.

**ЖЕЛЕЗЭ**, -а, *ср.* 1. төмөр; листовое железо гөлмөн төмөр; прокатное железо цувинал төмөр; 2. төмөр эдлэл; торговать железом төмөр эдлэл худалдаалах; 3. төмөртэй эм; принимать железо төмөртэй эм уух; ☆ куй железом. пока горячо төмрийг халуун дээр нь давт, хаазайсан дээр нь түдхэж унагах.

**ЖЕЛЕЗОБЕТОН**, -а, м. төмөр бетон.

**ЖЕЛЕЗОБЕТОННЫЙ**, -ая, -ое. төмөр бетон, төмөр бетоны; железобетонная конструкция төмөр бетон барилга.

**ЖЕЛЕЗОДЕЛАТЕЛЬНЫЙ**, -ая, -ое. төмөр боловсруулах.

**ЖЕЛЕЗОПРОКАТНЫЙ**, -ая, -ое. төмөр цувих; железопрокатный завод төмөр цувих завод.

**ЖЕЛОБ**, -а, *мн.* желоб, м. ховид, онгоц; водосточный желоб усны ховид.

**ЖЕЛТЕТЬ**, -ею, -еешь; *несов.* 1. шарлах, шар болох; трава желтеет өвс шарлаж байна; 2. шарлаж харагдах, шарлах, шаргалтан харагдах, шаргалтах; вдали желтела рожь алсад хөх тариа шаргалтаж байв.

**ЖЕЛТИЗНА**, -ы, *ж.* шар, шар өнгө, шар толбо.

**ЖЕЛТОК**, -тка, м. өндөгний шар.

**ЖЕЛТОРТЫЙ**, -ая, -ое. 1. шар амтай, шар хошуутай; 2. жулдырай, гэнэн бага; желторотый юнец жулдырай хүү.

**ЖЕЛТУХА**, -и, *ж.* шар өвчин, шарлах.

**ЖЕЛТЫЙ**, -ая, -ое; *жслт, желта, желто и желто*. 1. шар; желтая краска шар будаг; 2. бөөрөнхий, эвлэрэгч; желтые профсоюзы бөөрөнхий үйлдвэрчний эвлэл.

**ЖЕЛУДОК**, -дка, м. ходоод; расстройство желудка гүйлгэх.

**ЖЕЛУДОЧЕК**, -чка, м. (*спец.*) ховдол.

**ЖЕЛУДОЧНЫЙ**, -ая, -ое. ходоодны; желудочный сок ходоодны шүүс.

**ЖЕЛУДЬ**, -я, *род. мн.* желудей, м. царсны боргоцой.

**ЖЕЛЧНЫЙ**, -ая, -ое; -чен, -чна. 1. цөсний; желчный пузырь цөсний гэр; 2. шартай, хор шартай; желчный человек шартай хүн.

**ЖЕЛЧЬ**, -и, *ж.* 1. цөс; 2. шар, хор шар, уур; подавить желчь шараа дарах.

**ЖЕМАНИТЬСЯ**, -нюсь, -нишься; *несов. (разг.)* маяглах, цэмцэгнэх, цэмцэгнүүр аашлах, нэрэлэх.

**ЖЕМАНИЦА**, -ы, *ж.* (*разг.*) маягтай эмэгтэй, цэмцэгнүүр эхнэр.

**ЖЕМАНИЧАТЬ**, -аю, -аешь; *несов. (разг.)* маяглах, цэмцэгнэх, цэмцэгнүүр загнах, нэрэлэх.

**ЖЕМАННЫЙ**, -ая, -ое; -нен, -нна. маягтай, маягласан, цэмцэгнүүр, цэмцэгнэсэн; жеманное поведение цэмцэгнүүр зан.

**ЖЕМАНСТВО**, -а, *ср.* цэмцэгнэх, маяглах, цэмцэгнүүр зан.

**ЖЕМЧУГ**, -а, *мн.* -а, м. сувд.

**ЖЕМЧУЖИНА**, -ы, *ж.* 1. сувд; 2. эрдэнэ, чимэг; стихи Пушкина—жемчужина русской поэзии Пушкины шүлэг бая оросын яруу найргийн чимэг мөн.

**ЖЕМЧУЖНЫЙ**, -ая, -ое. 1. сувдан, сувдын; жемчужное ожерелье сувдан эрх; 2. дун цагаан; жемчужные зубы дун цагаан шүд.

**ЖЕНА**, -ы, *мн.* жёны, жён, жёнам, ж. эхнэр, авгай, гэргий.

**ЖЕНАТЫЙ**, -ая, -ое; -ат. гэргийтэй, эхнэртэй, авгайтай, гэрлэсэн.

**ЖЕНАТЬ**, *женю, женишь; сов. и несов., когда на ком.* гэрлүүдэх, эхнэр авч өгөх, гэргий авуулах, бэр буулгах.

**ЖЕНИТЬБА**, -ы, *ж.* гэрлэх, эхнэр авах.

**ЖЕНИТЬСЯ**, *женюсь, женишься; сов. и несов.* гэрлэх, эхнэр авах, гэргийтэй болох, авгай авах.

**ЖЕНИХ**, -а, м. хүргэн болох хүн, гэрлэх хүн.

**ЖЕНСКИЙ**, -ая, -ое. эмэгтэй хүний, эмэгтэйчүүдийн, бүсгүй хүний, эхнэр хүний, эм хүний, эхийн, эхнэр, эм; женская обувь эмэгтэй хүний гутал; женский труд эмэгтэйчүүдийн хөдөлмөр; женский костюм эмэгтэй хүний хувцас, эхнэр хувцас; родство по женской эхийн талын хамаатан; женский род эм хүйс.

**ЖЕНСТВЕННОСТЬ**, -и, *ж.* хүүхэнсэг байх, эмсэг байх, эелэг зөөлөн.

**ЖЕНЩИНА**, -ы, *ж.* эмэгтэй, бүсгүй, эхнэр, эм хүн; женщина-врач эмэгтэй эмч.



**ЖЕНЫШЕ'НЬ**, -я, м. (хүн) орхоодой.

**ЖЕРДОЧКА**, -и, ж. 1. нарийн сургааг, унь; 2. хөндлөвч.

**ЖЕРДЬ**, -и, род. мн. -ей, ж. сургааг.

**ЖЕРЕБАЯ**, ж. боос, хээлтэй; жеребая кобыла боос гүү.

**ЖЕРЕБЕНОК**, -нка, мн. -бята, -бят, м. унага, даага.

**ЖЕРЕБЕ'Ц**, -бца, м. азарга.

**ЖЕРЕБИ'ТЪСЯ**, 1 и 2 л. не употр., -ится; несов. унагалах.

**ЖЕРЕБЬЕВКА**, -и, ж. шавга сугалах, шавга татах шавга орхих.

**ЖЕРЛО'**, -а, мн. жерла, жерл, ср. ам, амсар, ерх; жерло пушки их бууны ам; жерло вулкана галт уулын ерх.

**ЖЕРНОВ**, -а' мн. жернова, -ов. м. ин; тээрмийн чулуу.

**ЖЕ'РТВА**, -ы, ж. 1. тахил, тавиг, тайлга, тавилга, тахилга; 2. өргөл, барьц, өглөг; принести в жертву өргөл болгон барих, өргөх; 3. биеэ өргөх, амиа өргөх, хохирох; идти на жертвы биеэ өргөх, амиа өгөх; 4. амь үрэгдэгч, хохирогч, сүйдэгч; жертвы агрессии түрэмгийлэлд хохирогчод.

**ЖЕ'РТВОВАТЬ**, -таую, -тауешь; несов. 1. барих, өргөх, өглөг өгөх; 2. биеэ өргөх, амиа өгөх, хохирох; жертвовать собой амь биеэ өргөх.

**ЖЕРТВОПРИНОШЕ'НИЕ**, -я, ср. тахил өргөх, өргөл барих, тахих.

**ЖЕСТ**, -а, м. 1. дохно дохих, зангах; решительный жест шийдэмгий дохих; 2. үйл хийсэн дүр, өнгөний хэрэг; сделать благородный жест сайн үйл хийсэн дүр үзүүлэх; это всего лишь жест энэ бол зөвхөн өнгөний хэрэг.

**ЖЕСТИКУЛ'РОВАТЬ**, -рую, -руешь; несов. дохих, дохивчлох, зангах.

**ЖЕСТИКУЛ'ЯЦИЯ**, -и, ж. дохих, дохивчлох, зангах, дохно, дохивчлолт, зангалт.

**ЖЕСТКИЙ**, -ая, -ое; -ток, -тка', -тко; жёстче. 1. ширүүн, хатуу, гордойсон; жёсткий диван хатуу диван; жёсткое мясо хатуу мах, гордойсон мах; 2. ширүүн, хатуу, догшин; жёсткий характер ширүүн зан; 3. хатуу, чанга, хөдөлбөргүй; жёсткие сроки хатуу хугацаа; жёсткие условия чанга болзол; ☆ жёсткий вагон хатуу вагон; жёсткая вода хатуу ус.

**ЖЁСТКО**, нареч. хатуу, ширүүн.

**ЖЕСТО'КИЙ**, -ая, -ое; -ок, -ока, -око; жесто-чайший. 1. харгис, хэрцгий, догшин, ширүүн, хатуу; жестокое обращение с людьми хүнтэй хэрцгий харилцах; 2. хатуу, ширүүн, айхавтар, хахир; жестокий отпор хатуу цехилт; жестокая ошибка айхавтар алдаа; жестокий мороз хахир хүйтэн.

**ЖЕСТО'КОСТЬ**, -и, ж. харгис хэрцгий, хэрцгий явдал, харгис догшин хэрэг, ширүүн зан.

**ЖЕСТЬ**, -и, ж. нимгэн төмөр, цагаан төмөр; кровельная жесь дээврийн (нимгэн) төмөр.

**ЖЕСТЯНО'Й**, -ая, -ое. нимгэн төмөр, цагаан төмөр; жестяной чайник (цагаан) төмөр данх.

**ЖЕСТЯ'НЩИК**, -а, м. нимгэн төмөрчин, нимгэн төмрийн дархан.

**ЖЕТО'Н**, -а, м. 1. энгэрийн тэмдэг; 2. дугариг тэмдэг.

**ЖЕЧЬ**, жгу, жжбшь, жгут; жбг, жгла; несов. кого-что. 1. галдах, түймэрдэх, шатаах, түлэх; неприятель жбг на своем пути города дайсан замдаа олон хот галдав; 2. шатаах, түлэх, хуурах; жечь

электричество цахилгаан шатаах; жечь дрова түлээ түлэх; 3. халаах, түлэх, хорсгох, хайрах; солище жбёт спину нар нуруу халааж байна.

**ЖЕ'ЧЬСЯ**, жгусь, жжбшься, жгутся; жбгся, жблась; несов. 1. түлэх, хайрах; крапива жбётся халгай түлдэг; 2. түлэгдэх.

**ЖЖЕ'НИЕ**, -я, ср. хорсох, халуу оргих.

**ЖЖЕ'НЫЙ**, -ая, -ое. болгосон, болсон, түлмэл, хуурсан; жжбный кирпич болсон туйпуу; жжбный кофе хуурсан кофе.

**ЖИВИ'ТЕЛЬНЫЙ**, -ая, -ое; -лен, -льна. сэргээх, бие сэргэдэг, сэргэлэн, мөнхийн; живительный воздух сэргэлэн агаар; живительная влага мөнхийн рашаан.

**ЖИ'ВНОСТЬ**, -и, ж., собир. (разг.) гэрийн шувуу, тэжээвэр шувуу.

**ЖИ'ВО**, нареч. 1. тодорхой, илхэн, дурайн; он живо помнил все события бүх үйл явдал сэтгэлд нь дурайн ордог байв; 2. ихэд, тон; он мне живо напоминает мать тэр, эхийг минь ихэд санагдуулна; 3. хөгжөөнтэй, хөгжилтэй, урамтай; пьесу играли очень живо жүжгийг их урамтай наадав; 4. бушуу, шалавхан даруйхан; он живо сбегал тэр (хүн) шалавхан гүйж очоод ирэв.

**ЖИВО'Й**, -ая, -ое; жив, жива, живо. 1. амьд, мэнд, амьтай, голтой; живая рыба амьд загас; зас-татъ кого-либо в живых мэнд байхад нь учрах; 2. амьд, амьтай; живая природа амьд байгаль; живое существо амьтан; 3. жинхэнэ, ёстой, бодтой, үнэн, амьд; живая действительность үнэн бодит байдал; живой пример героизма ёстой баатарлагийн жишээ; 4. цовоо, сэргэлэн, хөнгөн, гавшгай, хөгжөөнтэй, хөгжилтэй, урамтай; живой ребёнок цовоо хүүхэд; 5. зугаатай, хялбар тодорхой; живое изло-жение хялбар тодорхой өгүүлэх; 6. чухал, амни чухал; живое начинание чухал эхлэлт; 7. гүн, халуун; живая обида гүн гомдол; ☆ живая рана шинэ шарх; живой вес амьдын жин; живые цветы амьд цэцэг; живого места нет бүтэн газаргүй байна; живой портрет кого-либо хүнтэй цутгасан юм шиг адил; живой язык амьд хэл; за живое задеть эмзэг газ-рыг нь хөндөх, сэтгэлийг нь хөдөлгөх; на живую нитку санд мэнд; хааш яаш; ни жив, ни мёртв үхсэн амь-дын хооронд; остаться в живых амьд үлдэх.

**ЖИВОП'И'СЕЦ**, -сца, м. уран зурагч, зураач.

**ЖИВОП'ИСНЫЙ**, -ая, -ое; -сен, -сна. үзэсгэлэнт, зурсан юм шиг сайхан, зураг шиг гоё; живописная природа үзэсгэлэнт байгаль.

**ЖИ'ВОП'ИСЬ**, -и, ж. 1. уран зураг; урок живописи уран зургийн хичээл; 2. зураг; стенная живопись гуурганы зураг.

**ЖИ'ВОСТЬ**, -и, ж. цовоо, сэргэлэн.

**ЖИВО'Т**, -а, м. 1. гэдэс, хэвэл; 2. гэдэс дотор, дотор хоолоод ☆ не на живот, а на смерть үхэхийг мэдэхгүй амь өрж.

**ЖИВОТВО'РНЫЙ**, -ая, -ое; -рен, -рна (высок.) амьдруулах; тэнхрүүлэх, зориг бадруулах; живот-ворное действие сна нойрын тэнхрүүлэх чадал.

**ЖИВОТНОВО'Д**, -а, м. малчин, мал аж ахуйн мэргэжилтэн.

**ЖИВОТНОВО'ДСТВО**, -а, ср. мал аж ахуй.

**ЖИВОТНОВО'ДЧЕСКИЙ**, -ая, -ое. мал аж ахуйн, мал өсгөх, малын; животноводческий госхоз мал өсгөх сэнгийн аж ахуй.

**ЖИВО'ТНОЕ**, -ого, ср. 1. амьтан, ядгуус, мал; домашнее животное гэрийн тэжээмээ амьтан, мал; хищное животное махчин амьтан, араатан; 2. адгуус, адгуусан амьтан; человек приручил животных хүн

адгуусан амьтныг тэжээсэн, 3. адгуус, адгуус шиг хүн.

**ЖИВОТНЫЙ**, *-ая, -ое*. амьтны, адгуусны, адгуусан, малын; животный мир амьтны аймаг.

**ЖИВОТРЕПЕЩУЩИЙ**, *-ая, -ее*. хойшлуулшгүй чухал, туйлын чухал; животрепещущий вопрос туйлын чухал асуудал.

**ЖИВУЧЕСТЬ**, *-и, ж.* бөх голтой (*байх*), долоон голтой (*байх*); урт нас.

**ЖИВУЧИЙ**, *-ая, -ее; -уч.* 1. бөх голтой, долоон голтой, урт настай; живучее растение урт настай ургамал; живучий человек бөх голтой хүн; 2. удаан хадгалагддаг, удаан настай, бөх; живучий обычай бөх заншил.

**ЖИВЬЁМ**, *нареч.* амьдаар; захватить живьём в плен амьдаар нь олзлох.

**ЖИДКИЙ**, *-ая, -ое; -док, -дка, -дко; жиже*. 1. шингэн; жидкие тела шингэн бодис; 2. шингэн, сийрэг, армаг тариаг, гачир; жидкий лес сийрэг ой; жидкие волосы шингэн үс; 3. шингэн, усавхи, усан; жидкий чай шингэн цай; жидкий суп усан шөл; 4. сул, улбагар, улхгар, дорой; жидкие мускулы улхгар булчин.

**ЖИДКОСТЬ**, *-и, ж.* шингэн бодис, шингэн зүйл.

**ЖИЖА**, *-и, ж.* нялцгай шавар, нялгар шивх.

**ЖИЖЕ**, *сравн. степ. от жидкий*, бүр шингэн, улам шингэн.

**ЖИЗНЕДЕЯТЕЛЬНЫЙ**, *-ая, -ое; -лен, -льна*. ажиллагаа сайтай, идэвхтэй.

**ЖИЗНЕННОСТЬ**, *-и, ж.* амьдрах чадал; сила и жизненность советского строя зөвлөлт байгууллын хүч, амьдрах чадал.

**ЖИЗНЕННЫЙ**, *-ая, -ое; -знен, -зненна*. 1. амьдралын, аж амьдралын; жизненные потребности амьдралын хэрэгцээ; жизненный опыт амьдралын туршилта; 2. амин чухал, амьдралын чухал; жизненное предложение амин чухал санал.

**ЖИЗНЕОПИСАНИЕ**, *-я, ср.* намтар, цадиг.

**ЖИЗНЕРАДОСТНОСТЬ**, *-и, ж.* баясгалан, цог, хөхүүн байх, цовоо байх.

**ЖИЗНЕРАДОСТНЫЙ**, *-ая, -ое; -тен, -тна*. баясгалантай, цогтой, хөхүүн, цовоо; жизнерадостный человек баясгалантай хүн.

**ЖИЗНЕСПОСОБНОСТЬ**, *-и, ж.* амьдрах чадвар, амьдрах чадал, амьдралд таарах, амьдралд зохицох.

**ЖИЗНЕСПОСОБНЫЙ**, *-ая, -ое; -бен, -бна*. амьдрах чадвартай, амьдрах чадалтай, амьдралд таарсан, амьдралд зохицсон.

**ЖИЗНЕУТВЕРЖДАЮЩИЙ**, *-ая, -ее (высок.)*, амьдралыг бататгах.

**ЖИЗНЬ**, *-и, ж.* 1. амьдрал, ертөнц; возникновение жизни на земле дэлхийд амьдрал үүссэн нь, закон жизни ертөнцийн жам; 2. амьдрал, амь, амь бие; амь нас, нас; жизнь человека хүний амьдрал, хүний нас, хүний амь; рисковать жизнью амь өрөх; спасти кому-либо жизнь хүний амь аврах; лишить жизни алах; 3. амьдрал, аж амьдрал, аж байдал, байдал, явдал суудал; общественная жизнь нийгмийн амьдрал; семейная жизнь гэр бүлийн аж амьдрал; 4. ажил хэрэг, хэрэг; провести решение в жизнь шийдвэрийг ажил хэрэг болгох; 5. нас, амьд байх, амьд явах, хүн болох; в течение всей жизни бүх насны, хаа турш; при жизни амьд явахдаа; раз в жизни хүн болсоор нэг удаа; 6. хөл, хөдөлгөөн, цог, жавхаа; улыцы полны жизни гудамж зээл хөл ихтэй байна; ☆ вопрос жизни и смерти амин гол асуудал, амин сүнс; между жизнью и смертью үхлийн даваан

дээр; по гроб жизни энэ насандаа, үхтлээ; как жизнь? ямар ая зантай байна?

**ЖИЛА**, *-ы, ж.* 1. судас; 2. шөрмөс, шандас, бүлх; 3. судал; золотоносная жила алтны судал.

**ЖИЛЕТ**, *-а, м. и (разг.)*, **ЖИЛЕТКА**, *-и, ж* хантааз.

**ЖИЛЕЦ**, *-льцá, м.* суугч, байрлагч, суудаг хүн, хүн; жильцы дома байшинд суугчид; сдать комнату жильцу нэг тасалгаа хүнд хөлслөх.

**ЖИЛИСТЫЙ**, *-ая, -ое; -ист*. 1. шөрмөстэй, шандастай, бүлхэрхэг; жилистое мясо бүлхэрхэг мах; 2. шандсархаг, шөрмөслөг, шандастай, шөрмөстэй; жилистые руки шандсархаг гар.

**ЖИЛИЦА**, *-ы, ж.* суугч эмэгтэй, байрлагч эмэгтэй, суудаг эмэгтэй.

**ЖИЛИЩЕ**, *-а, ср.* орон сууц, орон гэр, орон байр, сууц; благоустройство жилищ орон байр тохижуулах.

**ЖИЛИЩНЫЙ**, *-ая, -ое*, орон сууцны, орон байрын; жилищное строительство орон сууц барих; жилищные условия орон сууцны нөхцөл.

**ЖИЛКА I**, *-и, ж.* 1. судас; 2. шөрмөс, шандас, бүлх; 3. (*чулуулгийн*) судал; 4. судал, зураас, мрамор с красными жилками улаан судалтай гантг.

**ЖИЛКА II**, *-и, ж. (разг.)* авьяас, чадвар; артистическая жилка жүжигчний авьяас; организаторская жилка зохион байгуулах авьяас.

**ЖИЛОЙ**, *-ая, -ое*. сууцны, хүн суух, хүн суудаг; жилой дом хүн суудаг байшин.

**ЖИЛПОЩАДЬ**, *-и, ж.* сууцны талбай, орон сууц.

**ЖИЛЬЁ**, *-я, ср.* 1. хүн оршдог газар; 2. орох оромж, орох газар, хоргодох байр, сууц.

**ЖИР**, *-а, мн. -ы, м.* өөх, тос; животные жиры өөх; растительные жиры ургамлын тос; рыбий жир загасны тос.

**ЖИРАФ**, *-а, м.* анаш.

**ЖИРЕТЬ**, *-ею, -еешь; несов.* өөхлөх, таргалах, бүүдүүрэх, махлах.

**ЖИРНЫЙ**, *-ая, -ое; -рен, -рна, -рно*. 1. тарган, өөхтэй, тостой, тослог, хурц; жирное мясо тарган мах; жирный суп тостой шөл; 2. тарган, бүдүүн, махлаг; жирный кот тарган муур; 3. тостой, тос болсон, тосон; жирные руки тостой гар; жирное пятно тосон толбо; 4. үржилтэй, шимтэй; жирная земля шимтэй газар; ☆ жирный шрифт тарган үсэг.

**ЖИРОВИК**, *-а, м. (разг.)*. өөхөн хавдар.

**ЖИРОВОЙ**, *-ая, -ое*. 1. өөхөн, тосон, өөхтэй, тостой, тослог; жировая ткань өөхөн нэхдэс; 2. өөх тосны; жировая промышленность өөх тосны үйлдвэр.

**ЖИРОПОТ**, *-а, м. (спец.)* зунгаг.

**ЖИТЕЙСКИЙ**, *-ая, -ое*. ертөнцийн; орчлонгийн, өдөр тутмын, ерийн; житейские дела ертөнцийн хэрэг, ердийн хэрэг.

**ЖИТЕЛЬ**, *-я, м.* оршин суугч, хүн; городской житель хотын хүн; деревенский житель хөдөөгийн хүн; коренной житель уул нутгийн хүн.

**ЖИТЕЛЬСТВО**, *-а, ср. (офиц.)* нутаглах, оршин суух, суурьших; место жительства оршин суух газар.

**ЖИТНИЦА**, *-ы, ж.* 1. сан, хадгалах газар; 2. тарианы сан, тарианы орон; Украина—житница Советской страны Украина бол Зөвлөлт Улсын тарианы орон мөн.

**ЖИТНЫЙ**, *-ая, -ое*. тарианы, үр тарианы.

**ЖИТО**, *-а, ср* тариа, үр тариа.

**ЖИТЬ**, *живу, живёшь; жил, жила, жило; с отрицанием: не жил, не жила, не жило; несов.* 1. амьдрах, наслах; жить догдо урт наслах; 2. оршин суух, суух, байх; жить в Москве Москвад суух; 3. амьдрах, амь зуух, амь тэжээх; жить своим трудом хөдөлмөрөөрөө амь зуух; жить на литературный заработок зохиолын хөлсөөр амь тэжээх; 4. гэж амьд явах, шүтэж амьдрах; жить детьми хүүхдээ гэж амьд явах; жить наукой шинжлэх ухааныг шүтэж амьдрах; 5. амьдрах, суух, байх; жить отшельником жожиглон суух; 6. байх, харилцах; жить дружно с братьями ах дүүтэйгээ эвтэй байх; жил-был, жили были байжээ.

**ЖИТЬЕ**, *-я, ср.* амьдрал, байдал, амьдрах, аж төрөх, суух, байх; дом пригодный для житья сууж болмоор байшин; ☆ житье-бытьё аж амьжирлага.

**ЖИТЬСЯ**, *несов.* живётся, *жилося кому-чему (разг.)* амьжрах, суух, байх; нам живётся хорошо бид сайн амьжирч байна; ему не живётся на одном месте тэр (хүн) нэг газар байж чаддаггүй.

**ЖМУРИТЬ**, *-рю, -ришь; несов., что.* анийлгах, онийлгох; жмурить глаза нүдээ анийлгах, нүдээ онийлгох.

**ЖМУРИТЬСЯ**, *-рюсь, -ришься; несов.* анийлх, онийлх.

**ЖМУРКИ**, *-рок.* нүд боож наадах.

**ЖМЫХИ** (*жмых*) *-ов.* шахдас; подеолечные жмыхи нарав цэцгийн үрийн шахдас.

**ЖНЕЙКА**, *-и, ж.* хадах машин, халуур машин.

**ЖНЕЦ**, *-а, м.* тариа хадагч.

**ЖНЕЯ**, *-и, ж. (обл.)* тариа хадагч эхнэр, **ЖНИВО**, *-а, ср., ЖНИВЬЕ*, *-я, ср., ЖНИТВО*, *-а, ср.* 1. тариа хадсан талбай; 2. тарианы ёзоор; 3. тариа хадах цаг.

**ЖНИЦА**, *-ы, ж.* тариа хадагч эмэгтэй.

**ЖОМ**, *-а, м (спец.)* 1. шахуур; 2. шахдас.

**ЖОНГЛЁР**, *-а, м.* жонглёр, саваачлагч.

**ЖОНГЛИРОВАТЬ**, *-рую, -руешь; несов., чем* 1. жонглёр тоглох; 2. мэхлэх, хуурах.

**ЖРАТЬ**, *жру, жрёшь; жрал, жрала, жрало; несов., что.* чихэх; идэх, гудрах.

**ЖРЕБИЙ**, *-и, м.* 1. шавга; бросать жребий шавга орхих, шавга хаях; 2. хувь, тавилан, үйл.

**ЖРЕЦ**, *-а, м.* 1. тайлагач, бөө; 2. шүтэгч хүн; жрец науки шинжлэх ухааныг шүтэгч хүн.

**ЖРИЦА**, *-ы, ж.* тайлагач чавганц, удган.

**ЖУЖЖАНИЕ**, *-я, ср.* шунгинах, дүнгэнэх, шүнгэнэлэг, хүнгэнэлэг.

**ЖУЖЖАТЬ**, *-жжу, -жжешь; несов.* шунгинах, шүнгэнэх, дүнгэнэх, хүнгэнэх; жужжат комары шумуул шунгинана.

**ЖУК**, *-а, м.* цох, цох хорхой.

**ЖУЛИК**, *-а, м.* луйварчин.

**ЖУЛИКОВАТЫЙ**, *-ая, -ое; -ат.* луйварчин, луйвардаг, луйвар хийдэг; жуликоватый вид луйварчин шинж; жуликоватый человек луйвар хийдэг хүн.

**ЖУЛЬНИЧАТЬ**, *-аю, -аешь; несов.* луйвардах, луйвар хийх, булхайдах, булхай хийх.

**ЖУЛЬНИЧЕСТВО**, *-а, ср.* луйвар, луйвардах, булхай, булхайдах.

**ЖУПЕЛ**, *-а, м. (хадны)* мангаа.

**ЖУРАВЛИНЫЙ**, *-ая, -ое.* тогорууны, тогоруун.

**ЖУРАВЛЬ**, 1. *-я, м.* тогоруу, цэн.

**ЖУРАВЛЬ**, 2. *-я, м.* худгийн цах.

**ЖУРИТЬ**, *-рю, -ришь; несов., кого-что (разг.)* зэмлэх, аяглах.

**ЖУРНАЛ**, *-а, м.* 1. сэтгүүл; литературный журнал утга зохиолын сэтгүүл; 2. тэмдэглэлийн дэвтэр; журнал заседаний хурлын тэмдэглэлийн дэвтэр; 3. бүртгэлийн дэвтэр; классный журнал ангийн бүртгэлийн дэвтэр.

**ЖУРНАЛИСТ**, *-а, м.* сэтгүүлч, сурвалжлагч.

**ЖУРНАЛИСТИКА**, *-и, ж.* 1. сэтгүүлчийн ажил; 2. тогтмол хэвлэл, сонин сэтгүүл.

**ЖУРНАЛИСТКА**, *-и, ж.* сэтгүүлч эмэгтэй, сурвалжлагч эмэгтэй.

**ЖУРНАЛЬНЫЙ**, *-ая, -ое.* сэтгүүлийн; журнальная статья сэтгүүлийн өгүүллэл.

**ЖУРЧАНИЕ**, *-я, ср.* хоржигноо, шоржигноо, шорчигноо.

**ЖУРЧАТЬ**, 1 и 2. *не употр., -чит; несов.* хоржигнох, шоржигнох; шорчигнох, хор хор хийх, шор шор гэх, жир жир урсах.

**ЖУТКИЙ**, *-ая, -ое; жуток, -тка, -тко.* 1. аймшигтай, айдас хүрмээр, зэвүүн, аягүй; жуткое зрелище айдас хүрмээр үзэгдэл; 2. аюултай, зэвүүн; жуткий холод аюултай хүйтэн, зэвүүн хүйтэн.

**ЖУТКО**, *нареч. (прост.)* аймшигтай, аймаар, айдас хүрмээр; мне что-то жутко миний нэг айдас хүрээд байна.

**ЖУТЬ**, *-и, ж.* айдас, зэвүү.

**ЖУЧОК**, *-чка, м.* бяцхан цох.

**ЖЭК**, *-а, м. (сокращение: жилищно-экономическая контора)* ОСАК орон сууц ашиглалтын контор.

**ЖЮРИ**, *нескл; ср.* оqбир, шалгаруулах комисс,

## 3

**ЗА, предлог.** 1. цаана, цаад талд, тэртээ; за рекой голын цаад талд, голын тэртээ; за горой уулын цаана; за домом байшингийн цаана; 2. дэргэд, гадаа, гадна; за столом ширээний дэргэд; стоять за станком суурь машины дэргэд зогсох; жить за городом хотын гадна суух; 3. урьд, өмнө; за два дня до праздника баяраас хоёр хоногийн урьд; за час до отхода поезда галт тэрэг хөдлөхөөс нэг цагийн өмнө; 4. дотор, турш; эту работу можно сделать за два дня энэ ажлыг хоёр өдрийн дотор хийж болно; многое сделано за неделю долоо хоногийн дотор их юм хийжээ; 5. учраас, учир, тул; за неимением времени завгүй учраас; за молодостью лет залуу настай учраас; за истечением срока хугацаа дууссан

учир; за необходимостью кэрэггүй байсан учир; 6. төлөө, тулд, тулд, гэж; за мир во всём мире дэлхий дахины энх гайны төлөө; за Родину Эх орны төлөө; пришёл за книгой ном авахын тул ирсэн, ном авах гэж ирсэн; пить за здоровье эрүүл мэндийн төлөө уух; я за тебя всё сделаю чиний тул би бүгдийг хийнэ; я рад за вас таны төлөө би баярлана; беспокоиться за детей хүүхдийн төлөө сэтгэл зовоох; 7. гэж; обратиться за советом зөвлөлгөө авах гэж очих; ценить за ум ухаантай гэж үнэлэх, ухааныг үнэлэх; принять за образец үлгэр жишээ гэж үзэх, жишээ болгох; принять кого-нибудь за своего знакомого ямар нэг хүнийг тацлаа гэж андуурах; в погоне за удачей амжилт олох гэж хөө

цөлдөх; 8. хойноос; один за другим хойно хойноос; бежать за кем-либо хүний хойноос гүйх; 9. хойно, дараа, дараалан; за дождями наступила жара бо-рооны дараа халуун болов; читать книгу за книгой номуудыг дараалан унших; идёт месяц за месяцем сарын дараа сар ирэх юм, сар дараалан өнгөрч байна; 10. гарах, өнгөрөх, гаруй; ему далеко за сорок тэр хүн дөч нилээд гарчээ; ему за пятьдесят лет тэр тавь гаруй настай; уже за полночь шөнө дунд өн-гөрлөв; 11. оронд, төлөө; работать за двоих хоёр хүний оронд ажиллах; работать за мастера мастерын оронд ажиллах; вы работаете за меня миний оронд та ажиллаач; 12. зөвшөөрөх; за и против зөвшөөрөх эсэх; 13. -аас, -ээс; взят за руку гараас барих; держаться за перила хайснаас барих; за исклю-чением одного нэгээс бусды нь; дело за немногим альгүй юмнаас хэрэг саатах; за вами сто рублей танаас зуун рубль; за мной пять рублей надаас та-ван рубльин авлагатай; 14. -аар, -ээр; выбросить за окно цонхоор хаях; купить за десять рублей арван рубльнэр худалдаж авах; продать за пять рублей таван рубльнэр худалдах; 15. -д, -т; посылать за врачом эмчид хүн явуулах; пойти за водой усанд явах; пойти за ягодами жимсэнд явах; принятая за работу ажилдаа орох; с кинжалом за поясом бүсэндээ хутгатай; камень за пазухой өвөрт нь чу-луу байна; за десять километров арван километрийн газарт; за последнее время сүүлийн үед; вапши-те за мной над оногоод бич; выйти замуж кадамд очих; молчать за едой хоол идэхдээ дугай байх; поговорить за обедом хоолны үед ярилах, хоол идэхдээ ярицах; 16. -ын, -ийн; заработок за один месяц нэг сарын цалин; 17. -ыг, -ийг; смотреть за детьми хүүхдийг харж байх; смотреть за мыслями санаагийн нь ажиг; принятая за еду хоолоо идэх; 18. -тай, -тэй; дело за номером таким-то тийм ду-гаартай хэрэг; письмо за подписью директора за-хирлын гарын үсэгтэй бичиг; за ним водиться эта дурная привычка тэр ийм муу зантай юм; ☆ ни за что ясан ч; за сколько купили стол? ширээ яаж авсан бэ?

**ЗААЛЕ'ТЬ**, -ею, -еешь; сов. улайх, улайж эхлэх.  
**ЗААПЛОДИ'РОВАТЬ**, -рую, -руешь; сов. алга таних, алга таниж эхлэх.

**ЗААРКА'НИТЬ**, -ню, -нишь; сов. уургалах, бу-гуйллах; заарканить лошадь морь бугуйлдах.

**ЗААРТА'ЧИТЬСЯ**, -чусь, -чишься; сов. (прост.) ярдглах, хэдэрдлэх, яхирлах, адрах.

**ЗАА'ХАТЬ**, -аю, -аешь; сов. ай яаяа гэх, халаг-лах, ай чааваас гэх.

**ЗАБА'ВА**, -ы, ж. зугаа, зугаацад; детские игры и забавы хүүхдийн тоглоом зугаа; пустая заба-ва хоосон зугаа.

**ЗАБАВЛЯ'ТЬ**, -аю, -аешь; несов., кого-что. зу-гаацуулах; забавлять детей играми хүүхдийг тог-лоомоор зугаацуулах.

**ЗАБАВЛЯ'ТЬСЯ**, -аюсь, -аешься; несов., зугаа-цах, наадах; забавляться играми тоглоомоор зу-гаацах.

**ЗАБА'ВНИК**, -а, м. (разг.) зугаач, зугаатай хүн, алиа салбадай.

**ЗАБА'ВНО**, нареч., **ЗАБА'ВНЫЙ**, -ая, -ое; -ден, -вна. инээдтэй, наргианы, хөгийн; забавный ребёнок наргианы хүүхэд; забавный случай хөгийн тохнол-дол; забавная картинка инээдтэй зураг.

**ЗАБАЙКА'ЛБЕ**, -я, ср. Байгалын өмнөх, Байгалын урд бее.

**ЗАБАЛЛОТИ'РОВАТЬ**, -рую, -руешь; -ованный; сов., кого-что. сонгохгүй, сонгогтоор унагаах; ба-

баллотировать кандидата нэр дэвшсэн хүнийг унагаах.

**ЗАБА'ЛТЫВАТЬ**, -аю, -аешь; несов. хутгал, зайлах.

**ЗАБАРАБА'НИТЬ**, -ню, -нишь; сов. нижигнүүлж эхлэх, балбаж эхлэх, тачигнуулж эхлэх; дождь за-барабанил по крыше бороо дээврийг тачигнуулан орж эхлэв.

**ЗАБАРРИКАДИ'РОВАТЬ**, -рую, -руешь; -анный; сов. шивээ босгох, гудамж хааж бэхдэлт хийх.

**ЗАБАРРИКАДИ'РОВАТЬСЯ**, -руюсь, -руешься; сов. шивээ босгох, гудамж хаагдаж шивээ байгуу-лагдах.

**ЗАБАСТОВА'ТЬ**, -тую, -туешь; сов. ажил хаях.  
**ЗАБАСТО'ВКА**, -и, ж. ажил хаях, ажлаа хаях, всеобщая забастовка нийтээр ажлаа хаях; объявить забастовку ажлаа хаяхыг илэрхийлэх.

**ЗАБАСТО'ВОЧНЫЙ**, -ая, -ое. ажил хаягчдын ажил хаялтын, ажил хаях; забастовочный комитет ажил хаягчдын хороо; забастовочное движение ажил хаях хөдөлгөөн.

**ЗАБАСТО'ВЩИК**, -а, м. ажил хаягч, ажлаа хаягч.

**ЗАБВЕ'НИЕ**, -я, ср. мартаж, мартагдах; забвение своих обязанностей үүргээ мартаж, предать забве-нию мартаж орхих.

**ЗАБЕ'Г**, -а, м. уралдаан, гүйлт; забег на пять-сот метров таван зуун метрийн уралдаан; забег с препятствиями саадтай гүйлт.

**ЗАБЕ'ГАТЬ**, -аю, -аешь; сов. 1. үймэлдэх, гүйл-дэх, хөл үймээн болох; 2. бүлтэлзэх, бүлтэгнэх.

**ЗАБЕГА'ТЬ**, -аю, -аешь; несов. 1. орох, орж гарах; орж байх; забегать далеко в лес ойн гүнд орох. 2. дайраад гарах, ороод гарах; забегать по пути замдаа ороод гарах; ☆ забегать вперед урьдчилан хэлэх.

**ЗАБЕ'ГАТЬСЯ**, -аюсь, -аешься; сов. (разг.) гүй-гээд ядрах, эцтэлээ гүйх.

**ЗАБЕЖА'ТЬ**, -егу, -ежешь; сов. 1. гүйж орох; забегать во двор хашаанд гүйж орох; 2. ороод гарах, дайрч орох; забегать к знакомым танилын-даа ороод гарах; 3. хэтэрхий гүйх; 4. урьдчилан хийж эхлэх.

**ЗАБЕЛИ'ТЬ**, -лю, -лишь; -лённый (-ян, -вна); сов., что (разг.) 1. цайлгах, цагаанаар будах; забелить стены хана цагаанаар будах; 2. сүүлэх, сүдлэх, цайлгах; забелить чай цай сүлэх; забелить щи щи цайлгах.

**ЗАБЕРЕ'МЕНЕТЬ**, -ею, -еешь; несов. жирэмсэн болох, бие давхар болох, хөл хүнд болох, шалтгаан-тай болох, хүүхэд олох.

**ЗАВЕСПОКО'ИТЬСЯ**, -оюсь, -оишься; сов. санаа зовних, санаа зовж эхлэх, сэтгэл зовох.

**ЗАБИВА'ТЬ**, -аю, -аешь; несов. 1. шаах, хадах; забивать клин шаантаг шаах; забивать гвоздь хадаас хадах; 2. таглах, бөглөх, чигжих; забивать щели ангархайг бөглөх; 3. дүүргэх; трубу забивать песком төмөр хоолойг элсээр дүүргэх; 4. алах, нйд-лах; забивать двадцать голов скота хорин мадыг алах; 5. цохиж оруулах; забивать гол хаалгаар бөмбөг цохиж оруулах; ☆ забивать голову кем-либо ямар нэг юмыг үхширтэл бодох, санаашрах.

**ЗАБИВА'ТЬСЯ**, -аюсь, -аешься; несов. 1. шур-гах, шигдэх, нуугдах; забиваться в угол буланд нуугдах; 2. бүтэх, таглаарх; 3. цохиж эхлэх.

**ЗАБИНО'ВАННЫЙ**, -ая, -ое. боосон, өрвөсөн.  
**ЗАБИНОВА'ТЬ**, -тую, -туешь; сов., **ЗАБИН-ТО'ВЫВАТЬ**, -аю, -аешь; несов. боох, ороох; за-бинтовать рану шарх боох.

**ЗАБИРА'ТЬ**, -аю, -аешь; несов., **ЗАБРА'ТЬ**, -беру, -берёшь; -аа, -ала, -ало; забранный (-ан,

-ана, -ано); *сов.*, *кого-что*. 1. авах, авч очих; *забирать с собою книги номоо биедээ авч очих*; 2. авах, эзлэн авах, булааж авах; *забирать власть засгийг эзлэн авах; забирать в плен олзлон авах*; 3. барих, хорих; 4. хунхих, танах; *забирать шов оёдлыг танах*.

**ЗАБИРАТЬСЯ**, *-аюсь, -аешься; несов.*, **ЗАБРАТЬСЯ**, *-берусь, -берёшься; -ался, -алась; сов.* 1. нэвтрэн орох, шургаж орох; *забираться в самую глубь леса ойн гүнд нэвтрэн орох*; 2. өгсөх, авиран гарах; *забираться на дерево модон дээр авиран гарах*.

**ЗАБИТОСТЬ**, *-и, ж.* мохтол нухлагдах.

**ЗАБИТЫЙ**, *-ая, -ое; -ит*. 1. шаагдсан, хадагдсан, хадсан; *забитый гвоздь хадсан хадаас*; 2. мохтол нухлагдсан, мохоо болсон, түгжмэл хоцорсон; *забитый человек мохоо болсон хүн*.

**ЗАБИТЬ**, *-бью, -бьёшь; -бей, -итый; сов.*, *кого-что*. 1. цохиж эхлэх; *забить в барабаны хэнгэрэг цохиж эхлэх*; 2. шаах, хадах; *забить клин шаантаг шаах; забить гвоздь хадаас хадах*; 3. таглах, бөглөх, чигжих; *забить щели ангархайг бөглөх*; 4. цохиж оруулах; *забить шар в угол бөмбөгийг буланд цохиж оруулах; забить мяч в ворота бөмбөгийг каалгаар цохиж оруулах*; 5. дүүргэх, чихэх; *забить сарай дровами пинг түлээгээр дүүргэх*; 6. оргилох, оргилон гарах; *из скважины забила нефть цооногоор нефть оргилов*; 7. алах, нядлах; *забить десять голов скота арван малыг алах*; 8. даргах; *сорняк забил цветы хогийн ургамал цэцгийг дарав*; ☆ *забить голову кому-либо толгойг эргүүлэх; забить себе в голову үхширтлээ санах; забить тревогу түгшүүр зарлах*.

**ЗАБИТЬСЯ**, *-бьюсь, -бьёшься; -бейся; сов.* 1. цохиж эхлэх; *сердце забилося зурх цохиж эхлэв*; 2. нуугдах, хоргодох, шигдэх; *забиться в угол буланд хоргодох*; 3. таглах, бөглөрөх, битүүрэх; *труба забила грязью яндан хогоор бөглөрөв*.

**ЗАБИЯКА**, *-и, м. и ж. (разг.)*. ярдаг хүн, хэрүүл өдөөгч, зодоон өдөгч.

**ЗАБЛАГОВРЕМЕННО**, *нареч.* урьдаас, эртхэн, хэдийний; *известить заблаговременно эртхэн мэдэгдэх; готовиться к чему-либо заблаговременно ямар нэг юманд эртхэн бэлтгэх*.

**ЗАБЛАГОРАССУДИТЬСЯ**, *-ится; безл.*, *сов.* зохистой гэж үзэх, хэрэгтэй гэж бодох, бодсоноо; *делать все, что заблагорассудится юу бодсоноо цөмийг хийх*.

**ЗАБЛЕСТЕТЬ**, *-ещу, -естишь и -ещешь; сов* 1. гялалзаж эхлэх, гялалзах; *на небе заблестели звёзды отгоргуйд одод гялалзав*; 2. мэлмэрэх; *на глазах заблестели слёзы нүдэнд нь нулимс мэлмэрэв*.

**ЗАБЛЕЯТЬ**, *-ею, -еешь; сов.* майлах

**ЗАБЛУДИТЬСЯ**, *-ужусь, -удишься; сов.* төөрөх *заблудиться в лесу ойд төөрөх*; ☆ *заблудиться в грёх соснаж харагдаж байхад хажуугаар нь төөрөх*.

**ЗАБЛУЖДАТЬСЯ**, *-аюсь, -аешься; несов.* 1. төөрөх; 2. эндүүрэх.

**ЗАБЛУЖДЕНИЕ**, *-я, ср.* эндүүрэл, эндүүрэх, төөрөгдөл, төөрөх; *вводить в заблуждение эндүүрүүлэх; впасть в заблуждение төөрөгдөлд орох*.

**ЗАБОДАТЬ**, *-аю, -аешь; сов.* мөргөх, мөргөж орчих, олих.

**ЗАБОЙ I**, *-я, м.* уурхайн хонгил, уурхайн мөргөцөг.

**ЗАБОЙ II**, *-я, м.* нядлах, нядлал; *забой скота мал нядлах*.

**ЗАБОЙЩИК**, *-а, м.* мөргөцөг малтагч, уурхайчин.

**ЗАБОЛАЧИВАНИЕ**, *-я, ср.* намагших, балчи бо-

**ЗАБОЛАЧИВАТЬСЯ**, *-ается; несов.*, **ЗАБОЛОТИТЬСЯ**, *1 и 2 л. не употр., -отится; сов.* намагжих, намагтай болох, балчи болох; *почва заболотилась хөрс намагжив*.

**ЗАБОЛЕВАЕМОСТЬ**, *-и, ж.* өвдөх, өвчлөх, өвчин тусах байдал.

**ЗАБОЛЕВАНИЕ**, *-я, ср.* өвчин хүрэх, өвдөх, өвчлөх, өвчтөн; *число заболеваний өвчлөх тоо, өвчтөний тоо*.

**ЗАБОЛЕВАТЬ**, *-аю, -аешь; несов.* өвдөх, өвчлөх; *заболеть ангиной сахуугаар өвдөх*.

**ЗАБОЛЕТЬ**, *1 и 2 л. не употр., -ит; сов.* өвдөж эхлэх; *у меня заболела голова миний толгой өвдөж эхлэв*.

**ЗАБОЛОНЬ**, *-и, ж. (спец.)*. зулам, налхи.

**ЗАБОЛОЧЕННЫЙ**, *-ая, -ое*, намаг болсон, намагтай; *заболоченный луг намагтай нуга*.

**ЗАБОЛТАТЬ**, *-аю, -аешь; -олтанный; сов. (разг.)* 1. унжгануулах, санжгануулах, займчуулах, хөдөлгөх; *заболтать ногами хөлөө санжгануулах*; 2. холих, хутгах; *заболтать в суп яйцо шөлөнд өндөг хутгах*.

**ЗАБОЛТАТЬСЯ I**, *-аюсь, -аешься; сов. (разг.)* чалчих, бурах, үгэндээ согтох, дэмий юм ярих; *она заболталась со знакомыми, потому и опоздала тэр хүүхэн танилдуудтайгаа дэмий юм ярьсаар байгааг хожимдээ*.

**ЗАБОЛТАТЬСЯ II**, *-аюсь, -аешься; сов. (разг.)* унжилзах, холжих, дайвалзах.

**ЗАБОР**, *-а, м.* хашаа, хороо, хайс; *сад был обнесён высоким забором цэцэрлэг өндөр хашаагаар хашигдсан байв*.

**ЗАБОРИСТЫЙ**, *-ая, -ое; -ист (прост.)*. хатуу, чагга, аргар; *забористый табак хатуу тамхи*.

**ЗАБОТА**, *-ы, ж.* 1. зовнил, сэтгэл зовох, санаа зовох; *забота о своём будущем ирээдүйнхээ төлөө санаа зовох*; 2. халамж, элбэрэл, арчлал, санаа тавих; *забота о благосостоянии народа ард түмний чинээлэг амьдралын тухай санаа тавих; окружить кого-нибудь заботами хүнд халамж үзүүлэх; отеческая забота эцэг ёсны халамж*; 3. аж явдал; *домашние заботы гэрийн аж явдал*; ☆ *без забот хайхрамжгүй, ему и заботы мало тэр, бүр хайхрахгүй*.

**ЗАБОТИТЬ**, *-очу, -отишь; несов., кого-что*. санаа зовох; *его сильно заботит болезнь ребёнка хүүхэд өвдөөд санаа нь их зовж байна*.

**ЗАБОТИТЬСЯ**, *-очусь, -отишься; несов., о ком-чём*. 1. халамжлах, санаа тавих, элбэрэх, арчлах; *заботиться о детях хүүхдээ элбэрэх; заботиться о благе народа ард түмний тусын тул санаа тавих*; 2. сэтгэл зовох, санаа зовох; *ему ни о чём не придётся заботиться түүний санаа зовох юм огт байхгүй*.

**ЗАБОТЛИВО**, *нареч.* арчилж, элбэрч, халамжилж; *заботливо выращивать молодняк скота төл малыг арчилж бойжуулах*.

**ЗАБОТЛИВОСТЬ**, *-и, ж.* арчлал, элбэрэл, халамж, санаа тавих.

**ЗАБОТЛИВЫЙ**, *-ая, -ое*. халамжтай, элбэрэлтэй, арчлах; *заботливый отец халамжтай эцэг*.

**ЗАБРАКОВАТЬ**, *-кую, -куешь; -ованный; сов.*, **ЗАБРАКОВЫВАТЬ**, *-аю, -аешь; несов.* голох, шаарлах, заазлах.

**ЗАБРАЛО**, *-а, ср.* нүүрийн халхавч, дуулгын унжлага; ☆ *выступить с открытым забралом эрс гэгс хэлэх, ил шууд хэлэх*.

**ЗАБРАСЫВАТЬ**, *-аю, -аешь; несов.* 1. чулуулах, шидэх; *забрасывать мяч бөмбөг шидэх*; 2. булаах, хаяж дүүргэх, даргах; *забрасывать землей шороогоор будах; забрасывать вопросами асуултаар да-*

рах, зэрэг асууцгаах; 3. хаях, орхих, болих; 4. илгээх, явуулах; забрасывать товары бараа явуулах.

**ЗАБРА'СЫВАТЬСЯ**, *1 и 2 л. не употр., -ется; несов.* хаягдах, шидэгдэх.

**ЗАБРА'ТЬ**, *-беру, -берёшь; -ал, -ала, -ало; забранный(-ан, -ана, -ано, сов., кого-что).* 1. авах, авч явах; забрать с собой деньги мөнгөө биедээ авч явах; 2. авах, эзлэн авах, булааж авах; забрать в плен олзлон авах; 3. барих, хорих; 4. хуних, танах; забрать в рукаве небольшой кусок ханцуйнаас жаахан хэсгийг танах; 4. хаах, таглах; забрать окно досками цонхыг банзаар таглах; ☆ забрать в голову үгширтэл баримтлах; забрать себе в голову ямар нэгэн бодолд автагдах; забрать силу хүчтэй болох, нөлөөтэй болох.

**ЗАБРА'ТЬСЯ**, *-берусь, -берёшься; -ался, -алась; сов.* 1. авирч гарах; забраться на верхушку дерева модны үзүүрт авирч гарах; 2. шургаж орох, дайрч орох, нэвтэрч орох; забраться под одеяло хөнжилдөө шургаж орох; забраться в чужой дом бусдын гэрт дайрч орох; забраться в самую глубь леса ойн их гүнд нэвтэрч орох.

**ЗАБРЕ'ЖИТЬ**, *1 и 2 л. не употр., -жит; сов.* 1. цайх, хаярах, гэгээрэх; забрезжил рассвет үүр гэгээрлээ; 2. сүүмэлзэх, улсхийх, гялсхийх; в темноте забрезжил огонёк харанхуйд гал улсхийв.

**ЗАБРЕСТИ'**, *-еду, -едёшь, -ёл, -ела; -едший; сов. (разг.).* 1. хэсгээр орох, зайж орох, зайж явсаар орох; забрести далеко в лес зайж явсаар ойд гүн орох; 2. ороод гарах, дайраад гарах; изредка забредёт случайный посетитель хааяа тохиолдсон хүн ороод гарна.

**ЗАБРОНИРОВА'ТЬ**, *-рую, -руешь; -ованный; сов.* 1. захиалах, захиалгаар үлдээх, үлдээх; бронировать место в поезде галт тэргэнд ор захиалгаар үлдээх; 2. хуяглах.

**ЗАБРОСА'ТЬ**, *-аю, -аешь; -осанный; сов., кого-что кем.* 1. булах, булагдтал дарах; забросать яму землёй нүхийг шороогоор булах; 2. шидэх, хаях, 3. дарах; забросать вопросами асуултаар дарах.

**ЗАБРО'СИТЬ**, *-ошу, -осишь; -ошенный; сов., кого-что.* 1. шидэх, чулуудах; забросить мяч в сад бөмбөгийг цэцэрлэгт шидэх; 2. хаях, орхих, болих; забросить хозяйство аж ахуйгаа хаях; забросить чтение уншихаа болих.

**ЗАБРО'ШЕННОСТЬ**, *-и, ж.* 1. хаягдах, орхигдох эзэнгүйдэх; 2. алслагдах, зэлүүд, бөглүү.

**ЗАБРО'ШЕННЫЙ**, *-ая, -ое* 1. хаясан, шидсэн, шидэгдсэн; заброшенный мяч шидсэн бөмбөг; 2. хаягдсан, орхигдсон; заброшенный сад орхигдсон цэцэрлэг, арчилгаагүй цэцэрлэг.

**ЗАБРЫ'ЗГАТЬ**, *-аю, -аешь; -анный; сов., что.*

**ЗАБРЫ'ЗГИВАТЬ**, *-аю, -аешь; несов.* 1. үсэргэх, цацах, сүрчих; забрызгать грязью шавхай үсэргэх; 2. үсэргэж эхлэх, сүрчиж эхлэх, дусалж эхлэх; забрызгал дождь бороо дусалж эхлэв.

**ЗАБУЛДЫ'ГА**, *-и, м. и ж. (прост. неодобр.).* танхай, архиц.

**ЗАБУР'ЛИ'ТЬ**, *-ит; сов.* долгиж эхлэх; забурлило море далай долгиж эхлэв.

**ЗАБУХА'ТЬ**, *-ает; несов., ЗАБУ'ХНУТЬ, 1 и 2 л. не употр., -нет; -ух, -ла; сов.* бамбайх, бэлхийх, дэвгэх; бочка забухла торх дэвтлээ.

**ЗАБУШЕВА'ТЬ**, *-шут, -шуешь; сов.* шуугих, шуурах, бургиллах; вегер снова забушеввал шуурга дахин шуурав.

**ЗАБЫВА'ТЬ**, *-аю, -аешь; несов.* 1. мартах; быстро забывать түргэн мартах; забывать о поручении

даалгаврыг мартах; 2. орхих, болих; забудь думать об этом энэ тухай бодохоо боль.

**ЗАБЫВА'ТЬСЯ**, *-аюсь, -аешься; несов.* 1. мартах, мартагдах; 2. зүүрмэглэх; 3. ухаан алдах, муужрах; 4. хэтрэх, биеэ барихгүй.

**ЗАБЫ'ВЧИВОСТЬ**, *-и, ж.* мартамхай; по забывчивости мартамхай учраас; страдать забывчивостью мартамхай болох.

**ЗАБЫ'ВЧИВЫЙ**, *-ая, -ое; -ив.* мартамхай; забывчивый человек мартамхай хүн.

**ЗАБЫ'ТЫЙ**, *-ая, -ое.* мартсан, мартагдсан; забытые в вагоне вещи вагонд мартсан юм; забытый писатель мартагдсан зохиолч.

**ЗАБЫ'ТЬ**, *-буду, -будешь; -будь; -ытый; сов.* 1. мартах, мартагдах; забыть номер дома байшингийн дугаарыг мартах; забыть книгу дома номоо гэртээ мартах; 2. орхих, болих; и думать забудь санахаа ч боль.

**ЗАБЫТЬЕ**, *-я, ср.* 1. мэдээ алдах, ухаан алдах, манарч ойчих; больно впасть в забытьё өвчтэй хүн ухаан алдав; 2. зүүрмэглэх.

**ЗАБЫ'ТЬСЯ**, *-будусь, -будешься; -будься; сов.* 1. мартагдах; 2. ухаан алдах, манарч унах; больно забылся өвчтэй хүн манарч унав; 3. үгширтэл бодох, санаашрах; забыться в мечтах мөрөөдлөөр санаашрах; 4. зүүрмэглэх; 5. хэтрэх, дэндэх; так забылся, что стал грубить старшим тэгж дэндээд ахмад хүнийг аашлах болов.

**ЗАВ**, *-а, м. (разг.).* (заведующий) эрхлэгч.

**ЗАВА'ЖИЧАТЬ**, *-аю, -аешь; сов. (разг.).* ихэрхэх, ихэрхэж эхлэх.

**ЗАВА'Л**, *-а, м.* саад, овоорсон юм, хунгар; снежный завал цасан хунгар.

**ЗАВА'ЛЕННЫЙ**, *-ая, -ое.* дарагдсан, заваленный работой ажилд дарагдсан.

**ЗАВА'ЛИВАТЬ**, *-аю, -аешь; несов.* **ЗАВАЛИ'ТЬ**, *-аю, -алишь; -аленный; сов., кого-что.* 1. бөглөх, дүүргэх; завалить яму песком нүхийг элсээр бөглөх; завалить магазины товарами дэлгүүрийг бараагаар дүүргэх; 2. овоолох; завалить проход мешками гудамд шуудай овоолох; 3. нураах; завалить стену туургыг нураах; 4. дарах; завалить двор мусором хашааг хогоор дарах; завалить срочной работой яаралтай ажлаар дарах, яаралтай ажилд дарагдах.

**ЗАВА'ЛИВАТЬСЯ**, *-аюсь, -аешься; несов., ЗАВАЛИ'ТЬСЯ, *-аюсь, -алишься; сов.* 1. цаагуур унах, завсраар ойчих; книга завалилась за полку тавиурын цаагуур ном унажээ; 2. хэвтэх; завалиться спать унтах гэж хэвтэх; 3. нурах; стена завалилась хана нурав.*

**ЗАВА'ЛИНКА**, *-и, ж.* байшингийн хаяавч, байшингийн хашаас.

**ЗА'ВАЛЬ**, *-и, ж., собир. (разг.).* дарагдсан бараа, новш.

**ЗАВАЛЯ'ТЬСЯ**, *1 и 2 л. не употр., -яется; сов. (разг.).* 1. дарагдах; письмо завалылось на почте захидал шуудан дээр дарагдав; 2. гүйлгээгүй хэвтэх.

**ЗАВА'РИВАТЬ**, *-аю, -аешь; несов., ЗАВАРИ'ТЬ, *-арю, -аришь; -аренный, сов., что.* 1. идээшүүлэх, хандлах, чанах, үйх; заварить чай цай үйх, цай идээшүүлэх; 2. хутгах, будлиан хутгах; заварить дело хэрэг будлиантуулах; заварить кашу бантан хутгах, холион бантан хийх.*

**ЗАВА'РИВАТЬСЯ**, *-ается; несов., ЗАВАРИ'ТЬСЯ, *1 и 2 л. не употр., -арится; сов.* идээших; заварился чай цай идээшжээ; ☆ заварилось дело төвөгтэй хэрэг гарчээ.*

**ЗАВА'РКА**, *-и, ж.* үйх, идээших, чанах; чаю осталось на одну заварку нэг чанах цай үлджээ.

**ЗАВАРНО'Й**, -ая, -ое. 1. юм чанах, чанагт; заварной котел юм чанах тогтоо; 2. хэдүүн усаар зуурсан, зуурч хийсэн; заварной хлеб зуурч хийсэн талх.

**ЗАВЕДЕ'НИЕ**, -я, ср. (устар.). газар, сургууль; прачечное заведение хувцас угаах газар; высшее учебное заведение дээд сургуулийн газар, дээд сургууль.

**ЗАВЕ'ДОВАНИЕ**, -я, ср. **ЗАВЕ'ДОВАТЬ**, -дую, -дуешь; несов., чем. эрхлэх, захирах; заведовать хозяйством аж ахуйг эрхлэх; заведовать учреждением албан газрыг захирах.

**ЗАВЕ'ДОМО**, нареч. мэдсээр, мэдээжийн; заведомо ложное показание мэдээжийн худад өчиг.

**ЗАВЕ'ДОМЫЙ**, -ая, -ое. мэдээжийн, ядт; заведомая ложь мэдээжийн худал.

**ЗАВЕ'ДУЮЩАЯ**, -ей, ж. эрхлэгч эмэгтэй.

**ЗАВЕ'ДУЮЩИЙ**, -его, м. эрхлэгч; заведующий хозяйством аж ахуйн эрхлэгч.

**ЗАВЕ'ДЫВАНИЕ**, -я, ср. **ЗАВЕ'ДЫВАТЬ**, -аю, -аешь; несов., чем. эрхлэх, захирах; заведывать финансами санхүүг эрхлэх.

**ЗАВЕСТИ'**, -зу, -зёшь; -ёз, -аа; -зённый (-ён, -ена) сов., кого-что. 1. далимаар хүргэх, завести нислэг по дороге замын далимаар захидаг хүргэх; 2. аваачих, хүргэх; завести товары в магазин дэлгүүрт бараа аваачих.

**ЗАВЕРБОВА'ТЬ**, -бую, -буешь; -бованный; сов., **ЗАВЕРБО'ВЫВАТЬ**, -аю, -аешь; несов., кого. элсүүлэх.

**ЗАВЕРЕ'НИЕ**, -я, ср. баталгаа; давать заверение баталгаа өгөх.

**ЗАВЕРИ'ТЕЛЬ**, -я, м. батлагч, баталгаа өгөгч.

**ЗАВЕРИ'ТЬ**, -рю, -ришь; -рениый; сов., кого-что. 1. батлах, батлан хэлэх; заверить в своей преданности үнэнч байгаагаа батлан хэлэх; 2. батлах, үнэн гэж батлах, баталгаа өгөх; заверить подпись гарын үсгийг батлах; заверить копию хуулыг үнэн гэж баталгаа өгөх.

**ЗАВЕРНУТЫЙ**, -ая, -ое. 1. ороолттой, ороосон, хуйлсан, боолттой; 2. мушгисан; 3. шууган, шамласан.

**ЗАВЕРНУ'ТЬ**, -ну, -нёшь; -вёрнутый; сов. 1. ороох, боох, хуйлах; завернуть книгу в бумагу номыг цаасаар ороох, номыг цаасаар боох; 2. мушгих, эргүүлэх, эргэдэж хаах, хаах; завернуть край портыг хаах; 3. шамлах, шуух; завернуть рукава хандуу шамлах; 4. тойрох, тойроод далдрах; завернуть за угол буланг тойроод далдрах; 5. ороод гарах, далимд орох; завернуть к приятелю найзындаа ороод гарах; 6. орох, болох; завернули морозы хүйтэн болох; ☆ завернуть ребёнка в одеяло хүүхэд мануулах, хүүхдийг хөнжилд ороох.

**ЗАВЕРНУ'ТЬСЯ**, -нусь, -идьсья; сов. 1. биеэ ороох, ороогдох; завернуться в одеяло хөнжлөөр биеэ ороох; 2. шамрах; завернулась под шубы дээлийн хормой шамрав.

**СОЛЁ** НЫЙ, -ая, -ое; *солон, солонка, солонка*. 1. давстай, давслаг; солёная вода давстай ус; солёное озеро давстай нуур; 2. давсархаг, давстай; слишком солёный суп их давсархаг шөл, давс нь ихэдсэн шөл; 3. давсалсан, давсанд дарсан; солёные огурцы давсалсан өргөст хэмх.

**СОЛИДА** РИЗА ЦИЯ, -и, ж. эв санаа нэгдэх, эр санааны нэгдэл, санаа нийлэх.

**СОЛИДА** РИЗИ РОВАТЬСЯ, -руюсь, -руешься; сов. и несов., с кем-чем (*книжн.*) эв санаа нэгдэх, санаа нийлэх; солидаризироваться в мнении доклады чика илтгэгчтэй санал нийлэх.

**СОЛИДА** РНОСТЬ, -и, ж. эв санаа нэгдэх, эв санааны нэгдэл, санал нийлэх; международная солидарность трудящихся олон улсын хөдөлмөрчдийн эв санааны нэгдэл; из солидарности санал мийлсэн учраас.

**СОЛИДА** РНЫЙ, -ая, -ое; -рен, -рна; с кем-чем. санал нийлсэн, эв санал нэгтэй, хамтын; солидарная ответственность хамтын хариуцлага.

**СОЛИ** ДНО, нареч. 1. бат бөх, бат бөх; солидно построенный дом бат бөх барьсан байшин; 2. томоотой, төлөвтэй; 3. нэлээд их, ихээхэн.

**СОЛИ** ДНОСТЬ, -и, ж. 1. бат бөх байх, бат бөх байх; 2. томоо, төлөв, буурь.

**СОЛИ** ДНЫЙ, -ая, -ое; -ден, -дена. 1. бат бөх, бат бөх, буурьтай; очень солидные знания тон буурьтай мэдлэг; 2. томоотой, төлөв, буурьтай, суурьтай; солидный человек томоотой хүн; солидный журнал буурьтай сэтгүүл; 3. хижээл насны, хижээлхэн; человек солидных лет хижээл насны хүн; 4. нэлээд их, ихээхэн; солидная сумма денег нэлээд их мөнгө.

**СОЛИП** СИЗМ, -а, м. солипсизм (*гагцхүү өөрийн ухаарлыг бодит зүйл гээд, бусдад бүх юмыг үгүйсгэдэг туйлын субъектив идея дахь*).



**СОЛИПСИСТ**, *-а, м.* солипсист, солипсизмыг барьтлагч.

**СОЛИСТ**, *-а, м.* гоцлон дуулагч, гоцлон хөгжимдөгч.

**СОЛИСТКА**, *-и, ж.* гоцлон дуулагч эмэгтэй, гоцлон хөгжимдөгч эмэгтэй.

**СОЛИТЕР**, *-а, м.* том засмал алмас.

**СОЛИТЕР**, *-а, м.* гуш хорхой.

**СОЛИТЬ**, *солю, солишь (солишь); соленый; несов., что.* 1. давс хийх, давс орхих, давслах; солить суп шөлөнд давс хийх; 2. давслах, давсанд дарах; солить грибы мөөг давслах.

**СОЛИТЬСЯ**, *1 и 2 л. не употр. -ится; несов.* давслагдах.

**СОЛКА**, *-и, ж.* давслах, давслагт.

**СОЛНЕЧНО**, *нареч.* нартай байх, нарлаг байх; сегодня солнечно өнөөдөр нартай байна.

**СОЛНЕЧНЫЙ**, *-ая, -ое; -чен, -чна.* 1. нарны, наран; солнечная радиация нарны цацраг; солнечное затмение нар хиртэх; солнечная сторона наран тал; солнечные часы наран цаг; солнечная ванна наран угаал; солнечное пятно нарны толбо; 2. нартай, нарлаг; солнечный день нартай өдөр; солнечная ком ната нарлаг тасалгаа; ☆ солнечный удар нар карвах, нар цохих.

**СОЛНЦЕ**, *-а, ср.* 1. нар; восход солнца нар ургах, нар гарах; заход солнца нар жаргах, нар шингэх; греться на солнце наранд ээх; до солнца нар гартал; 2. наран; солнце правды үнэний наран.

**СОЛНЦЕПЕК**, *-а, м.* ээвэр, наран тал; сидеть на солнцепёке наран талд суух.

**СОЛНЦЕСТОЯНИЕ**, *-я, ср.* өвөл зуны туйл, нар буцах; зимнее солнцестояние өвлийн туйл; летнее солнцестояние зуны туйл.

**СОЛЮ**, *1 нескл. ср.* 1. гоцлол дуу, гоцлол хөгжим; 2. гоцлон дуулах, гоцлон хөгжимдөх.

**СОЛЮ**, *нареч.* гоцлон, ганцаараа; петь соло воцлон дуулах; танцевать соло ганцаараа бүжиглэх.

**СОЛОВЕЙ**, *-вья, м.* алтан гургалдай.

**СОЛОВЕТЬ**, *-ею, -еешь; несов. (прост.).* гяртайх, сурдайх.

**СОЛОВЬИЙ**, *-ая, -ое.* шарга.

**СОЛОВЬИНЫЙ**, *-ая, -ое.* алтан гургалдай; соловьиные трели алтан гургалдайн жиргэх.

**СОЛОД**, *-а (-у), м.* амуу соёолж.

**СОЛОМА**, *-ы, ж.* сүрэл.

**СОЛОМЕННЫЙ**, *-ая, -ое.* сүрэл, сүрлээр хийсэн; соломенная подстилка сүрэл дэвсгэр.

**СОЛОМИНА**, *-ы, ж.* нэг ширхэг сүрэл.

**СОЛОМИНКА**, *-и, ж.* бяцхан сүрэл, нарийхан сүрэл.

**СОЛОМКА**, *-и, ж.* 1. бяцхан сүрэл, нарийхан сүрэл; 2. савхан чихэр, савхан боов.

**СОЛОМОРЕЗКА**, *-и, ж.* сүрэл хэрчүүл.

**СОЛОНИНА**, *-ы, ж.* давсалсан мах.

**СОЛОНКА**, *-и, ж.* давсны сав.

**СОЛОНО**, 1. давстай юм; 2. давс амтагдах. давстай байх; слишком соломо во рту аман дотор давс амтагдана.

**СОЛОНОВАТЫЙ**, *-ая, -ое.* давсархаг, баахан давстай.

**СОЛОНЧАК**, *-а, м.* марз, мараа, хужиртай газар.

**СОЛОНЧАКОВЫЙ**, *-ая, -ое.* хужиртай, марзын; мараны; солончаковые почвы хужиртай хөрс.

**СОЛЬ**, *-и, мн. -и, -ей, ж.* 1. давс; поваренная соль хоолны давс; 2. учир, утга; вся соль в этом камаг учир үүнд байна.

**СОЛЬНЫЙ**, *-ая, -ое.* гоцлол, ганцаар дуулах, гоцлон хөгжимдөх; сольный отрывок. гоцлол хэсэг.

**СОЛЯНОЙ**, *-ая, -ое.* давсны, давстай, давслаг; соляные копи давсны уурхай; соляная кислота давсны хүчил.

**СОЛЯРИЙ**, *-я, м.* наранд шарах газар.

**СОМ**, *-а, м.* цулбуурт (загас).

**СОМКНУТЫЙ**, *-ая, -ое.* 1. жимийсэн, хамхисан, аньсан; сомкнутые уста жимийсэн уруул; 2. шигүү, үргэлж, завсаргүй, хураангуй; сомкнутый строй хураангуй жагсаал, шигүү жагсаал.

**СОМКНУТЬ**, *-ну, -нешь; сомкнутый; сов., что.* 1. нийлүүлэх, үргэлж болгох, завсаргүй болгох, шигүү жагсаах, хураангуйлах; 2. аних, хамхих; сомкнуть глаза нүдээ аних.

**СОМКНУТЬСЯ**, *1 и 2 л. ед. не употр., -нётся; сов.* 1. шигүү жагсах, үргэлж болох, нийлэх; 2. аних, камхих.

**СОМНЕВАТЬСЯ**, *-аюсь, -аешься; несов., в ком; чем и союзом что.* сэжиглэх, тээнэгэлзэх, өргөлдөх, сэжигдэх.

**СОМНЕНИЕ**, *-я, ср.* 1. сэжиг, дамжиг, тээнэгэлзэл, эргэлзэл; возбуждать сомнение сэжиг төрүүлэх; 2. тээнэгэлзэх, тулгардах; разрешить все сомнения эргэлзсэнийг бүгдийг шийдвэрлэх; ☆ без сомнения дамжиггүй, осолгүй.

**СОМНИТЕЛЬНО**, *нареч.* 1. сэжиглэмээр, сэжиглэлтэй, сэжиг төрмөөр; сомнительно чистый сэжиглэмээр цэвэр; 2. эргэлзэлтэй, итгэлгүй; сомнительно, зайдёт ли он к нам түүний манайд ирнэ гэдэг итгэлгүй.

**СОМНИТЕЛЬНОСТЬ**, *-и, ж.* сэжиглэлтэй (байх), итгэлгүй (байх), эргэлзэлтэй (байх).

**СОМНИТЕЛЬНЫЙ**, *-ая, -ое; -лен, -льна.* 1. сэжиглэлтэй, эргэлзэмээр, дамжигтай; сомнительная теория эргэлзэмээр онол; 2. сэжигтэй, сэжиглэмээр, эргэлзэлтэй; сомнительное дело эргэлзэлтэй хэрэг; 3. хоёрдмол утгатай, ац утгатай.

**СОН**, *сна, м.* 1. нойр; унтах; его клонит ко сну түүний нойр хүрч байна; здоровый сон сайн нойр; спать крепким сном бөх унтах; пробудить кого-либо от сна хүнийг нойроос нь сэрээх; сквозь сон слышат нойр дундаа сонсох, нойрмог сонсох; 2. зүүд; видеть сон зүүдлэх; 3. (сайхан) зүүд, зүүд зэрэглээ; ☆ как во сне 1. сайхан зүүд шиг; 2. нойрмог юм шиг, зүүрмэглэж байгаа юм шиг; заснуть вечным сном мөнх нойрсох; со сна нойрмоглоод.

**СОНАТА**, *-ы, ж.* эгшиглэнт аялгуу, сонат (хурдац, шинжээрээ өөр өөр гурав дөрвөн бүлгээс бүрдсэн хөгжмийн зохиол).

**СОНЕТ**, *-а, м.* арван дөрвөн мөрт шүлэг.

**СОНЛИВОСТЬ**, *-и, ж.* нойрмог байдал, нойртой (байх).

**СОНЛИВЫЙ**, *-ая, -ое; -ив.* нойрмог, нойртой.

**СОНМ**, *-а, м.* тоо томшгүй, үй түм.

**СОННЫЙ**, *-ая, -ое.* 1. унтаж байх үеийн; 2. нойрмог, нойр хүрсэн; сонное состояние нойрмог байдал; 3. нойрмог, дутуу сэрсэн; сонные глаза нойрмог нүд; 4. унтуулах, нойр күүргэх, нойрын; ☆ сонная артерия нойрын тарагуур судас, гүрээний судас.

**СОНЯ**, *-и, м. и ж.* унтаахай.

**СООБРАЖАТЬ**, *-аю, -аешь; несов.* 1. ухаарч, ухах; 2. юм ойлгох; я сегодня плохо соображаю би өнөөдөр юм ойлгохгүй байна.

**СООБРАЖЕНИЕ**, *-я, ср.* 1. бодол, бодлого бодох, ухаарах; поступать без соображения бодлогогүй юм хийх; 2. бодол, санал; у меня есть свои соображения над өөрийн бодол бий; ☆ принять в соображение бодолцох, анхаарах.

**СООБРАЗИТЕЛЬНОСТЬ**, -и, ж. ухамж, ухамхай (байх), авхаалж.

**СООБРАЗИТЕЛЬНЫЙ**, -ая, -ое; -лен, -льна. ухамжтай, ухамхай, авхаалжтай, окуутай; сообразительный ребёнок ухамхай хүүхэд.

**СООБРАЗИТЬ**, -ажу, -азишь; -ажённый (-ён, -ена); сов. ухаарах, ухах, ойлгох; сообразить в чём дело учрыг нь ойлгох.

**СООБРАЗНО**, нареч. нийцүүлэн, тохируулан, зохицуулан; сообразно с обстоятельствами байдал зохицуулан.

**СООБРАЗНОСТЬ**, -и, ж. нийцсэн (байх), тохирсон (байх), зохилдсон (байх); сообразность всех действий бүх үйл явдал зохилдсон байх.

**СООБРАЗОВАТЬ**, -зую, -зуюшь; -ованный; сов. и несов., что с чем (книжн.). нийцүүлэх, тохируулах, тааруулах, зохилдуулах; сообразовать расходы с доходами зарлага орлоготой тохируулах.

**СООБРАЗОВАТЬСЯ**, -зуюсь, -зуюсьея; сов. и несов., с чем (книжн.). (байдалтай) нийцүүлэх, (зохисыг) үзэх; сообразоваться с обстоятельствами зохисыг үзэх.

**СООБРАЗОВАТЬ**, -аю, -аешь; несов., что с чем. нийцүүлэх, тохируулах, тааруулах, зохилдуулах.

**СООБРАЗОВАТЬСЯ**, -аюсь, -аеясь; несов., с чем. (байдалтай) нийцүүлэх, (зохисыг) үзэх.

**СООБЩА**, нареч. хамт, хамтран, хоршиж; действовать сообща хамтран үйлдэх.

**СООБЩАТЬ**, -аю, -аешь; несов. 1. сонсгох, мэдэгдэх, дуулах, мэдээлэх; 2. олгох, халдаах, нялзаах; 3. болгох, шингээх.

**СООБЩАТЬСЯ**, -аюсь, -аеясь; несов. 1. халдах, нялзах, шингэх; 2. харилцах, холбоо барих; сообщаться друг с другом письмом бие биетэйгээ захидалар харилцах; 3. нийлэх, холбоотой байх; Москва-река сообщается с Волгой Москва гол, Ижил мөрөнтэй холбоотой.

**СООБЩЕНИЕ**, -я, ср. 1. сонсгох, мэдэгдэх, мэдээлэх; сообщение известий мэдээ сонсгох; 2. мэдээ, мэдээлэл; прочесть интересное сообщение сонин мэдээ унших; последнее сообщение сүүлийн мэдээ; 3. харилцаа; воздушное сообщение агаарын харилцаа.

**СООБЩЕСТВО**, -а, ср. бүлэг, бүлэглэл, хоршоо; преступное сообщество гэмт хоршоо.

**СООБЩИТЬ**, -ту, -тишь; -щённый (-ён, -ена); сов. 1. сонсгох, мэдэгдэх, дуулгах, мэдээлэх; сообщить о прибытии поезда галт тэрэг ирэхийг мэдэгдэх; 2. олгох, халдаах, нялзаах; 3. болгох, шингээх; сообщить железу магнитные свойства температуры соронзонтой болгох.

**СООБЩИТЬСЯ**, 1 и 2 л. не употр., -ишься; сов., кому-чему (книжн.). халдах, нялзах, шингэх; болельщица матери сообщила детям эхийн өвчин хүүхдүүдэд нь халдав.

**СООБЩИНИК**, -а, м. хамсаа, хоршоо, нам нийлэгч

**СООБЩИНИЦА**, -ы, ж. хамсаа өмөгтэй, хоршоо эхнэр.

**СООБЩИЧЕСТВО**, -а, ср. хамсах, хорших, нам нийлэх.

**СООРУДИТЬ**, -ужу, -удишь; -ужённый (-ён, -ена); сов., что, **СООРУЖАТЬ**, -аю, -аешь; несов. зайгуулах, бүтээх, босгох, барих; соорудить памятник хөшөө зайгуулах; соорудить здание барилга барих.

**СООРУЖЕНИЕ**, -я, ср. 1. зайгуулах, бүтээх, босгох, барих; 2. байшин, барилга; монументальное сооружение дуг барилга.

**СООТВЕТСТВЕННО**, предлог с дат. п. 1. зохих ёсоор, тэр ёсоор, тэрчлэн; 2. ёсоор, нийлүүлэн, зо-

хицуулан; действовать соответственно приказу тусгай ёсоор үйлдэх.

**СООТВЕТСТВЕННЫЙ**, -ая, -ое; -вен, -венна. зохистой, тохирох, таарамжтай; вынести соответственное решение тохирох шийдвэр гаргах.

**СООТВЕТСТВИЕ**, -я, ср. зохицох, нийцэх, тохирох, таарах, зохимж, тохиромж, таарамж; полное соответствие интересов эрх ашиг бүрэн нийцэх; в соответствии с законом хуульд зохицуулан.

**СООТВЕТСТВОВАТЬ**, -твую, -твуеть; несов., кому-чему. зохицох, нийцэх, тохирох, таарах, таацах; соответствовать истине үзэнд нийцэх; соответствовать своей цели зорилгодоо таарах.

**СООТВЕТСТВУЮЩИЙ**, -ая, -ее. зохих, тохиромжтой, таарах; соответствующее помещение тохиромжтой байр.

**СООТЧЕСТВЕННИК**, -а, м. (книжн.). нэгэн нутгийн хүн.

**СООТЧЕСТВЕННИЦА**, -ы, ж. нэгэн нутгийн эмэгтэй, нэгэн нутгийн бүсгүй.

**СООТЧЕСТВИЕ**, -су, -сешь, -ёс, -есла; -есённый (-ён, -ена); -еся; сов., что (книжн.). харьцалдуулах, тэнцээрийг олох, харьцуулах; соотнести два понятия хоёр ухагдахууныг харьцалдуулах.

**СООТНОСИТЕЛЬНОСТЬ**, -и, ж. харьцалдаа, харьцаатай байх.

**СООТНОСИТЕЛЬНЫЙ**, -ая, -ое; -лен, -льна. харьцалдаат, тэнцээртэй, харьцаатай.

**СООТНОСИТЬ**, -ошу, -асишь; несов. харьцалдуулах, тэнцээрийг олох, харьцуулах.

**СООТНОСИТЬСЯ**, 1 и 2 л. не употр., -осишься; несов. (книжн.). харьцалдах, тэнцээртэй байх.

**СООТНОШЕНИЕ**, -я, ср. харьцалдаа, тэнцээр, харьцаа; соотношение сил хүчний харьцаа.

**СОПЕ'НИЕ**, -я, ср. 1. шуухинах; 2. шуухинаан.

**СОПЕ'РНИК**, -а, м. өрсөлдөгч, тэмцэлдэгч.

**СОПЕ'РНИЦА**, -ы, ж. өрсөлдөгч эмэгтэй, өрсөлдөгч эхнэр.

**СОПЕ'РНИЧАТЬ**, -аю, -аешь; несов., с кем-чем в чем. 1. өрсөлдөх, тэмцэлдэх; 2. өрсөлдөх, тэмцэх; ни одна капиталистическая страна не может соперничать с СССР по темпам развития промышленности нэгч капиталист орон, үйлдвэрийн хөгжлийн хурдацаар ЗСБНХУ-тай өрсөлдөж чадахгүй.

**СОПЕ'РНИЧЕСКИЙ**, -ая, -ое. өрсөлдөөний, тэмцэлдээний.

**СОПЕ'РНИЧЕСТВО**, -а, ср. өрсөлдөөн, тэмцэлдээ.

**СОПЕ'ТЬ**, -плю, -пишь; несов. шуухинах.

**СО'ПКА**, -и, ж. толгой, гувээ.

**СОПЛЕ'МЕННО**, -а, м. чей. нэг угсааны хүн, нэг угсаатан.

**СОПЛЕ'МЕННЫЙ**, -ая, -ое. высок нэг угсааны, угсаа нэгтэй; соплеменные народы нэг угсааны ард түмэн.

**СО'ПЛИ**, -ей, ед, -я, -и, ж. (прост.). нус.

**СОПЛИ'ВЫЙ**, -ая, -ое; -ив (прост.). нустай, нусгай.

**СОПОДЧИНЕ'НИЕ**, -я, ср. 1. нэг захиргаатай болгох, нэг . . . захируулах; 2. зэрэгцүүлэн захируулах, зэрэгцэн хавсрах.

**СОПОДЧИНЕ'ННЫЙ**, -ая, -ое. зэрэгцүүлэн захируулсан, зэрэгцэн хавсарсан; соподчинённые придаточные предложения зэрэгцэн хавсарсан өгүүлбэр.

**СОПОДЧИ'НТЬ**, -ню, -нишь; -нённый (-ён, -ена), сов., кого что кому-чему (книжн.), **СОПОДЧИ'НЯТЬ**, -яю, -яешь; несов. 1. нэг захиргаатай болгох, нэг . . . захируулах; соподчинить все районы центру

Сүх нутгийг нэг төвд захируулах; 2. зэрэгцүүлэн захируулах; зэрэгцүүлэн хавсаргах; соподчинить предложения главному хэдэн хавсарсан өгүүлбэрийг нэг гол өгүүлбэрт зэрэгцүүлэн хавсаргах.

**СОПОСТАВИМЫЙ**, -ая, -ое; -и.м. жишиж болох, харьцуулж болмоор, зэрэгцүүлсэн; сеп ставимые понятия жишиж болох ухагдахуун.

**СОПОСТАВИТЕЛЬНЫЙ**, -ая, -ое, -елен. зэрэгцүүлсэн; сопоставительная грамматика зэрэгцүүлсэн хэл зүй.

**СОПОСТАВИТЬ**, -аю, -вишь; -вляемый; сов., кого-что и кого-чего с кем-чем. жишиж үзэх, харьцуулах, зүйрлэж үзэх, зэрэгцүүлэн үзэх, жишээлж үзэх; сопоставить мнения различных учёных янз бүрийн эрдэмтний саналыг зэрэгцүүлэн үзэх.

**СОПОСТАВЛЕНИЕ** -я, ср. жишиж үзэх, харьцуулах, зэрэгцүүлэн үзэх, жишээлж үзэх, жишилт, зэрэгцүүлэлт, жишээлэлт; сопоставление показаний свидетелей гэри нарын мэдүүлгийг зэрэгцүүлэн үзэх.

**СОПОСТАВЛЯТЬ**, -яю, -яешь; несов. жишиж үзэх, харьцуулах, зүйрлэж үзэх, зэрэгцүүлэн үзэх, жишээлж үзэх.

**СОПОСТАВЛЯТЬСЯ**, -ется, несов. жишигдэх, харьцуулагдах, зүйрлөгдөх.

**СОПРАНО**, нескл., ср. 1. сопрано, тунгалаг хоолой э мэгтэй хүний нарийн хоолой; 2. сопрано, нарийн хоолойтой эмэгтэй.

**СОПРЕДЕЛЬНЫЙ** -ая, -ое; -лен, -льна (книжн.) кнл залгаа, зэрэгцээ; сопредельные страны хил залгаа улс; сопредельные понятия зэрэгцээ ухагдахуун.

**СОПРЕТЬ**, -еет; сов. ялрах, гутах, чийг дарах, нойт оргих; сено сопрело под дождём өвс бороонд норж ялзарчээ.

**СОПРИКАСАТЬСЯ**, -аюсь, -аешься; несов., с кем-чем. 1. (хил) нийлэх, залгах; 2. хүрэх, хавирах, хүрэлцэх; 3. хавирах; нийлэх; наши интересы ни в чём не соприкасаются бидний эрх ашиг юугаар ч хавирдаггүй; 4. харилцах; соприкасаться с различными людьми янз бүрийн хүнтэй харилцах.

**СОПРИКОСНОВЕНИЕ**, -я, ср. 1. (хил) залгах, нийлэх; 2. хавиралдах, харгалдах; войти в соприкосновение с противником дайсантай хавиралдах; 3. харилцах, харилцаа, холбоо; у нас с ним нет никаких точек соприкосновения бид түүнтэй ямар ч холбоо байхгүй.

**СОПРИКОСНУТЬСЯ**, -нусь, -нешься; сов. хүрэлцэх, хавирах.

**СОПРИЧАСТНЫЙ**, -ая, -ое; -тен, -тна, чему (книжн.). холбогдол бүхий, хамаа бүхий.

**СОПРОВОДИТЕЛЬНЫЙ**, -ая, -ое (офиц.). дагалт, сопроводительное письмо дагалт бичиг.

**СОПРОВОДИТЬ**, -ожу, -одишь; -ождённый (-ден, -дена); сов. хавсаргах; сопроводить заявление соответствующими документами өргөдөлд зохих баримт бичиг хавсаргах.

**СОПРОВОЖДАТЬ**, -аю, -аешь; несов. 1. хавсаргах; 2. хүргэх, дагах, дагалдах, бараа болох; сопроводить арестованных баривчлагдасдыг хүргэх; 3. дуугуулах, хавсаргах; сопроводжать пение музыкой дуу дуулахад хөгжим хавсаргах.

**СОПРОВОЖДАТЬСЯ**, 1 и 2 л. не употр., -ается; несов., чем (книжн.). 1. зэрэгцэх, дагалдах; дождь сопровождался грозой бороотой зэрэгцэн тэнгэр дуугарав; 3. хавсаргах; некоторые места текста сопровождаются примечаниями эз бичгийн зарим газар тайлбар хавсаргана.

**СОПРОВОЖДЕНИЕ**, -я, ср. 1. хүргэх, дагах, дагалдах, дагуулах, хавсаргах; в сопровождении друзей нөхдөө дагуулан; 2. хамтруулах; музыкальное сопровождение хөгжим хамтруулах.

**СОПРОТИВЛЕНИЕ**, -я, ср. 1. эсэргүүцэх, эсэргүүцэл; оказывать сопротивление врагу дайсанд эсэргүүцэл үзүүлэх, дайсныг эсэргүүцэх; 2. эсэргүүцэл; электрическое сопротивление цахилгаан эсэргүүцэл; ☆ по линии наименьшего сопротивления хялбарыг харж.

**СОПРОТИВЛЯЕМОСТЬ**, -и, ж. эсэргүүцэл, эсэргүүцэх чадал, эсэргүүцэх чанар; сопротивляемость организма болезням бие махбодын өвчин эсэргүүцэх чадал.

**СОПРОТИВЛЯТЬСЯ**, -яюсь, -яешься; несов., кому-чему. эсэргүүцэх.

**СОПРЯЖЁННЫЙ**, -ая, -ое; -ён, -ена; с чем (книжн.), холбоотой, -тай (-тэй, -той.) байх; путь сопряжённый с опасностью аюултай зам.

**СОПУТСТВОВАТЬ**, -твую, -твуеть; несов. дагах, дагалдах; сопутствовать в прогулке зугаацаар явахад дагах.

**СОПУТСТВУЮЩИЙ**, -ая, -ее. дагалдан гарах; сопутствующие обстоятельства дагалдан гарах учир байдал.

**СОП**, -а (-у), м. 1. хог, хог шороо; вымести сор из комнаты тасалгааны хогийг шүүрдэн гаргах; 2. дэмий юм, хэрэггүй юм; в его сочинениях много сор, түүний зохиолд хэрэггүй юм их бий; ☆ не выноси-сор из избы хүнд муугаа харуулахгүй байх.

**СОРАЗМЕРИТЬ**, -рю, -ришь; -ренный; сов. чт-чем, тааруулах, зохицуулах, тэнцүүлэх; соразмерить затраты с доходами зардлыг орлоготой тааруулах.

**СОРАЗМЕРНО**, нагет. тааруулан, зохицуулан.

**СОРАЗМЕРНОСТЬ**, -и, ж. хэмжээ таарах, хэмжээ зохицох.

**СОРАЗМЕРНЫЙ** -ая, -ое; -рен, -рна. хэмжээ таарсан, хэмжээ зохицох; траты, соразмерные заработку авах хөлтэй хэмжээ зохицох зардал, олонтойгоо зохицуулан зарах.

**СОРАЗМЕРЯТЬ**, -яю, -яешь; несов. тааруулах, зохицуулах, тэнцүүлэх.

**СОРАЗМЕРЯТЬСЯ**, -яюсь, -яешься; несов. таарах, зохицох.

**СОРАТНИК**, -а, м. (высок.). хамт зүтгэгч.

**СОРВАНЕЦ**, -нца, м. (разг.). дүрсгүй хүүхэд, томоогүй жаал.

**СОРВАТЬ** I, -ву, -вёшь; -ал, -ала, -ало; сорванный; сов., что. 1. таслах, тас татах, зулгаах, хуулах, хуу татах; сорвать цветок цэцэг зулгаах; сорвать ветку мөчир тас татах; ветер сорвал шапку салх малгай хуу татав; 2. тайлах, гаргах; сорвать на ком-либо свой гнев уураа хүнд гаргав.

**СОРВАТЬ** II, -ву, -вёшь; -ал, -ала, -ало; сорванный; сов., что. тасалдуулах, саатуулах, эвдэх, алдагдуулах; сорвать занятия хичээл тасалдуулах.

**СОРВАТЬСЯ** I, -аюсь -вёшьясь; -ался, -алась -алось (и-алось); сов. 1. мултрах, алдуурах; дверь сорвалась с петель хаалга нугасаагаа мултрав; 2. босон харайх; сорваться с места суудлаасаа босон харайх; 3. унах; сорваться с вершины скалы кадны оройгоос унах; 4. үг алдах, санамсаргүй хэлчлэх; слово сорвалось с языка санамсаргүй үг хэлчлэв.

**СОРВАТЬСЯ** II, 1 и 2 л. не употр., -ается; -ался -алась, -алось; сов. тасалдах, эс бүтэх; дело сорвалось хэрэг эс бүтэв.

**СОРВИГОЛОВА**, -ы, вин. сорвиголову, м. и ж. (разг.). дөргүй амьтан, галзуу амьтан, галзуу тархи.

**СОРГАНИЗОВАТЬ**, -зую, -зуеть; сов., сорганизовать, -ую, -авшь; несов., кого-что. 1. эс

байгуулах, эмхлэн байгуулах, байгуулах; 2. зохион байгуулах, эмхлэх, явуулах, үзүүлэх; *хамт хэрэгдэх нэр үгийг үйл үгийн үйлдүүлэх хэв болгоно*; 3. зохион байгуулах, нэгтгэх; 4. эмхлэх, цэгцлэх, эмх журамтай болгох.

**СОРЕВНОВАНИЕ**, -я, ср. 1. уралдаан; социалистическое соревнование социалист уралдаан; вызвать на соревнование уралдаанд уриалах; 2. тэмцээн, уралдаан; спортивные соревнования спортын тэмцээн; соревнование в стрельбе буудлагын тэмцээн.

**СОРЕВНОВАТЬСЯ**, -нурьс-, -нуешься; несов., с кем. 1. уралдах; 2. тэмцэх, уралдах.

**СОРИНКА**, -и, ж. шороо, юм; **вынуть соринку** из глаза нүдэнд орсон юмыг авах.

**СОРИТЬ**, -рю-, -ришь; несов. 1. хог тарих, хог шороо болгох; сорить в комнате тасалгээнд хог шороо болгох; 2. үрэх; сорить деньгами мөнгө үрэх.

**СОРНЫЙ**, -ая, -ое. 1. хогийн, хог шороон; сорный ящик хогийн хайрцаг; 2. хог, ээрлэг; сорная трава хог өвс.

**СОРНЯК**, -а, м. хог ургамал, зэрлэг ургамал.

**СОРОГА**, -и, ж. мөнгөн сугас (*сагас*), ялаагана

**СОРОДИЧ**, -а, м. 1. хамаатан; 2. нэг нутгийн хүн

**СОРОК**, сорока, числит. дөч.

**СОРОКА**, -и, ж. шаазгай.

**СОРОКАГРАДУСНЫЙ**, -ая, -се. дөчин градусын; сорокаградусный мороз дөчин градусын хүйтэн.

**СОРОКАЛЕТНИЕ**, -я, ср. 1. дөчин жил; 2. дөчин жилийн ой.

**СОРОКАЛЕТНИЙ**, -яя, -ее. 1. дөчин жилийн; сорокалетняя годовщина дөчин жилийн ой; 2. дөчин насны, дөчин настай, дөчтэй; сорокалетний юбилей дөчин насны ой; сорокалетний мужчина дөчин настай хүн.

**СОРОКОВОЙ**, -ая, -ое. дөчдүгээр, дөчдөх, дөчин. дөчний.

**СОРОКОНОЖКА**, -и, ж. жаран хөлт.

**СОРОКОПУТ**, -а, м. хөхөл (*шувуу*), хөхийд, дунхай.

**СОРОЧИЙ**, -ья, -ье. шаазгайн; сорочьи яйца шаазгайн өндөг.

**СОРОЧКА**, -и, ж. цамц, хийлэг.

**СОРТЬ**, -а, мн. -а, -ов, м. зүйл, төрөл, зэрэг, -дугаар (*дүгээр*), табак первого сорта тэргүүн зэргийн тамхи; высший сорт дээд зэрэг; мука первого сорта нэгдүгээр гурил.

**СОРТИМЕНТ**, -а, м. зүйл бүр, төрөл бүр; сортимент листовой стали зүйл бүрийн гөлөм болд.

**СОРТИРОВАЛЬНЫЙ**, -ая, -ое. ялгах; сортировальная машина ялгах машин.

**СОРТИРОВАНИЕ**, -я, ср. ялгах, ялгалт, дугаарлах, дугаарлалт.

**СОРТИРОВАТЬ**, -рую-, -руешь; сованный; несов., что. ялгах, дугаарлах; сортировать товар бараа дугаарлах.

**СОРТИРОВАТЬСЯ**, 1 и 2 л. не употр. -втся; несов. ялгахдаг, дугаарлахдаг, ялгах, дугаарлах.

**СОРТИРОВАКА**, -и, ж. 1. ялгах, дугаарлах, ялгалт, дугаарлалт; 2. ялгах машин, ялгуур машин.

**СОРТИРОВОЧНЫЙ**, -ая, -ое. 1. ялгах, дугаарлах; сортировочная машина ялгах машин; 2. сортировочная ялгах өртөө.

**СОРТИРОВЩИК**, -а, м. ялгагч.

**СОРТИРОВЩИЦА**, -ы, ж. ялгагч эмэгтэй.

**СОРТНОСТЬ**, -и, ж. (*спец.*) зэрэг дугаар; определение сортности семян үрийн зэрэг дугаарыг тодорхойлох.

**СОРТНЫЙ**, -ая, -ое. (*спец.*) дээд зэргийн, зэрэг дугаар сайтай, сайн чанарын; сортный товар зэрэг дугаар сайтай бараа.

**СОРТОВОЙ**, -ая, -ое. зэрэг эзлэх, зэрэгт орох, ялгамал, шилмэл; сортовое железо шилмэл төмөр, **СОРТОВЫСПЫТАНИЕ**, -я, ср. (*үрийн*) зэрэг дугаарыг шалгах, чанарыг тодорхойлох.

**СОРТОВЫСПЫТАТЕЛЬНЫЙ**, -ая, -ое. (*үрийн*) зэрэг дугаарыг шалгах, чанарыг тодорхойлох; сортоиспытательные участки (*үрийн*) зэрэг дугаарыг шалгах газар, чанарыг тодорхойлох газар.

**СОСАТЬ**, -су-, -сешь; *сосанный; несов., что.* 1. хөхөх, сорох, шимэх; сосать грудь матери эхийн хөх хөхөх; 2. шимэх, хүлхэх; сосать сахар чихэр шимэх; 3. сорох, татах, татуулах, соруулах; 4. эмэлэх, шаналах; тоска сосёт сердце гуниглаж, зүрх сэтгэл эмэлнэ; 5. харлах; под ложечкой сосёт доктор харлана.

**СОСВАТАТЬ**, -аю-, -аешь; сов. хадамнах, ураг болох.

**СОСЕД**, -а, мн. -и, -ей, -ям, м. айлын хүн, хөрш.

**СОСЕДИТЬ**, 1 л. ед. не употр., -ишь; *несов., с кем-чем (устар.)* айл суух, хөрш байх, саахалт суух, зэргэлдээ орших; Монголия соседит с СССР Монгол улс ЗСБНХУ-тай зэргэлдээ оршино.

**СОСЕДКА**, -и, ж. айлын эмэгтэй, хөрш эхнэр.

**СОСЕДНИЙ**, -яя, -ее. айл, хөрш, саахалт, зэргэлдээ; соседние страны зэргэлдээ улс орон; соседняя квартира хөрш байр.

**СОСЕДСКИЙ**, -ая, -ое. айлынхны, айлын, хөршийн, саахалтын, айл хунарын; соседские дети айлынхны хүүхдүүд.

**СОСЕДСТВО**, -а, ср. айл, саахалт, хөрш байх; жить по соседству айл суух.

**СОСИСКА**, -и, ж. зайдас.

**СОСКА**, -и, ж. хөхөлт, угж.

**СОСКАБЛИВАТЬ**, -аю-, -аешь; *несов.* хусах, харах.

**СОСКАКИВАТЬ**, -аю-, -аешь; *несов.* 1. буун харайх, үсрэн буух, дэвхрэх; 2. мултрах, мултран унах.

**СОСКАЛЗЫВАТЬ**, -аю-, -аешь; *несов.* 1. мулгарч унах, мултарч ойчих; 2. гулгаж буух, хальтран буух.

**СОСКОБЛИТЬ**, -облю-, -облишь (*и -облишь*); *-облennyй; сов., что.* хусах, харах; соскоблить старую краску со стены туурганы хуучин будгийг хусах.

**СОСКОБЛИТЬСЯ**, -лится; *сов.* хусагдах.

**СОСКОЛЬЗНУТЬ**, -ну-, -нётся; *сов.* 1. мултран унах, мултран ойчих; 2. гулгаж буух, хальтран буух.

**СОСКОЧИТЬ**, -очу-, -очишь; *сов.* 1. буун харайх, үсрэн буух, дэвхрэх; соскочить с края морин дээрээ үсрэн буух; 2. мултрах, мултран унах; дверь соскочила с петель хаалга нугаснаасаа мултран.

**СОСКРЕБАТЬ**, -аю-, -аешь; *несов.* **СОСКРЕСТИ**, -ребу-, -ребьшь; -рбб-, -ребла-, -ребьяный (-ян, -ена); *сов., что.* хусах, харах, арилгах.

**СОСКУЧИТЬСЯ**, -чусь-, -чишься; *сов.* уйдах, уйтгарлах, санах; соскучиться в одиночестве ганцаараа уйдах; соскучиться по отцу эцгийгээ санах, авьгаа санах.

**СОСЛАГАТЕЛЬНЫЙ**, -ая, -ое; *сослагательное* наклонение болзох төлөв.

**СОСЛАТЬ**, *сошлю-, сошлешь; сосланный; сов., кого (что).* цөлөх.

**СОСЛАТЬСЯ**, *сошлюсь, сошлешься; сов., на кого-что.* шалтаг заах, шалтаглах, иш татах, нэр барих; сослаться на болезнь өвчнөөр шалтаглах; сослаться на какую-либо книгу нэг номоос иш татах; сослаться на авторитетного учёного алдар хүндтэй эрдэмтний нэрийг барих.

**СО'СЛЕПА** и **СО'СЛЕПУ**, нареч. (разг.). хараа муутайдаа, сохортоо; **сослепу** натолкнуться на стену хараа муутайдаа туурга мөргөх.

**СОСЛО'ВНЕ**, -я, ср. язгуур, язгуур угсаа, угсаа, язгуур угсаа ялгаварлах, угсаа ялгаварлах; Великая Октябрьская социалистическая революция упряднила все сословия Октябрьный социалист их хувьсгал язгуур угсаа ялгаварлахыг устгасан юм.

**СОСЛО'ВНЫЙ**, -ая, -ое. язгуурын, язгуур угсааны, угсааны; **сословное неравенство** язгуур угсааны тэгш бус байдал.

**СОСЛУЖИ'ВЕЦ**, -вца, м. хамт алба хаагч.

**СОСЛУЖИ'ТЬ**, -ужу, -ужишь; сов.; **сослужить службу** тус болох, тус хүргэх.

**СОСНА'**, -ы, мн. сосны, сосен, ж. нарс.

**СОСНО'ВЫЙ**, -ая, -ое. 1. нарсны, нарсан; **сосновые шишки** нарсны боргоцой; **сосновое масло** нарсны тос; **сосновые дрова** нарсан түлээ; 2. нарсан, нарснаас бүрдсэн; **сосновый бор** нарсан ой; 3. нарсан, нарсаар хийсэн; **сосновая мебель** нарсан тавил.

**СОСНУ'ТЬ**, -ну, -нѣшь; сов. (разг.). дугхийх, зүүрмэглэхийх; **соснуть часок** цагхан дугхийх, ганцан цаг дугхийх.

**СОСНЯ'К**, -а, м. нарсан ой.

**СОСО'К**, -ска, м. хөхний товч, (амьтны) хөх.

**СОСРЕДОТО'ЧЕНИЕ**, -я, ср. бөөгнөрүүлэх, хуралдуулах; **сосредоточение сил** хүчээ хуралдуулах.

**СОСРЕДОТО'ЧЕННО**, нареч. маш анхааралтай, анхаарлаа төвлөрүүлэн, шаргуу.

**СОСРЕДОТО'ЧЕННОСТЬ**, -и, ж. их анхааралтай (байх), шаргуу (байх).

**СОСРЕДОТО'ЧЕННЫЙ**, -ая, -ое; -чен, -ченна. 1. бөөгнөрсөн, хуралдсан, бөөгнөрүүлсэн, хуралдуулсан; **силы противника, сосредоточенные на правом фланге** дайсны баруун жигүүрт хуралдсан хүч; 2. маш анхааралтай, ширтсэн, төвлөрүүлсэн, нэг юманд хандуулсан; **сосредоточенный взгляд** маш анхааралтай харц; **сосредоточенное внимание** шаргуу анхаарал.

**СОСРЕДОТО'ЧИВАТЬ**, -аю, -аешь; несов. 1. бөөгнөрүүлэх, хуралдуулах; 2. төвлөрүүлэх, чиглүүлэх, хандуулах.

**СОСРЕДОТО'ЧИВАТЬСЯ**, -аюсь -аешься; несов. 1. бөөгнөрөх, хуралдах; 2. төвлөрөх, чиглэх, хандах.

**СОСРЕДОТО'ЧИТЬ**, -чу, -чишь; -оченный; сов. 1. бөөгнөрүүлэх, хуралдуулах; **сосредоточить войска в пограничной зоне** хилийн бүсэнд цэрэг бөөгнөрүүлэх; 2. төвлөрүүлэх, чиглүүлэх, хандуулах; **сосредоточить внимание на чём-либо** юманд анхаарлаа төвлөрүүлэх.

**СОСРЕДОТО'ЧИТЬСЯ**, -чусь, -чишься; возвр. 1. бөөгнөрөх, хуралдах; 2. төвлөрөх, чиглэх, хандах; **вся его любовь сосредоточилась на ребёнке** хамаг кайр сэтгэл нь хүүхдэдээ ханджээ; 3. бодлоо төвлөрүүлэх, анхаарлаа төвлөрүүлэх; **шум мешал сосредоточиться** шуугиан анхаарлаа төвлөрүүлэхэд саад болов.

**СОСТА'В**, -а, м. 1. бүрэлдэхүүн; **классовый состав общества** нийгмийн ангийн бүрэлдэхүүн; **в составе комиссии** проишлои изменения комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оров; **словарный состав русского языка** орос хэлний үгсийн бүрэлдэхүүн; 2. найраг, найруулсан юм, найрлага, хөд, зай; **лекарственные составы** эмийн хөд, эмийн найрлага, найруулсан эм; **химический состав химийн найраг**; 3. бүрэлдэхүүн; **олон тооны дагавар**; **офицерский состав** офицерын бүрэлдэхүүн, офицерууд; 4. бүрэлдэхүүн; галт тэрэг; **подвижный состав** хөдлөх бүрэлдэхүүн; **пассажирский состав** суудлын галт тэрэг; ☆ **в составе** бүрэлдэхүүнтэй, бүрдсэн, -тай, (-тэй, -той); **комиссия в составе трех человек** гурван хүнээс

бүрдсэн комисси, гурван хүнтэй комисси; **состав пресупления** гэмт хэргийн бүрэлдэхүүн, үйлдсэн гэмт хэрэг.

**СОСТАВИ'ТЕЛЬ**, -я, м. эмхтгэгч, зохиогч, эмхлэгч; **составитель учебника** сурах бичиг зохиогч; **составитель поездов** галт тэрэг эмхлэгч.

**СОСТА'ВИТЬ I**, -влю, -вишь; -вленный; сов., что. 1. эмхлэх, эвлүүлэх, угсрах; **составить два стола** хоёр ширээ зэрэгцүүлэн тавих; 2. найруулах; **составить лекарство** эм найруулах; 3. бүрдүүлэх, зохион байгуулах; **составить общество** нийгэмлэг бүрдүүлэх; 4. -тай (-тэй, -той) болох, буй болгох, байгуулах; **составить имущество** хөрөнгө хогшилтой болох; **составить библиотеку** номын сан байгуулах; 5. эмхтгэгч, боловсруулах, зохиох, хийх, бичих, тавих; **составить сюжет** статей өгүүллэйн эмхтгэл хийх; **составить проект** төсөл боловсруулах; **составить словарь** толь зохиох; 6. болох, хүрэх; **все эти расходы** составят не больше тысячи рублей энэ бүх зарлага мянган төгрөгөөс илүү болохгүй; 7. болох, төрөх; **составить мнение о ком-либо** хүний тухай бодол төрөх; 8. болох, байх; **составить затруднение** бэрхшээл болох.

**СОСТА'ВИТЬ II**, -влю, -вишь; -вленный; сов., что. тавих, бөөгнүүлэн тавих; **составить кастрюлю** со стола сав суулгыг ширээн дээрээс бөөгнүүлэн авч тавих.

**СОСТА'ВИТЬСЯ I и 2 л. не употр., -ится; сов. (книжн.).** 1. байгуулагдах, буй болох, бүрэлдэх, бүрдэх; **составилась комиссия** комисси байгуулагдав; 2. цуглах, хуралдах, хуримтлах; **составилась значительная сумма денег** нэлээд их мөнгө хуримтлав; 3. төрөх, гарах; **составилось определенное мнение** тодорхой бодол төрөв.

**СОСТАВЛЕ'НИЕ**, -я, ср. эмхтгэх, боловсруулах, зохиох, бичих; **составление учебника** сурах бичиг зохиох.

**СОСТАВЛЯ'ТЬ**, -яю, -яешь; несов. 1. эмхлэх, эвлүүлэх, угсрах, зэрэгцүүлэн тавих; 2. найруулах; 3. бүрдүүлэх, зохион байгуулах; 4. -тай (-тэй, -той) болгох, буй болгох, байгуулах; 5. эмхтгэх, боловсруулах, зохиох, хийх, бичих; 6. болох, хүрэх; 7. болох, төрөх; 8. болох, байх.

**СОСТАВЛЯ'ТЬ II**, -яю, -яешь; несов. авч тавих, буулган тавих.

**СОСТАВЛЯ'ТЬСЯ**, -яется; несов. 1. байгуулагдах, буй болох, бүрэлдэх, бүрдэх; 2. цуглах, хуралдах, хуримтлах; 3. төрөх, гарах.

**СОСТАВНО'Й**, -ая, -ое. 1. эвлүүлэн хийсэн, хэдэн хэсгээс бүтсэн, эвхдэг; **составная лестница** эвхдэг шат; 2. бүрэлдэхүүний, найрлагын, (бүрэлдэхүүн, найрлагат) ордог; **составной элемент** химического соединения химийн нийлэлд ордог зүйл.

**СОСТА'РИТЬ**, -рю, -ришь; сов. өглүүлэх, хөгшрүүлэх, өвгөрүүлэх.

**СОСТА'РИТЬСЯ**, -рюсь, -ришься; сов. өглөх, хөгшрөх, өвгөрөх.

**СОСТОЯ'НИЕ**, -я, ср. 1. байдал; **состояние промышленности** үйлдвэрийн байдал; **состояние здоровья** биеийн байдал, биеийн эрүүд мэнд; **состояние погоды** тэнгэрийн байдал; 2. байх; **состояние** тоски гунигтай байх; 3. хөрөнгө, чадал чинээ; ☆ **быть в состоянии** чадалтай байх, чадах; **сейчас я не в состоянии** чигатъ одоо над юм унших чадал алга.

**СОСТОЯ'ТЕЛЬНОСТЬ**, -и, ж. 1. нотолгоо, үндэслэл, нотолгоотой эсэх; **проверить состоятельность теории** онол нь үндэслэлтэй эсэхийг шалгах; 2. чинээлэг байх, чадал чинээ, хөрөнгө чинээ.

**СОСТОЯТЕЛЬНЫЙ**, *-ая, -ое; -лен, -льна*. 1. но тогтоотой, үндэслэлтэй; 2. чинээлэг, чадал чинээтэй, хөрөнгөтэй.

**СОСТОЯТЬ**, *-ою, -оишь; несов.* 1. бүрдэх, бүрэлдэх, бүрэлдэн тогтох; капиталистическое общество состоит из антагонистических классов капиталист нийгэм эсрэг тэсрэг ангиас бүрэлдэн тогтоно; 2. орших, байх; вот в чём состоит вся трудность хамар бэрх чухам үүнд оршино; 3. байх, хүлээх, хаах; состоять членом научного общества шинжлэх ухааны нийгэмлэгийн гишүүн байх; состоять в должности заведующего эрхлэгчийн тушаал хүлээх.

**СОСТОЯТЬСЯ**, *1 и 2 л. не употр., -оится* сов. болох, -тай (*-тэй, -той*); лекция состоится в девять часов есөн цагт лекцитэй.

**СОСТРАДАНИЕ**, *-я, ср.* нигүүлсэх, энэрэх, өрөвдөх, нигүүлсэл, энэрэл, өрөвдөх сэтгэл; возбудить в ком-либо сострадание хүнд өрөвдөх сэтгэл төрүүлэх.

**СОСТРАДАТЕЛЬНОСТЬ**, *-и, ж.* нигүүлсэнгүй сэтгэл, энэрэнгүй (*байх*.)

**СОСТРАДАТЕЛЬНЫЙ**, *-ая, -ое, -лен, -льна*. нигүүлсэнгүй, энэрэнгүй, өр нимгэн, өрөвдөх сэтгэлтэй.

**СОСТРИГАТЬ**, *-аю, -аешь; несов.* хяргах, хайчлах. үс хайчлах.

**СОСТРИТЬ**, *-рю, -ришь; сов.* уран үг хэлэх.  
**СОСТРИЧЬ**, *-игу, -ижшь, -игут; -иг, -игла; -иженный; сов.* что хяргах, хайчлах; **состричь волосы** үс хайчлах.

**СОСТРОГАТЬ**, *-аю, -аешь; -оганный; сов., что* карах, зорох.

**СОСТРОГАТЬСЯ**, *-ается, сов.* зорогдох.

**СОСТРОИТЬ**, *-ою, -оишь; -оенный сов.;* сооронить гожу нүүр амаа муруйлгах

**СОСТРЯПАТЬ**, *-аю, -аешь; -анный; сов. 1. (хоол)* кийх, тогоо барих; **состряпать обед** хоол хийх; 2. кийгчээн болох, оромдох, аргацаах.

**СОСТЯЗАНИЕ**, *-я, ср.* тэмцээн, уралдаан, тэмцэх, уралдах; состязание в беге явган уралдах, явган уралдаан; конькобежные состязания тэшүүрийн тэмцээн, тэшүүрээр уралдах.

**СОСТЯЗАТЬСЯ**, *-аюсь, -аешься; несов., с кем в чем.* тэмцэх, уралдах, тэмцэлдэх, булаалдах; **состязаться в плавании** сэлж уралдах; **состязаться в строумнии** цец булаалдах.

**СОСУД I**, *-а, м.* сав.

**СОСУД II**, *-а, м.* судас; **кровеносный сосуд** цусны судас.

**СОСУДИСТЫЙ**, *-ая, -ое.* судаст, судасны, судсан; **сосудистая оболочка глаза** нүдний судаст бүрхэвч; **сосудистое сплетение судсан** сүлжээ; **сосудистый жёлоб** судасны ховил.

**СОСУЛЬКА**, *-и, ж.* соёо, унжсан мөс, хонгорцог; **ледяная сосулька** соёо мөс, унжсан мөс.

**СОСУН**, *-а, м.* хөхүүл, эхийгээ хөхдөг, хөхнөөс гараагүй; **жеребёнок-сосун** эхийгээ хөхдөг унага.

**СОСУЩЕСТВОВАНИЕ**, *-я, ср.* хамт байх, зэрэгцэн орших; **мирное сосуществование** энх тайвнаар зэрэгцэн орших.

**СОСУЩЕСТВОВАТЬ**, *-твую, -твуеть; несов. (книжн.)* хамт байх, зэрэгцэн орших.

**СОСЧИТАТЬ**, *-аю, -аешь; сов.* тоолох.

**СОСЧИТАТЬСЯ**, *-аюсь, -аешься; сов. 1.* тооцоо хийх, өр ширгүй болох; 2. өшөө авах.

**СОСЧИТЫВАТЬ**, *-аю, -аешь; несов.* тоолох.

**СОСЧИТЫВАТЬСЯ**, *-аюсь, -аешься; несов., с кем в чем.* 1. тооцоо хийх, өр ширгүй болох; 2. өшөө авах.

**СОТВОРЕНИЕ**, *-я, ср.* бүтээх, зохиох, бүтээлт.

**СОТВОРИТЬ**, *-рю, -ришь, -рѣнный (-ѣн, -ѣна)* сов. бүтээх, зохиох.

**СОТКАТЬ**, *-тку, -ткѣшь, сотканный; сов.* нэхэх.

**СОТНИК**, *-а, м.* зуутын дарга.

**СОТНЯ**, *-и, род. мн. -тен, ж. 1.* зуун; **сотня яиц** зуун өндөг; 2. зуун төгрөг; 3. сотни өдий төдий, хэдэн зуун; **сотнями** өдий төдийгөөр, хэдэн зуугаар, зуу зуугаар.

**СОТОВЫЙ**, *-ая, -ое.* сархинагийн; **сотовый мёд** сархинагийн бал.

**СОТРУДНИК**, *-а, м.* 1. ажилтан, албан хаагч; **научный сотрудник** эрдэм шинжилгээний ажилтан; 2. хамсан ажиллагч, туслагч.

**СОТРУДНИЦА**, *-ы, ж.* 1. ажилтан эмэгтэй, албан хаагч эмэгтэй; 2. хамсан ажиллагч эмэгтэй, туслагч эмэгтэй.

**СОТРУДНИЧАТЬ**, *-аю, -аешь, несов.* 1. хамтран ажиллах; **сотрудничать со всеми государствами** бүх улстай хамтран ажиллах; 2. ажиллах; **сотрудничать в газете** сонинд ажиллах, **соины** газар ажиллах.

**СОТРУДНИЧЕСТВО**, *-а, ср. 1. (хамтран)* ажиллах; **сотрудничество в журнале** сэтгүүлд ажиллах, сэтгүүлийн газар ажиллах; **сотрудничество с известным учёным** нэрт эрдэмтэнтэй хамтран ажиллах; 2. хамтран ажиллах, хамтын ажиллагаа; **сотрудничество стран социалистического лагеря** социалист лагерийн орнуудын хамтран ажиллах.

**СОТРЯСАТЬ**, *-аю, -аешь, несов.* донсолгох, доргиох, ганхуулах, найгуулах, хөдөлгөх.

**СОТРЯСАТЬСЯ**, *-аюсь, -аешься, несов.* донслох, доргилох, ганхах, найгах, хөдлөх.

**СОТРЯСЕНИЕ**, *-я, ср.* донслох, доргих, ганхах, найгах, хөдлөх, донслолт, доргилт, ганхалт, найгалт, хөдлөлт; **сотрясение мозга** тархи хөдлөх, тархи унах.

**СОТРЯСТИ**, *-су, -сѣшь; -яс, -ясла; -ясѣнный (-ѣн -ѣна)* -ясиш, сов. что донсолгох, доргиох, ганхуулах, найгуулах, хөдөлгөх; **взрыв сотряс воздух** юм тэсэрч агаар донсолгов.

**СОТРЯСТИСЬ**, *-яусь, -ясѣшься, -ясса, -яслась; сов.* донслох, доргих, ганхах, найгах, хөдлөх.

**СОТЫ**, *-ов.* зөгийн сархинаг, уут; **вынимать соты** из улья зөгийн үүрнээс сархинагийг авах.

**СОТЫЙ**, *-ая, -ое.* зуудугаар, зуудахь, зуун, зууны; **пятьдесят три соты** зууны тавин гурав.

**СОУС**, *-а, (-у), м.* сүмс.

**СОУСНИК**, *-а, м.* сүмсийн сав.

**СОУЧАСТВОВАТЬ**, *-ствую, -ствуешь, несов.* в чѣм оролцох, эзлэх, хамсах, хамсааралцах.

**СОУЧАСТНИЕ**, *-я, ср. (офиц.)* оролцох, хамсах, оролцоо, оролцолт, хамааралцах; **соучастие в преступлении** гэмт хэрэгт оролцох.

**СОУЧАСТНИК**, *-а, м. (офиц.)* хамсаа, хамсаатан, хань хамсаа, оролцогч.

**СОУЧАСТНИЦА**, *-ы, ж.* хамсаатан эмэгтэй, хамсаа эхнэр.

**СОУЧЕНИК**, *-а, м., кого и чей (устар.)* хамт суралцагч, хамт суралцсан хүн.

**СОФА**, *-ы, мн.* софы, соф. софам. ж. софаа, өргөн зөөлөн диваан.

**СОФИСТ**, *-а, м. (книжн.).* софист, софизмыг баримтлагч.

**СОФИЗМ**, *-а, м. (книжн.).* софизм (*өнгөцхөн үгдэхэд өв мэт боловч, үнэндээ зориуд хуурмаг баримт хэрэглэн хийсэн дүгнэлт*).

**СОФИСТИКА**, *-и, ж.* хуурмаг баримт хэрэглэх.

**СОФИСТИЧЕСКИЙ**, *-ая, -ое.* хуурмаг баримт хэрэглэсэн, хуурмаг баримт үндэслэсэн.

**СОХА**, *-и, мн.* сохи, сох, сохам, ж. модон вѣжис.

**СОХАТЫЙ**, *-ого, м.* хандгай.

**СОХНУТЬ**, -ну, -нешь; *сох* (и *сохнул*); *сохла*; *несов.* 1. хатах, эврэх, эгших; *бельё сохнет* дотуур *кувчас хатаж байна*; 2. гандах, хагдрах; *трава сохнет* ногоо гандаж байна; 3. хагах, хатагнрах; *сохнуть* от тоски гуниглаж хатагнрах.

**СОХРАНЕ'НИЕ**, -я, *ср.* хамгаалах, сахиу, хадгалах; *сохранение мира* энх тайвныг сахиу.

**СОХРАНИ'ТЬ**, -ню, -нишь, -нённый (-ён, -ена); *сов.* 1. гамнах, нөөх, хадгалах, үлдээх; *сохранить имущество* эд хөрөнгөө хадгалах, нөөх; 2. хамгаалах, сахиу; *сохранить спокойствие* амгалан байдлыг сахиу; 3. (хэвээр) үлдээх, нөөх; *сохранить хорошие обывай сайн заншил хэвээр үлдээх.*

**СОХРАНИ'ТЬСЯ**, -нюсь, -нишья, *сов.* 1. хэвээр үлдэх, хэвээр байх; *дом хорошо сохранился* байшин сайн хэвээр байна; 2. хадгалагдах, үлдэх; *память о Ленине сохраняется в веках* Лениний дурсгал үеийн үед хадгалагдана; 3. яригаараа байх; *несмотря на свои шестьдесят лет, он хорошо сохранился* жар дурсан Соловч яригаараа байна.

**СОХРА'НОСТЬ**, -и, *ж.* 1. бүтэн байлгах, хэвээр хадгалах; 2. гэмтэлгүй байлгах; *сохранность продуктов* идэвхийн вуйлийг гэмтэлгүй байлгах.

**СОХРА'ННЫЙ**, -ая, -се, -анен, -анна. 1. нууц; *спрятать в сохранном месте нууц газар* хадгалах; 2. бүтэн байлгах, хадгалах; *сохранная расписка* хадгалсны баримт.

**СОХРА'НЯ'ТЬ**, -яю, -яешь *несов.* 1. гамнах, нөөх, хадгалах, үлдээх; 2. хамгаалах, сахиу; 3. хэвээр үлдээх, нөөх.

**СОХРА'НЯ'ТЬСЯ**, -яюсь, -яешься, *несов.* 1. хэвээр үлдэх, хэвээр байх, 2. хадгалагдах, үлдэх; 3. яригаараа байх.

**СОЦВЕ'ТИЕ**, -я, *ср.* баг цэцэг.

**СОЦДО'ГОВОР**, -а, *м.* (договор о социалистическом соревновании) социалист уралдааны гэрээ.

**СОЦИА'Л-ДЕМОКРА'Т**, -а, *м.* социал-демократ (социал-демократ намын гишүүн).

**СОЦИА'Л-ДЕМОКРАТИ'ЗМ**, -а, *м.* социал-демократизм.

**СОЦИА'Л-ДЕМОКРАТИ'ЧЕСКИЙ**, -ая, -ое. социал-демократ.

**СОЦИА'Л-ДЕМОКРА'ТИЯ**, -и, *ж.* социал, демократ.

**СОЦИАЛИЗА'ЦИЯ**, -и, *ж.* нийгэмчлэх, нийгэмчлэл.

**СОЦИАЛИЗИ'РОВАТЬ**, -рую, -руешь, -анный; *сов. и несов.* что. нийгэмчлэх, нийгмийн өмч болгох.

**СОЦИАЛИЗИ'РОВАТЬСЯ**, 1 и 2 л. не употр., -руется; *сов. и несов.* 1. нийгмийн болгох; 2. нийгэмчлэгдэх.

**СОЦИАЛИ'ЗМ**, -а, *м.* социализм, нийгэм журам; социализм—первая фаза коммунизма социализм бол коммунизмын анхдугаар шат мөн; построение социализма—социализм байгуулах; победа социализма социализмын ялалт, нийгэм журам ялах; *научный социализм* шинжлэх ухааны социализм.

**СОЦИАЛИ'СТ**, -а, *м.* социалист, нийгэм журамтан (социализмыг баримтлагч; социалист намын гишүүн).

**СОЦИАЛИСТИ'ЧЕСКИЙ**, -ая, -ое. социалист, нийгэм журамт, социализмын, нийгэм журмын; социалистическое строительство социалист байгуулалт, нийгэм журмын байгуулалт; социалистическое государство социалист улс, нийгэм журамт гүрэн; социалистическая революция социалист хувьсгал; социалистическое соревнование социалист уралдаан; социалистическое хозяйство социалист аж ахуй.

**СОЦИАЛИ'СТ-РЕВОЛЮЦИОНЕ'Р**, социалиста-революционера, *м.* социалист-хувьсгалч (народникийн бүлгүүдээс бүрэлдсэн, марксизмд эрс харш, жинж хөрөнгөтөн нударгаан намын гишүүн, энэ нам

хувьсгалын эсэргүү ажилд оролцон, Зөвлөлт засгийг эсэргүүцэн тэмцэж байв).

**СОЦИА'ЛЬНО**, нареч. нийгэмд, нийгмийн талаар; *социально чуждый элемент* нийгэмд харш этгээд.

**СОЦИАЛЬНО-БЫТОВО'Й**, -ая, -ое. нийгэм аж байдлын, нийгэм ахуй байдлын; *социально-бытовые условия* нийгэм аж байдлын нөхцөл.

**СОЦИАЛЬНООПАС'НЫЙ**, -ая, -ое; -сен, -сна. нийгэмд аюултай; *социальноопасный преступник* нийгэмд аюултай хэрэгтэн.

**СОЦИА'ЛЬНО-ПОЛИТИ'ЧЕСКИЙ**, -ая, -ое. нийгэм улс төрийн; *социально-политические отношения* нийгэм улс төрийн харьцаа.

**СОЦИА'ЛЬНО-ЭКОНОМИ'ЧЕСКИЙ**, -ая, -ое. нийгэм эдийн засгийн; *социально-экономические науки* нийгэм эдийн засгийн шинжлэх ухаан.

**СОЦИА'ЛЬНЫЙ**, -ая, -ое. нийгмийн; *социальное происхождение* нийгмийн гарал; *социальное положение* нийгмийн байдал; *социальное обеспечение* нийгмийн хайгэмж.

**СОЦИС'ЛОГ**, -а, *м.* нийгэм судлагч.

**СОЦИОЛО'ГИЯ**, -и, *ж.* нийгэм судлал.

**СОЦСОРЕВНОВА'НИЕ**, -я, *ср.* (социалистическое соревнование) социалист уралдаан.

**СОЦСТРА'Х**, -а, *м.* (социальное страхование) нийгмийн даатгал.

**СОЧЕТА'НИЕ**, -я, *ср.* 1. хослуулах, холбох; *сочетание теории с практикой* онолыг практиктай холбох; 2. нийлэх, зохицох, тохиолдох; *красивое сочетание цветов* олон өнгө сайхан зохицох; *сочетание звуков* авиа нийлэх.

**СОЧЕТА'ТЬ**, -аю, -аешь, *сов. и несов.* что с чем. хослох, холбох, агуулах; *сочетать в себе* разнообразие способности олон янзын авьяас биедээ агуулах.

**СОЧЕТА'ТЬСЯ**, -аюсь, -аешься; *сов. и несов.* 1. нийлэх, хослох; *ум в нём сочетался с храбростью* ухаан, эрэлхэг зориг хосолсон хүн; 2. нийцэх; *зохицох, найралдах, найрах*; *у него слова сочетаются с делом* үг ажил хоёр нь нийцдэг хүн; 3. нийлэх, гэрлэх.

**СОЧИНЕ'НИЕ**, -я; *ср.* 1. зохиох, зохиол бичих; *заниматься сочинением стихов* шүлэг зохиох; 2. зохиол; *собрание сочинений* зохиолын эмхтгэл, сүмбүм; 3. зохион бичих (ажил); *классное сочинение* ангийн зохион бичих ажил; 4. энгийн нийлэх, зэрэгцэн нийлэх, зэрэгцэх; *сочинение и подчинение* преложенин өгүүлдэрүүдийн зэрэгцэх ба хавсрах.

**СОЧИНИ'ТЕЛЬ**, -я, *м.* 1. зохиогч; 2. санаагаараа зохиогч, зохиогоод хэлэгч; *сочинитель* небылиц худал үг санаагаараа зохиогч.

**СОЧИНИ'ТЕЛЬНЫЙ**, -ая, -ое. зэрэгцсэн; *сочинительные союзы* зэрэгцсэн холбоос үг.

**СОЧИНИ'ТЕЛЬСТВО**, -а, *ср.* 1. зохиох, зохиолчийн үг; 2. санаагаараа зохиох, зохиогоод хэлэх.

**СОЧИНИ'ТЬ**, -ню, -нишь, -нённый (-ён, -ена); *сов.* что (разг.). **СОЧИ'НЯ'ТЬ**, -яю, -яешь, *несов.* 1. зохиох, найруулах, бичих; *сочинить стихотворение* шүлэг зохиох; 2. санаагаараа зохиох, зохиогоод хэлэх.

**СОЧИ'ТЬСЯ**, 1 и 2 л. не употр., -ится; *несов.* нэвчих, шүүрэх, дуслах; *кровь сочится из раны* шархнаас цус дуслална; *рана сочится кровью* шархнаас цус шүүрнэ.

**СОЧЛЕНЕ'НИЕ**, -я, *ср.* үе, хэсэглэл.

**СОЧЛЕНИ'ТЬ**, -ню, -нишь, -нённый (-ён, -ена); *сов.* что (книжн.). залгах, нийлүүлэх.

**СОЧЛЕНЯ'ТЬ**, -яю, -яешь; *несов.* залгах, нийлүүлэх.

**СОЧ'НОСТЬ**, -и, *ж.* 1. шүүстэй (байх), шинтэй (байх); *сочность* дыми шүүстэй амтат гуа; 2. онч-

той (байх), хурц (байх); сочность стиля найруулга хурц байх; 3. сонсголонтгой (байх); сочность бас сонсголонтгой аргил хоолой.

**СОЧНЫЙ**, -ая, -ое; -чен, -чна, -чно. 1. шүүстэй, шүүслэг, шингэй; сочное яблоко шүүслэг алим; 2. хурц год, гялалзсан; сочные краски хурц год будаг; 3. ончтой, хурц; сочное выражение ончтой хэллэг; 4. сонсголонтгой; сочный голос сонсголонтгой хоолой.

**СОЧТЕННЫЙ**, -ая, -се; дни его сочтены өдрөө хүлээж байна, цаг нь болсон.

**СОЧУВСТВЕННО**, нареч. 1. өрөвдөн, хайрлан; 2. ойшоон, галархан; сочувственно улынуться талархан инээмсэглэх.

**СОЧУВСТВЕННЫЙ**, -ая, -се; -ен, -енна. 1. өрөвдөнгүй, хөөрхийлсөн, хайрласан; 2. ойшоонгүй, даган баяссан, талархсан; сочувственный отзыв ойшоосон үнээлт.

**СОЧУВСТВЕННЕ**, -я, ср. 1. өрөвдөх, хөөрхийлэх, хайрлах, өрөвч сэтгэл; выражать своё сочувствие өрөвдсөнийгөө илэрхийлэх, хөөрхийлэх; 2. ойшоох, даган баясах, талархах, ойшооц, талархалт; наше предложение вызвало общее сочувствие бидний саналыг бүгд ойшоов.

**СОЧУВСТВОВАТЬ**, -тую, -туюшь; несов., кому-чему. 1. өрөвдөх, хөөрхийлэх, хайрлах; сочувствовать чужому горю гасланд нэрвэгдсэн хүнийг өрөвдөх; 2. ойшоох, даган баясах, талархах; сочувствовать чьему-либо мнению хүний саналыг ойшоох.

**СОЧУВСТВУЮЩИЙ**, -ая, -ее. ойшоогч, даган баясагч, талархагч.

**СОШКА**, -и, ж. (бууны) хөл; ☆ мелкая сошка өчүүхэн хун, шальгүй амьтан.

**СОШНИК**, -а, м. анжисны хошуу.

**СОЩУРИВАТЬ**, -аю, -аешь; несов. анилгах, онилгох, жийтайлгах.

**СОЩУРИВАТЬСЯ**, -аюсь, -аешься; несов. анийх, ониих, жийтайх.

**СОЮЗ**, I, -а, м. 1. холбоо; союз рабочих и крестьян ажилчин тариачин хоёрын холбоо; 2. холбоот улс; Союз Советских Социалистических Республик Зөвлөлт Социалист (Нийгэм Журалт) Бүгд Найрамдах Холбоот Улс; 2. эвлэл; Революционный Союз Молодёжи Хувьсгалт Залуучуудын Эвлэл; 4. холбоо, эвцэл; военный союз цэргийн холбоо; заключить союз холбоо байгуулах; ☆ в союзе с кем-либо хунтэй эвсэн, нийлэн.

**СОЮЗ**, II, -а, м. холбоос үг.

**СОЮЗКА**, -и, ж. (спец.). (гутлын) хоншоор, зулаг.

**СОЮЗНИК**, -а, м. **СОЮЗНИЦА**, -ы, ж. холбоотон.

**СОЮЗНИЧЕСКИЙ** -ая, -ое. холбоотны.

**СОЮЗНО-РЕСПУБЛИКАНСКИЙ**, -ая, -ое (офиц.) холбооны бүгд найрамдах улсын; союзно-республиканское министерство холбооны бүгд найрамдах улсын яам.

**СОЮЗНЫЙ** I, -ая, -ое. 1. холбооны; союзная республика холбооны бүгд найрамдах улс; 2. үйлдвэрчний эвлэлийн; профсоюзный билет үйлдвэрчний эвлэлийн батлах; 3. холбооны, эвцлийн, холбоо байгуулсан; союзный договор холбооны гэрээ, холбоо байгуулсан гэрээ.

**СОЮЗНЫЙ** II, -ая, -ое. холбоос үгтэй;

**СОЯ**, -и, ж. буурцгана, шар буурцаг, буурцаг.

**СПАД**, -а, м. буурах, татрах, татах; спад весенних вод хавар ус татрах.

**СПАДАТЬ**, -ает; несов. буурах, татрах, татах.

**СПАЗМА**, -ы, ж. булчин татах, мушгих, булчин таталт; спазмы в желудке ходоодны булчин татах

**СПАЗМАТИЧЕСКИЙ** -ая, -ое. булчин гатах, булчин тагалтын.

**СПАИВАТЬ** I, -аю, -аешь; несов. 1. уулгах; 2. архиинд оруулах, архиин болгох.

**СПАИВАТЬ**, II, -аю, -аешь; несов. 1. гагнах; 2. гагнах, барилдлагатай болгох, бат нэгтгэх, нягтруулах.

**СПАИВАТЬСЯ**, -ается; несов. 1. гагнагдах; 2. барилдлагатай болох, бат нэгдэх, гагнагдах.

**СПАЙКА**, -а, ж. 1. гагнах; 2. гагнаас, гагнуурч. 3. наалдах, барилдах; 4. барилдлага, нягт холбоо.

**СПАЙЩИК**, -а, м. гагнуурчин.

**СПАЛИТЬ**, -лю, -лишь; -лённый (-ён, -ена); сов. хуйхлах, түлэх, шатаах.

**СПАЛЬНЫЙ**, -ая, -ое. унтах, нойрсох, унлагчин; спальный вагон унтах вагон; спальная комната унтах өрөө; спальный мешок унтах уут.

**СПАЛЬНЯ**, -и, род. мн. -лен, ж. 1. унтах өрөө, нойрсох тасалгаа, нойрсох танхим; 2. унтах өрөөний тавил.

**СПАНЬЕ**, -я, ср. унтах.

**СПАРЕННЫЙ**, -ая, -се; -рен, -рена, -рено. 1. холсолсон, холбосон, зэрэглэсэн; 2. нийлүүлсэн, хээлгүүлсэн.

**СПАРИВАНИЕ**, -я, ср. 1. хослох, хослуулах, холсох, нийлүүлэх; 2. нийлүүлэх, хээлтүүлэх, нийлүүлэг, хээлтүүлэг.

**СПАРИВАТЬ**, -аю, -аешь; несов., **СПАРИТЬ**, -рю, -ришь; -ренный сов. 1. хослох, холбох, зэрэглэх, нийлүүлэх; 2. нийлүүлэх, хээлтүүлэх, гишгүүлэх.

**СПАРИТЬСЯ**, -рюсь, -ришься; сов. нийлэх, гишгэх.

**СПАРТАКИАДА**, -ы, ж. спартакиад, наадам.

**СПАРТАНЕЦ**, -нца, м. 1. спарт хүн; 2. хатуужил, тэвчээртэй хүн.

**СПАРТАНСКИЙ**, -ая, -ое. хатуу, хатуужил, тэвчээртэй; спартанское воспитание хатуу хүмүүжил.

**СПАРХИВАТЬ**, -ает; несов. нисэх, нисэн олох; үр хийтэл нисэх.

**СПАРЫВАТЬ**, -аю, -аешь; несов. ханзлах.

**СПАСАНИЕ**, -я, ср. аврах.

**СПАСАТЕЛЬНЫЙ**, -ая, -ое. аврах; спасательный круг аврах цагариг.

**СПАСАТЬ**, -аю, -аешь; несов. аврах, ангижруулах, хэтрүүлэх, гэтэлгэх.

**СПАСАТЬСЯ** -аюсь, -аешься; несов. от кого-что. 1. амь гарах, амна аврах, ангижрах, хэлтрэх, гэтэлх. 2. аврагдах.

**СПАСЕНИЕ**, -я, ср. аврах, аврал, ангижруулах, гэтэлгэх; спасение имущества от огня эд хогшлыг галаас аврах.

**СПАСИБО**, I. частица. баярлалаа, гялайлаа, ачтай боллоо; спасибо вам танд баярлалаа; 2. частица. баярлах талархах; спасибо товарищам за по мощь нехдийн тусалсанд талархъя; 3. в знач. суц. спасибо, род. (прост.). -а, ср. талархал, талархах, баярлалаа гэх; спасибо не сказал талархлын үг, ч хэлсэнгүй, баярлалаа ч гэж хэлсэнгүй.

**СПАСИТЕЛЬ** -я, м. аврагч, гэтэлгэгч.

**СПАСИТЕЛЬНЫЙ**, -ая -ов; -лен, -льна, аврах, ангижруулах, гэтэлгэх; спасительное средство аврах арга.

**СПАСОВАТЬ**, -ую, -уешь; сов. 1. больё гэх, болих, байх; 2. худчийх, шантрах; спасовать перед трудностями бэрхшээлээс шантрах.

**СПАСТИ**, -су, -сешь; спас, спасла; -сённый (-ён, -ена); спасши; сов. кого-что. аврах, ангижруулах,



халтрүүлэх, гэтэлгэх; спасти кому-либо жизнь хүний амь аврах.

**СПАСТИТЬСЯ**, -сусь, -сёшься; *спасся, спаслась; сов.*, от кого-чего, амь гарах, амна аврах, ангижрах, хэлтрэх, гэтлэх; спасти от смерти үхлээс ангижрах, үхлээс гэтлэх.

**СПАСТЬ**, 1 и 2 л. не употр., -ёт; *спал; сов.* буурах, багасах, татрах, татах; жара спала халуун буурав; вода в реке спала голын ус татрав.

**СПАТЬ**, сплю, спишь, спал, спала, спало; *несов.* 1. унтах, нойрсох; ему хочется спать түүний нойр күрч байна; уложить спать унтуулах; спать мёртвым сном үхширтэл унтах; 2. ноомойн суух; надо было не спать, а действовать ноомойн суухгүй, ажиллах хэрэгтэй байсан юм; ☆ спать вечным сном мөнх нойрсох.

**СПАТЬСЯ**, *безл, несов.*: нойр хүрэх; не спится нойр хүрэхгүй байна.

**СПАЯННОСТЬ**, -и, *ж.* барилдлага, бат нэгдэл, нягт холбоо; спаянность коллектива хамт олны бат нэгдэл.

**СПАЯТЬ**, -яю, -яешь; *спаянный; сов.* 1. гагнах; 2. гагнах, барилдлагатай болгох, бат нэгтгэх, нягт холбох; спаять коллектив крепкой дисциплиной хамт олныг хатуу сахилгаар бат нэгтгэх.

**СПАЯТЬСЯ**, 1 и 2 л. не употр., -яется; *сов.* 1. гагнагдах; 2. барилдлагатай болох, бат нэгдэх, гагнагдах; спаяться единым фронтом против врагов мира өнх тайвны дайсныг эсэргүүцэн нэгэн фронтод бат нэгдэх.

